



Konrad
-Adenauer-
Stiftung



Эрхлэн эмхэтгэсэн Ш.Батсүх

АРДЧИЛАЛД ИРГЭДИЙН ИДЭВХИ, ОРОЛЦОО ЧУХАЛ БОЛОХ НЬ

Эрдэт шинжилгээний бага хурлын этхэтгэл

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД

КОНРАД-АДЕНАУЭР-САН



ДАНИЕЛ ШМЮКИНГ

КАС-ГИЙН МОНГОЛ ДАХЬ
СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧ

- Утас + 976 11 319 135/136
- Факс + 976 11 319 137
- daniel.schmuecking@kas.de



СЭНГЭЭГИЙН ГАНЗАЯА

ТӨСЛИЙН МЕНЕЖЕР

- Утас + 976 11 319 135/136
- Факс + 976 11 319 137
- Zaya.Sengee@kas.de

УДИРДЛАГЫН АКАДЕМИ



ШАЙРИЙН БАТСҮХ

УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН
ДЭД ЗАХИРАЛ

- Утас + 976 70132757
- Факс + 976 70133037
- sh.batsukh@naog.gov.mn



БАДНААГИЙН ГАНЦООЖ

УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН
СУДАЛГААНЫ АЖИЛТАН

- Утас + 976 70131754
- Факс + 976 70133037
- Gantsooj@naog.gov.mn



Konrad
-Adenauer-
Stiftung



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
УДИРДЛАГЫН АКАДЕМИ

Эрхлэн эмхэтгэсэн Ш.Батсүх

АРДЧИЛАЛД ИРГЭДИЙН ИДЭВХИ, ОРОЛЦОО ЧУХАЛ БОЛОХ НЬ

Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл

УЛААНБААТАР ХОТ
2015 ОН

DDC

320

Б-34

Эрхлэн эмхэтгэсэн Ш.Батсүх

АРДЧИЛАЛД ИРГЭДИЙН ИДЭВХИ, ОРОЛЦОО ЧУХАЛ БОЛОХ НЬ

© 2015 Зохиогчийн эрх хамгаалагдсан.

Энэхүү хурлын эмхэтгэлийг ХБНГУ-ын Конрад-Аденауэр-Сангийн санхүүжилтээр хэвлүүлэв.

Удирдлагын академи
Улаанбаатар – 36
Богд Жавзандамбын гудамж
Хан-Уул дүүрэг, Монгол улс
Утас: (976) 91055262
Имэйл: gantsooj@naog.gov.mn

ISBN – 978-99973-0-781-1

“Адмон принт” ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

АГУУЛГА

Өмнөх үг	4
Даниел Шмюкинг Конрад-Аденауэр-Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн Эрдэм шинжилгээний бага хурлыг нээж хэлсэн үг	5
Герхард Тийдеманн ХБНГУ-аас Монгол улсад суугаа Элчин сайдын Эрдэм шинжилгээний бага хуралд оролцогчдод хандаж хэлсэн үг	8
Ш.Батсүх Орон нутгийн түвшин дэх иргэдийн оролцоо	11
Ж.Баасандаш, Д.Цогтбаатар 1990 оны ардчилсан хувьсгалд залуусын оролцоо	32
Ц.Оюунгэрэл Ардчилал дахь эмэгтэйчүүдийн тэгш эрхийн асуудал	46
Х.Номингэрэл Ардчилалд залуучуудын оролцоо чухал болох нь	54

ӨМНӨХ ҮГ

Уншигч Танд “**Ардчилалд иргэдийн идэвхи, оролцоо чухал болох нь**” сэдвээр 2015 оны 5 дугаар сарын 07-нд Удирдлагын академи, ХБНГУ-ын Конрад-Аденауэр-Сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар хамтран зохион байгуулсан Эрдэм шинжилгээний бага хурлын материалыг эмхэтгэн хүргэж байна. Энэ бага хурлыг Конрад-Аденауэр-Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчөөр энэ оны эхээр томилогдон ирсэн доктор Даниел Шмюкинг санаачлан хамтын ажиллагаатай байгууллага, хүмүүстэйгээ уулзаж танилцан, цаашдын хамтын ажиллагаагаа ярилцах зорилгоор бидэнтэй хамтран зохион байгуулсан юм. ХБНГУ-ын Конрад-Аденауэр-Сан 2015 онд “**Ардчилалд ардчилсан үзэлтнүүд хэрэгтэй**” гэсэн уриа дэвшүүлэн ажиллаж байгаа учраас дээрх сэдвийг сонгож уг бага хурлыг зохион байгуулсан.

Эрдэм шинжилгээний бага хурлыг нээж Конрад-Аденауэр-Сангийн суурин төлөөлөгч доктор Шмюкинг, ХБНГУ-аас Монгол улсад суугаа Элчин сайд Герхард Тийдеманн нар үг хэлсэн бөгөөд хурлаар дөрвөн илтгэл хэлэлцүүлж, хуралд оролцогчдод илтгэл тус бүрийн дараа асуулт тавьж хариулт авах, санаа бодлоо илэрхийлэх боломж олгосон юм. Энэ бүхнийг эмхэтгэлд аль болох бүрэн оруулахыг зорьсон ч зарим санаа давхардсан болон илтгэлтэй шууд холбогдолгүй асуудлуудыг хэвлэх боломжгүй байсныг ойлгоно хэмээн найдаж байна.

Энэхүү бага хуралд 40-өөд байгууллагын 140 орчим төлөөлөгч оролцсон бөгөөд тэдний дотор Монгол улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат, Үндсэн хуулийн цэцийн хэд хэдэн гишүүн, ХБНГУ-аас Монгол улсад суугаа Элчин сайд Герхард Тийдеманн зэрэг нэр хүндтэй хүмүүс байснаас гадна оюутан залуус, жирийн иргэд, орон нутгийн төлөөлөл ч байлаа.

Хурлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн Удирдлагын академийн удирдлага, багш ажилтнууд болон Конрад-Аденауэр-Сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын хамт олонд талархсанаа илэрхийлье.

Доктор, профессор Ш.Батсүх



ДР. ДАНИЕЛ ШМЮКИНГ

Конрад-Аденауэр-Сангийн
Монгол дахь суурин төлөөлөгчийн
эрдэм шинжилгээний бага
хурлыг нээж хэлсэн үг

Эрхэм хүндэт Элчин сайд ноён Герхард Тийдеманн,
Эрхэм хүндэт ноён Ш.Батсүх,
Эрхэм хүндэт хурлын илтгэгчид, хуралд оролцогчид болон Конрад-Аденауэр-
Сангийн анд нөхдөө,

“Ардчилалд иргэдийн идэвхи, оролцоо чухал болох нь” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд хүрэлцэн ирсэн Та бүхэнд чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье.

Ойролцоогоор 3 сарын өмнө би Монголд ирсэн. Өнөөдрийн энэ арга хэмжээ бол миний Конрад-Аденауэр-Сангийн Монгол дахь шинэ суурин төлөөлөгч болсноос хойш оролцож байгаа анхны бага хурал юм. Миний хувьд Монголын ардчиллын цаашдын хөгжилд иргэдийн оролцооны асуудал чухал учраас улс төр дэх иргэдийн оролцооны энэ сэдвийг би зориуд сонгосон юм.

Германы алдарт зохиолч Бертолд Брехтийн хэлснээр “Улс төрд оролцдоггүй хүн бол өөрөөр нь улс төр хийхийг зөвшөөрдөг хүн” юм. Өөрөөр хэлбэл ард түмний засаглалаар тодорхойлогддог ардчиллыг ард түмэн өөрсдөө засан тохинуулан, бүтээн байгуулах ёстой.

Өнгөрсөн 25 жилд Монгол Улс ямарваа эргэлзээгүйгээр маш сайн хөгжсөн. Гадаад орчны хүнд нөхцөл байдалтай байсан тэр үед Монголын улс төрчид болон иргэд нь хамтдаа ардчиллыг сонгосон юм. Энэ шийдвэрээр Монгол Улс даван туулахаар зорьсон хэцүү бэрхшээлтэй зам эхэлсэн бөгөөд уг зам дуусах болоогүй байна. Ардчилал бол амар зүйл биш. Ардчилалд тэмцлийн болон их хөдөлмөрийн үр дүнд хүрдэг. Ардчиллыг ард иргэд бүтээдэг. Ардчилал бол оролцоо болон хамтын ажиллагааны үр дүнд оршин тогтнодог.

Монголын улс төрийн тогтолцооны цаашдын хөгжилд улс төрийн оролцоо яагаад чухал болохыг би гурван зүйлээр тайлбарлая. Үүнд:

1. Дарангуйллын буюу захиран тушаах засаглалын тогтолцоотой харьцуулбал ардчилал нь иргэддээ эрх чөлөө олгодог боловч улс төрд оролцох шаардлага тавьдаг. Энэ нь сонгуульд оролцох, иргэдийн идэвхи гаргах, нэрээ дэвшүүлэх, намд элсэх, улс төрийн үйл ажиллагаа явуулах гэх мэт. Иргэд идэвхи чармайлт гаргахгүй бол ардчилал хүнд бэрх асуудалтай тулгардаг. Монголын улс төрийн намууд болон улс төрчид нь нэр хүнд муутай байдгийг би мэднэ. Үүнийг Сант Марал сангийн сүүлийн үеийн судалгаа баталж байна. Нөгөө талаас Монголын иргэн бүрд улс төрд оролцох эрх, боломж байдаг тул улс төрчдийн талаар гомдоллохын оронд улс төрийн идэвхи гарган өөрийн үнэт зүйл болон ардчиллын ойлголтыг түгээн үр дүн гаргах ёстой.
2. Ардчиллын чухал элемент болох хяналт ба харилцан тэнцвэртэй байдал буюу англи хэлээр “Checks and Balances” гэх нөхцөл байдал нь зөвхөн хүчирхэг болон хараат бус засгийн газрын эсрэг сөргөлдөгч нар бүрэлдсэнээр хэрэгжих болно. Уг сөргөлдөгчдийн үүргийг шүүмжлэх чадвартай хэвлэл мэдээлэл, идэвхтэй иргэний нийгэм, парламентын дотоод буюу гадна талын сөрөг хүчин, ардчилсан бүтэцтэй намууд гэх мэт оролцогчид гүйцэтгэдэг. Намуудын гишүүд удирдлагаа сонгох болон хариуцлага тооцох боломжтой байх ёстой. Үүнээс гадна гишүүд нь намын зорилгын агуулгын талаар мэтгэлцэх буюу саналаа хураах эрхтэй байх ёстой. Намууд бол өдөр тутмын улс төрийн үйл ажиллагаанаас гадуур алсын хараатай үзэл бодлын чиглэл болон үнэт зүйлийн үндэстэй байх ёстой. Миний ойлголтоор намын дотоод ардчилал нь Монголын ардчиллын хөгжлийн хамгийн чухал шат нь юм. Үүнд гишүүдийн бодит эрх болон үүргийг тусгасан намын ил тод үйл ажиллагааны дүрэм гол нөлөө үзүүлэх болно.
3. Ардчилсан системд парламент ард түмнийг төлөөлөх үүрэгтэй. Шилдэг ардчилсан системд парламентын гишүүд нийгмийн олон төрлийн бүтцийг төлөөлдөг юм. Монгол Улсын хувьд Улсын Их Хуралд эмэгтэйчүүд, малчид болон залуучуудыг төлөөлсөн гишүүд хангалттай байх ёстой. Ухаалаг хуулиудыг зөвхөн нийгмийн олон бүлгийн төлөөллийн хэлэлцүүлгийн үр дүнд баталдаг юм. Уг үйл ажиллагаа нь зөвхөн дээр дурдсан бүлгүүд улс төрд оролцсоноор бүтэх болно. Ийм учраас ирэх оны УИХ-ын сонгуулийн үр дүнгээр эмэгтэйчүүд, малчид болон залуучуудыг олноор төлөөлсөн гишүүд сонгогдвол би их баярлах болно. Манай Конрад-Аденауэр-Сангийн зүгээс үүнийг дэмжихэд бэлэн байна.

Миний зүрх сэтгэлд энэ сэдэв ойр байгааг Та бүхэн анзаарсан байх. Конрад-Аденауэр-Сан Монголын ардчилалд 1993 оноос хойш дэмжлэг үзүүлж байгаа. Ардчиллын хөгжлийн бүх үе шат өөрийн сорилтой байсан. Бид төрийн байгуулалт, эрх зүйт төр, чөлөөт хэвлэл мэдээллийг байгуулахаас авахуулаад улс төрчдийн сургалт хүртэл Монголын ардчилалд үнэнч болоод шүүмжлэлтэй хандаж ирсэн түнш нь байсан ба ийм байсаар байх болно. Нээлттэй үг хэлэх нь үүнд их чухал юм. Зөвхөн нээлттэй, шударга хэлэлцээний аргаар асуудлаа шийдвэрлэх боломж гардаг. Монголд гурван сар болсны дараа би энэ тал дээр санаа зовохгүй байна.

Монголчуудын элэгсэг дотно байдлаас гадна их нээлттэй байдгийг би анзаарсан. Үүнд би их талархдаг. Ийм учраас би өөрт оногдсон үүргийн дагуу Та бүхэнтэй хамтран ажиллах болсондоо баяртай байна. Өнөөдрийн бага хурлаар шүүмжлэлтэй бөгөөд үр дүнтэй хэлэлцүүлэг өрнүүлнэ гэж найдаж байна.

Өнөөдрийн бага хуралд сонирхолтой сэдвээр илтгэл тавих хүндэт оролцогчид Монголын ардчиллыг шүүмжлэлтэй дэмжиж ирсэн Конрад-Аденауэр-Сангийн түншүүд юм. Улс төрийн оролцоо янз бүрийн түвшинд явагдаж байна. Үүнийг өөр өөр албан тушаалд ажилладаг манай илтгэгчид өөрсдийн салбарын асуудлаар ярьж байгаагаас харж болох юм.

Удирдлагын академийн дэд захирал доктор, профессор Ш.Батсүх Орон нутгийн төвшин дэх иргэдийн оролцооны талаар илтгэх болно. АНУ-ын Төлөөлөгчдийн танхимын дарга асан Тир О'Нейл "Бүх улс төрийн асуудал нь орон нутагт хамаардаг юм" гэж хэлсэн байдаг. Өөрөөр хэлбэл тухайн орон нутгаас гарсан улс төрч нутгийнхаа иргэдийн ашиг сонирхлыг илүү сайн мэддэг юм. Харин орон нутгийн иргэдэд улс төрд оролцох урам зориг өгөх нь чухал асуудал болж байна.

Монголын Улс төрийн хэлмэгдэгсдийн холбооны тэргүүн Д.Цогтбаатар өнөөгийн ардчилалд өнгөрсөн үеийг үнэлж дүгнэхийн ач холбогдлын талаар илтгэх болно. Өөрийн түүхээ мэдсэнээр ирээдүйгээ бүтээж болдог юм. Зөвхөн өнгөрсөн алдаагаа мэдэж байж түүнээс ирээдүйд зайлсхийж чадна.

Өөрчлөлтийн Төлөөх Залуу Эмэгтэйчүүд ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн, хатагтай Номингэрэл "Залуучуудын оролцоо чухал болох нь" сэдвээр илтгэнэ. Ардчилал өөрийгөө байнга шинэчлэх чадвартай байх ёстой. Үүнд залуучуудыг болон тэдний санаачилгыг дэмжих нь их чухал юм. Монгол Улс бол залуу улс хэдий ч харамсалтай нь УИХ-ын бүрэлдэхүүн үүнийг илэрхийлж чадахгүй байна.

УИХ-ын гишүүн, АН-ын дэргэдэх Монголын Ардчилсан Эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн, хатагтай Ц.Оюунгэрэл төгсгөлд нь ардчилал дахь эмэгтэйчүүдийн тэгш эрхийн асуудлаар илтгэх юм. Бид ирэх жилийн сонгуулиар УИХ илүү олон эмэгтэй гишүүдтэй болох зорилго тавин хамтран ажиллаж байгаа. Уг зорилго маань хэрхэн бүтэхийг харж, сонирхож байна.

Өнөөдрийн бага хуралд сонирхолтой илтгэлүүд тавигдах болно. Бага хурлыг идэвхи санаачилга гарган зохион байгуулсан Др. проф. Ш.Батсүхэд, Удирдлагын академийн болон манай Конрад-Аденауэр-Сангийн хамт олонд чин сэтгэлийн талархлаа илэрхийлье.

Үүгээр бага хурал нээснийг мэдэгдье. Би хувьдаа сонирхолтой илтгэлүүдийг сонсож, өргөн хүрээтэй хэлэлцүүлэг өрнүүлнэ хэмээн найдаж байна.



ГЕРХАРД ТИЙДЕМАНН

**ХБНГУ-аас Монгол улсад
суугаа Элчин сайдын Эрдэм
шинжилгээний бага хуралд
оролцогчдод хандаж хэлсэн үг**

Эрхэм хүндэт хатагтай, ноёд оо!

Би энд олон сайн танилуудаа байгааг харж байна. Тэднийг би нэг бүрчлэн нэрлэх бололцоогүй байна. Өнөөдөр би Конрад-Аденауэр-Сан болон Удирдлагын академийн зочин болж энэ үйл ажиллагаанд оролцож байгаадаа баяртай байна. Хуульч хүний хувьд Шпайэрийн Их сургууль, Холбооны улсын Удирдлагын академи бол миний боловсролын нэгээхэн хэсэг болохыг хэлэхэд таатай байна.

Миний улс төр, нийгмийн боловсролын гол түнш бол Конрад-Аденауэр-Сан юм. Конрад-Аденауэр-Сангийн тухай би дэлгэрэнгүй ярих болно. Хамтарч шийдэж, хамтарч оролцдоггүй иргэдгүйгээр ардчиллыг төсөөлөх аргагүй юм. Үүнээс үзвэл төр нь идэвхитэй хамтран ажилладаг ардчилсан үзэлтэй иргэдгүйгээр ажиллах бололцоогүй гэж үзэж болохоор байна. Энэ нь практикт хэрхэн хэрэгжихийг Та бүхэн дараа дараагийн хэлэлцүүлгээс илүү нарийвчилан тодорхой мэдэх боломжтой. Ардчиллыг төлөвшүүлэхэд ардчилсан нийгмийн үнэт зүйлээс гадна ардчилсан үзэлтэй иргэдийн идэвхитэй оролцоо, иргэдийн дэмжлэг шаардлагатай байдаг.

ХБНГУ-ын Үндсэн хууль болон Монгол улсын Үндсэн хуулийн хүрээнд дэх иргэдийн оролцооны зохицуулалтаас гадна улс төрийн намууд чухал үүрэгтэй. Улс төрийн нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг нэгтгэн тодорхойлохын зэрэгцээ парламент (УИХ)-д төлөөлөн сонгогдож, хууль баталж, үүгээр уламжлан Засгийн газрын үйл ажиллагаанд оролцож хэрэгжүүлдэг.

Би өөрийнхөө улс төрийн боловсролыг эргэж дурсвал улс төрийн амьдралд оролцохоос өмнө улс төрийн үзэл бодол төлөвших үйл явц эхэлсэн байдаг. Доктор Шмюкингийн хэлсэн АНУ-ын ишлэлээс харвал хүн өсвөр насны болон сургуулийн боловсролоор дамжуулан төлөвшдөг байна. Би эхлээд өсвөр насны залуусын хөдөлгөөн “Хөх цэрэг” аянд идэвхитэй оролцдог байсан. Энэ бол улс төрийн байгууллага биш хэдий ч би тэнд бүлгийн болон семинарын ажил, олон нийтийн ажлыг яаж зохион байгуулахыг сурахын зэрэгцээ энэ үеэс л улс төртэй холбогдож эхэлсэн юм.

Энэ ажлыг хийж байгаа хүн орон нутгийн улс төрчидтэй холбоо тогтоохоос өөр аргагүй болдог. Ардчилсан замаар төлөвшсөн хүмүүс, улс төрийн идэвхитэй хүмүүс юуны түрүүнд суралцах хэрэгтэй гэдэг нь ойлгомжтой. Мэргэшихийн тулд болон хариуцлага хүлээх үүднээс сургалтыг санал болгох хэрэгтэй болдог. Германд үүнд зориулсан тусгай байгууллагууд байдаг. Жишээлбэл, Монголд төлөөлөгчийн газар нь ажилладаг Фрийдрих-Эбертийн-Сан, Ханс-Зайдалын-Сан, Конрад-Аденауэр-Сан зэрэг улс төрийн сангуудыг нэрлэж болно. Улс төрийн сангуудаас зохион байгуулсан семинаруудад оролцсоноор улс төрийн тодорхой арга хэрэгслүүдийг эзэмшдэг явдал нь ихээхэн тус болсон гэж би боддог. Энэхүү сургалт, семинаруудад оролцсоноор олон нийтийн ажилд идэвхитэй оролцоход тус болсон. Тухайлбал, орон нутагт усанд сэлэлтийн газар байгуулах, замын хөдөлгөөний аюулгүй байдалд саад болж буй модыг зайлуулах зэрэг ажлыг зохион байгуулахад ач холбогдолоо өгсөн. Тэр үед олон хэлэлцүүлэг, ярилцлагуудын үр дүнд өөрийн удирдлага бүхий залуучуудын төвийг байгуулж байлаа. Намайг залуу байхад залуучуудын зүгээс хүсэж байсан зүйлийн нэг нь ийм төвүүдийг олноор байгуулах явдал байсан.

Ийнхүү миний өсвөр насны нийгмийн идэвхи ардчилал, ардчилалд иргэдийн оролцоо байх ёстойг ойлгосон явдал юм. Үүнд та, би, бид бүгдээрээ хамааралтай байдаг бөгөөд зөвхөн ХБНГУ гэлтгүй Монгол улсад ч залуусын улс төрийн боловсрол чухал. Хүмүүс зөвхөн өөрийнхөө үндсэн сонирхлыг бодохоосоо илүүтэйгээр нийгмийн ашиг сонирхлыг бүхэлд нь харж өөрийн орон нутаг, багийн хүрээнд эсвэл улсынхаа хэмжээнд төлөөлөх явдал юм. Энэ үйл явц Улаанбаатарт улс төрийн үйл ажиллагаанд оролцохоос эхлэн УИХ, Засгийн газарт төлөөлөх хүртэлх үйл явц юм.

Харамсалтай нь бид улс төрийн хүрээнд зарим нэгэн удааширлыг харж байна. Улс төрийн намуудын ардчилал гэдэг тийм хялбар зүйл бишээ. Үүнд ХБНГУ гэлтгүй Монгол улсад ч, өөр бусад ардчилсан орнуудад ч ялгаагүй иргэдийн идэвхитэй оролцоо хэрэгтэй. Энэ нь магадгүй арван жилийн өмнө хялбар байсан ч өнөөдөр хэцүү байж ч болох юм. Учир нь бидэнд хөндлөнгөөс нөлөөлж буй хүчин зүйл их болсон. Нийгэм маань хэрэглээ талруугаа хэт хазайсан тул, эсвэл нийгмийн олон асуудлууд, ажилгүйдэл их байгаа нь иргэдийн хувьд улс төрийн асуудлаас өөрийгөө татахад хүргэдэг. Гэсэн хэдий ч ардчилал нь ардчилсан үзэлтэй идэвхитэй иргэдийн оролцоогүйгээр хөгжих боломжгүй юм. Сүүлийн үед иргэд үйлдвэрчний эвлэл болон сайн дурын байгууллагууд, улс төрийн намууд, төрийн бус байгууллагуудад оролцох оролцоо буурсан гэж гомдоллох болсон. Энэ нь XXI зууны дэлхий нийтийг хамарсан асуудал болж байх шиг байна. Та бүхэн надаас энэ асуудлыг шийдэх талаар бэлэн жор шаардахгүй байх гэж найдаж байна. Тийм бэлэн жор ч байхгүй байх гэж би бодож байна. Гэхдээ бид олон хүмүүсийг идэвхижүүлж чадвал энэ нь зөв алхам болно. Бид өнөөдрийн бага хурлаас иргэдийг төр, нийгмийн хэрэгт хэрхэн оролцуулах талаар олон санаа олж авч чадна гэдэгт найдаж байна.

ХБНГУ-аас Монгол улсад суугаа Элчин сайдын хувьд юуны түрүүнд 2015 онд 25 жилийн гурван ой давхцаж байгааг дурьдмаар байна. Яагаад би гурван ой гэж байгаа вэ гэвэл ХБНГУ, Монгол улсад эвийн замаар ардчиллыг бий болгосон 25 жилийн ойгоо тус бүр тэмдэглэж байгаа. Бидний үнэлэмж нэг ижил, тийм ч учраас энэхүү шилжилтийн хүнд үеийг энхийн жагсаал цуглаанаар бий болгоно

гэдэг тийм амар байгаагүй. 1989, 1990 онд ардчиллыг бид тийм амар, хурдан авчраагүй гэдгийг хэлмээр байна. Гэхдээ энэхүү шилжилт маань маш амжилттай хэрэгжиж эхэлсэн, гагцхүү дуусаагүй байгаа. Том улс төр бол шилжилтийн энэ урт хугацаанд иргэдийнхээ дуу хоолой, санаа бодлыг сонсох нь чухал. Тийм ч учраас иргэдийгээ идэвхтэй оролцуулах нь зайлшгүй чухал юм. Тэгээд 25 жилийн гурав дахь ойгоо би энд дурьдмаар байна. Ардчилсан нийгмийг ХБНГУ болон Монгол улсад бий болгосон гэдгийг би өмнө хэллээ. Гурав дахь 25 жилийн ой бол ХБНГУ-ын Элчин сайдын яам Монгол улсад нээгдсэний 25 жилийн ой юм. Хуучин Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсын элчин сайдын яамыг ХБНГУ хүлээн авсан явдал юм. Энэ бол дэлхийд давтагдашгүй цорын ганц жишээ гэж хэлмээр байна. Яагаад гэвэл Монгол улсад ХБНГУ-ын Элчин сайдын яам байгаагүй, харин бусад орнуудад хоёр Германы Элчин сайдын яам байсан. Энд бид БНАГУ-ын Элчин сайдын яамыг тэр дор нь хүлээн авсан юм. Тухайлбал, Токио, Москвад бид БНАГУ-ын Элчин сайдын яамыг хаасан. Тиймээс энэ бол онцгой тохиолдол байсан юм. Яагаад үүнийг би Элчин сайдын хувьд онцолж хэлж байна вэ гэхээр БНАГУ-ын Элчин сайдын яамыг ХБНГУ-ын Элчин сайдын яам шууд хүлээж авсаныг онцлон хэлж байгаа юм.

Та бүхэнд өнөөдрийн энэ арга хэмжээнд өндөр амжилт хүсье. Би энэ боломжийг ашиглаж ноён доктор Шмюкингд Монгол улсад Кондар-Аденауэр-Сангийн төлөөлөгчөөр ажиллахад нь хамгийн сайн сайхныг хүсье.

Та бүхнийг улс төр дэх иргэдийн оролцооны олон асуудлаар үр дүнтэй хэлэлцүүлэг өрнүүлнэ гэдэгт найдаж байна. Энэ нь ардчилалд туйлаас чухал юм. Төгсгөлд нь Монгол улсад иргэд, улс төрчид бие биенээ илүү сайн сонсож, хамтарч ажиллаасай гэж би хүсэж байна. Ингэсэн цагт л ардчилалын суурь бэхжиж улам өргөжих болно.



ОРОН НУТГИЙН ТҮВШИН ДЭХ ИРГЭДИЙН ОРОЛЦОО

*Доктор, профессор Ш.Батсүх
Удирдлагын акадегийн дэд захирал*

Оршил

Орон нутгийн түвшинд шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хангах нь ардчиллыг хөгжүүлэх, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчныг тэдний оролцоотой бий болгох, иргэдийн идэвхи санаачилгыг дэмжих, төрд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой юм. Тиймээс иргэдийн оролцоонд анхаарал хандуулж зүй зохистой хөгжүүлэх нь ардчиллын үндэс суурийг бэхжүүлж, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чухал үүрэг гүйцэтгэх болно.

Манай улс 1990 онд ардчилсан хөгжлийн замыг сонгож 1992 онд шинэ Үндсэн хуулиа батлахдаа Ром-Германы эрх зүйд үндэслэсэн байдаг. Энэ үүднээс Европын орнууд, түүний дотор ХБНГУ-аас суралцах зүйл бидэнд их бий. Өнөөдрийн энэ эрдэм шинжилгээний бага хурлаар хэлэлцэж буй “Иргэдийн оролцоо”-ны асуудлаар ч Европын улсуудаас суралцах зүйл бидэнд их байна.

Би энэ илтгэлдээ “Орон нутгийн түвшин дэх иргэдийн оролцоо” ХБНГУ-д хөгжлийн ямар үе шатыг туулж, хэтийн төлөв нь ямар байгаа, манай оронд бидний хийсэн судалгаагаар байдал ямар байгаа, цаашид юу хийх хэрэгтэй байгаа талаар голлон ярих болно.

Энэ талаар ярихын өмнө шууд ардчилал-иргэдийн оролцоо сүүлийн жилүүдэд яагаад ингэж их анхаарал татах болов, иргэдийн оролцоо гэж чухам юу вэ гэдгийг товч авч үзье.

Шууд ардчилал, иргэдийн оролцооны асуудал сүүлийн жилүүдэд ихээхэн яригдах болсон нь *нэгдүгээрт* засаглалын үзэл баримтлалын хүрээнд оролцоог чухалчилдагтай, *хоёрдугаарт* иргэдийн олонхи улс төрийн намууд болон улс төрчдийн гаргаж буй улс төрийн шийдвэрт сэтгэл хангалуун бус байдагтай, *гуравдугаарт* иргэдийг төлөөлж бүх түвшинд мандат авсан улс төрчид ихэнх тохиолдолд иргэдийг бүрэн төлөөлж чадахгүй байна гэж үзэж буйтай холбоотой юм. Шууд ардчилал, иргэдийн оролцоо нь төлөөллийн ардчилалд суурилсан өнөөгийн улс төрийн тогтолцоог халах буюу орлох гэхээсээ илүү түүний сул тал,

дутагдлыг засаж залруулах зорилготой. Түүнээс гадна “Олны хүч оломгүй далай” гэдэг шиг нийгэмд байгаа идэвхитэй иргэдийн асар их хүч нөөцийг ашиглах тухай асуудал юм.

Шууд ардчиллыг дараах хоёр утгаар ойлгодог¹. *Нэгдүгээрт*, ард нийтийн санал асуулгад тулгуурлан эрх мэдлийг шууд ард түмэн хэрэгжүүлдэг нийгмийн зохион байгуулалтын хэлбэр, *хоёрдугаарт*, иргэдийн оролцоотойгоор шийдвэр гаргадаг улс төрийн арга гэж үздэг. Иргэдийн оролцоотой шийдвэр гаргадаг энэ арга нь төлөөллийн ардчиллын тогтолцооны нэг хэсэг байж болдог. Бид энд иргэдийн оролцоог хоёрдахь утгаар нь авч үзэж байна.

Иргэдийн оролцоо гэж улс төрийн шийдвэр гаргах үйл явц болон томоохон төсөл, хөтөлбөрүүдийг төлөвлөх явцад иргэдийг оролцуулахыг хэлдэг. Иргэдийн оролцоо бол хүн төрлхтний түүхийн явцад хамтын ажиллагааны зохион байгуулалтын дээд хэлбэрт хүрэх гэсэн байнгын тэмүүлэл юм². Зарим оронд төсвийн төлөвлөлт хийхэд иргэдийг өргөнөөр оролцуулдаг болсон байна. Манай оронд 2012 оноос “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн төлөвлөлтөд иргэд оролцох боломж нээгдсэн³.

Иргэдийн оролцооны тухай ойлголт өнөөг хүртэл нэг мөр болоогүй байна. Тухайлбал, шууд ардчиллын чухал илэрхийлэл болох “Ард нийтийн санал асуулга”-ыг иргэдийн оролцооны хэлбэр гэж үзэх үү, үгүй юу гэдэг асуудлаар судлаачид санал зөрдөг. Ер нь иргэдийн оролцооны их олон арга хэлбэр бий. Тухайлбал, иргэд улс төрийн сонгуульд саналаа өгөх, жагсаал цуглаанд оролцох, тодорхой асуудлаар гарын үсэг цуглуулах гэх мэт олон арга хэлбэрээр шийдвэр гаргахад оролцож болдог. Бидний энд авч үзэж буй иргэдийн оролцооны асуудал бол засаг захиргааны байгууллагууд шийдвэр гаргах, төлөвлөх, хяналт тавих зэрэг үйл ажиллагаандаа иргэдийг зориуд зохион байгуулалттайгаар оролцуулж тэдэнд мэдээлэл өгөх, саналыг нь сонсох, асуудлыг хамтран хэлэлцэх тухай юм. Орон нутгийн бүх шатны хурлын болон засаг захиргааны байгууллагууд үйл ажиллагаагаа нээлттэй, ил тод, хяналттай явуулахад иргэдийн оролцоо чухал байдаг. Түүнээс гадна иргэдийг асуудал шийдэхэд оролцуулснаар иргэд идэвхижиж өөрөө өөрийнхөө төлөө, оршин суугаа нутгийнхаа хөгжлийн төлөө санаачилга гарган ажиллах боломж олдоно. Ингэж идэвхи санаачилгатай иргэдийг дайчлан зарим асуудлыг тэдний оролцоо, дэмжлэг туслалцаатайгаар шийдсэнээр захиргааны байгууллагын зардал буурч, ажлын ачаалал ихээхэн багасах боломж ч бүрддэг байна.

Гадаадын зарим улсуудад тухайлбал, Европын Холбооны улсуудад иргэдийн оролцоо явцуу утгаараа зөвхөн орон нутгийн түвшинд л хэрэглэгддэг байна. Манай улсад ч гэсэн Үндсэн хуулиндаа зөвхөн баг, хорооны түвшинд шууд ардчиллын хэлбэрээр, иргэдийн шууд оролцоотойгоор асуудлыг шийдэхээр зохицуулж өгсөн байдаг. Харин бусад түвшинд төлөөллийн ардчиллын зарчмаар асуудлыг шийдэхээр хуульчилсан. Гэсэн хэдий ч дээр дурдсанчлан сүүлийн жилүүдэд гадаадын олон оронд төдийгүй манай оронд ч иргэдийн оролцоог бүхий л түвшинд нэмэгдүүлэх хүсэл эрмэлзлэл бий болжээ.

1 Энэ талаар http://de.wikipedia.org/wiki/Direkte_Demokratie хаягаар орж дэлгэрэнгүй үзнэ үү (2014 оны 11 дүгээр сарын 19-ний 17 цаг 47 минутад хандсан хандалт).

2 Martin A. Novak, Five rules for the evolution of cooperation. In Science. 314. Nr. 5805, 2006-12-08, p. 1560-1563, PMC 3279745 (<http://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC3279745/>), мөн <http://www.forschungsstelle-direkte-demokratie.de/>.

3 “Төсвийн тухай” Монгол Улсын хууль, 2011 он.

ХБНГУ-ын орон нутгийн түвшин дэх иргэдийн оролцоо, хөгжлийн хандлага

ХБНГУ-ын орон нутгийн түвшин дэх иргэдийн оролцоо хоёр үе шатыг дамжин хөгжиж иржээ⁴. Үүнд:

1. *“Иргэдийн оролцооны хувьсгал” гэж нэрлэгддэг эхний үе шат*

ХБНГУ-д орон нутгийн түвшин дэх иргэдийн оролцоог хэдэн арван жилийн өмнөөс л төлөөллийн ардчиллын олон төвөгтэй асуудлуудыг шийдвэрлэх хамгийн тохиромжтой хэрэгсэл гэж үзсээр ирсэн байна. Гэхдээ энэ асуудлыг практик амьдралд янз янзаар ойлгож хэрэглэж ирсэн түүхтэй. Өнгөрсөн зууны 60-аад оны сүүлчээр хувсгалын шинжтэй бослого тэмцэл, иргэдийн санаачлагын олон хэлбэрийн хөдөлгөөнүүд бий болсон. Энэ бүхэн бол иргэдийн үнэт зүйлс өөрчлөгдөж өөрсдийнхөө амьдралын нөхцлийг өөрсдийн идэвхитэй оролцоотойгоор шийдвэрлэх гэсэн хүсэл эрмэлзлэл давамгайлах болсонтой холбоотой байлаа. Иргэдийн оролцооны хувьсгалын шинжтэй энэ хөдөлгөөн 1980-аад онд бүрэн зогссон байна.

2. *Иргэдийн оролцооны хоёр дахь үе шат нь 1992 оны Рио-де Жанейрогийн дэлхийн дээд хэтжээний уулзалтын үр дүнтэй холбоотой хөгжсөн*

Рио-де Жанейро хотноо 1992 онд зохион байгуулсан “Байгаль орчин, хөгжил” НҮБ-ын бага хурал орон нутгийн засаг захиргааны байгууллагуудыг иргэдийн оролцоотой “Тогтвортой хөгжлийн стратеги” боловсруулах санаачилга гаргасан. Энэ санаачлага нь иргэдийн оролцооны гурван янзын хөгжлийг бий болгосон байна. Үүнд:

1. Хот тосгоны дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулах замаар иргэдийн шаардлага, иргэдийн шийдвэр гаргах боломжийг нээж өгсөн.
2. Орон нутгийн засаг захиргааны байгууллагын өөрсдийнх нь санаачлагаар иргэдийн оролцоотой төсөв зохиох боломжийг бий болгосон.
3. Иргэдийн оролцооны олон тооны арга хэрэгсэлүүдийг туршиж хэрэглэх, шинээр боловсруулах ажлыг хийж эхэлсэн. Энэ оролдлого өнөөдөр ч гэсэн үргэлжилсээр байна.

Энэ бүхэн нь идэвхитэй иргэдийн тусламжтайгаар ардчиллыг хөгжүүлж, иргэдийг идэвхижүүлж буй сайн хэлбэр хэдий ч төлөөллийн ардчиллын хүчийг сулруулж, легитим шинжийг алдагдуулах аюултай байж болохыг анхаарах хэрэгтэй гэж үзэж байна. Түүнээс гадна орон нутгийн засаг захиргааны байгууллага, иргэдийн хооронд болон иргэдийн дунд маргаан, зөрчил үүсэх асуудал ч гарч болно.

Иргэдийн оролцоог ардчиллыг хөгжүүлэх нэг боломжит хувилбар гэж үзэж дэмжиж байна.

ХБНГУ-д орон нутгийн түвшин дэх иргэдийн оролцоог цааш хөгжүүлэхэд дараах чиглэлээр анхаарч ажиллаж байна. Үүнд:

1. Иргэдийн оролцоог баталгаатай хангах дүрэм журмуудыг бий болгох замаар энэ асуудлыг институтчилах чиглэл барьж байна. Энэ хүрээнд мөн иргэдийн оролцооны ойлголтыг шинэ түвшинд гаргах оролдлого хийж байна.

4 Helmut Klages (2014). Entwicklungsperspektiven der Buergerbeteiligung auf kommunaler Ebene. In eNewsletter Netzwerk Buergerbeteiligung 01/2014

2. Орон нутгийн улс төрчид, засаг захиргааны ажилтнууд, иргэд хоорондын хамтын ажиллагаанд ихээхэн ач холбогдол өгч байна. Эдгээр бүлэг хүмүүс асуудлыг шийдэхдээ аль болох зөвшилцөлд хүрэх боломжийг эрж хайх шаардлага гарч байгаа юм байна.
3. Оролцогч талууд хамтарч ажиллах боломж бүрдүүлэх үүднээс нутгийн захиргааны байгууллагууд аль болох нээлттэй байж, оролцогч талуудыг мэдээллээр хангах шаардлага бий болно. Ялангуяа иргэд аль асуудалд илүү оролцох шаардлага байна вэ гэдгээ сонгож шийдэх боломж бий болгож өгөх хэрэгтэй.
4. Дараагийн чухал чиглэл бол иргэдийн оролцоог үйл явц гэж үзэж захиргааны байгууллагын зүгээс үйл ажиллагаагаа үүнд чиглүүлж өөрчлөх хэрэгтэй болж байна. Тухайлбал, иргэд тодорхой асуудлаар аль болох эрт мэдээлэлтэй болж үйл явцад оролцох боломжийг бүрдүүлэх шаардлага гарна. Тийм учраас энд цаг хугацааны төлөвлөлт чухал болж ирнэ.

Иргэдийн оролцоог хөгжүүлэхэд тулгамдаж буй олон асуудал байна гэж үзэж байна. Тухайлбал, хүмүүсийн хоорондын харилцаанд сэтгэлгээний ялгаа, мэргэжлийн нэр томъёо жирийн иргэдэд ойлгомжгүй байдаг зэрэг бэрхшээл байна. Мөн иргэд, захиргааны байгууллагын ажилтнууд үл итгэлцэх байдлыг арилгаж харилцан бие биедээ итгэдэг соёлд суралцах шаардлага гарч байна. Дараагийн нэг чухал асуудал бол аль болох бүх иргэдийг оролцуулах чиглэл барих хэрэгтэй болно. Энэ бол тийм амар асуудал биш.

Эцэст нь иргэдийн оролцоо, төлөөллийн ардчилал хоёр хоорондоо зөрчилдөх, иргэдийн оролцоо төлөөллийн ардчиллын хүчийг сулруулах, үгүйсгэх асуудал үүсч болох юм гэсэн болгоомжлол байгаа тухай дурдсан байна.

Монгол улсын орон нутгийн түвшин дэх иргэдийн оролцоо, хөгжлийн хандлага

Манай улсад 1992 онд шинэ Үндсэн хууль батлагдсанаар шууд ардчилал, иргэний оролцооны асуудал шинэ шатанд тавигдсан гэж үзэж болно. Үндсэн хуульд “Монгол улсад засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ⁵”, Монгол улсын иргэн “Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй⁶” гэсэн шууд ардчилалын суурь зарчмууд тусгагдсан байдаг.

Мөн “Ард нийтийн санал асуулга” явуулах тухай заалт ч бий. Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонхи нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож олонхийн санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ⁷ гэж манай Үндсэн хуульд байгаа нь шууд ардчилалын хамгийн дээд хэлбэр болох ард нийтийн санал асуулга буюу референдумийг Үндэсний хэмжээнд явуулахыг хүлээн зөвшөөрсөн орон юм. Үүнийгээ ч амьдралд бодитой хэрэгжүүлэхийн тулд Ард нийтийн санал асуулгын тухай хуулийг батлан гаргасан байна.

5 Монгол улсын Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн 1 дэх заалт

6 Монгол улсын Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 9 дэх заалт

7 Монгол улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 16 дахь заалт

1995 оны 10 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан “Ард нийтийн санал асуулгын тухай” хуулийн зорилт нь ард нийтийн санал асуулга явуулах зарчим, журмыг тодорхойлж, санал асуулгыг бэлтгэн зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулах явдал юм. Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн зарчмаар Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд оролцож, санал асуулгаар шийдвэрлэх асуудлын талаар саналаа нууцаар гаргах, санал асуулга авах өдөр эх орондоо байгаа 18 нас хүрсэн Монгол улсын иргэн үндэс угсаа, хэл, арьс өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаварлахгүйгээр санал асуулгад оролцож саналаа өгөх эрхтэй юм. Гэвч ард нийтийн санал асуулга хийх санаачлага нь иргэдээсээ биш, харин хууль санаачлагч эрх бүхий субъектүүд (УИХ, УИХ-ын гишүүд, Засгийн газар, Ерөнхийлөгч)-ийн зүгээс гарахаар хуульчлагдсан байна. Хэдийгээр иргэн хүн ард нийтийн санал асуулгаар шийдвэрлэх асуудлыг хөндөж тавьж болох боловч түүнийгээ зөвхөн хууль санаачлагчаар дамжуулах ёстой. Иймд ард нийтийн санал асуулгаар асуудал шийдвэрлэх санаачлагыг тодорхой тооны иргэд (тухайн үед сонгуулийн насанд хүрсэн нийт иргэдийг төлөөлж болох зохистой тооны иргэдийг түүвэрлэх замаар тогтоож болох юм) гаргах боломжийг уг хуульд нэмж оруулсан тохиолдолд ардчилал өндөр хөгжсөн орнуудтай нэгэн адил иргэдийн санаачлагаар реферэндум явуулах бололцоо бүрдэнэ.

Үүнээс гадна манай Үндсэн хуулинд шууд ардчилалын бас нэгэн чухал хэлбэр болох Иргэдийн Нийтийн Хурлыг хүлээн зөвшөөрч хуульчлан тусгажээ. Энэ нь “Нутгийн өөрөө удирдах байгууллага бол ... баг, хороонд Иргэдийн Нийтийн Хурал, тухайн хуралдааны чөлөө цагт түүний тэргүүлэгчид мөн”⁸ гэсэн Үндсэн хуулийн заалт юм. Баг, хорооны түвшинд өөрөө удирдах байгууллага нь нэгэнт Иргэдийн Нийтийн Хурал учраас Үндсэн хуулийн заалтын дагуу баг, хорооны “нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлаа бие даан шийдвэрлэх” бодит эрхтэй бөгөөд түүний “Эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно”⁹ гэсэн Үндсэн хуулийн заалттай. Энэ заалтын дагуу эдүгээ ч манай улсын баг, хороодын түвшинд иргэдийн нийтийн хурлаараа өөртөө холбогдол бүхий асуудлуудыг хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд шийдвэрлэж байгаа нь шууд ардчиллын бодит илрэл юм.

Олон улсын практикт хэрэглэгддэг шууд ардчиллын түгээмэл хэлбэрүүдийн нэг нь орон нутгийн түвшний асуудлыг тухайн орон нутгийн иргэд шууд санал хураалтаар шийдвэрлэдэг шууд ардчиллын гурав дахь хэлбэр буюу орон нутгийн реферэндумын хуультай байх нь элбэг юм. Одоогоор манай улсад орон нутгийн түвшинд ард түмний санал асуулгаар асуудлыг шийдэж ирсэн практик байхгүй байгаа бөгөөд холбогдох хууль нь ч хараахан гараагүй байна. Энэ нь үндэсний болон орон нутгийн түвшний улс төрчдийн анхаарах асуудлын нэг мөн юм.

Гэхдээ 1992 оны Үндсэн хууль батлагдахаас өмнө манай улсад шууд ардчилал гэж байгаагүй гэвэл үнэнд үл нийцнэ. Тухайлбал, бүр 1922 оноос “Монгол улсын нутгийн захиргааны дүрэм”, “Их шавийн захиргааны дүрэм”, “Дарьгангийн нутгийн захиргааны дүрэм” зэрэг батлагдаж эдгээрт тулгуурлан арван гэр, баг, сум, хошууны хурлын зохион байгуулалтууд хийгдэж байсан.

8 Үндсэн хуулийн тавин есдүгээр зүйлийн 2 дахь заалт

9 Үндсэн хуулийн жаран хоёрдугаар зүйлийн 1.2 дахь заалт

Шууд ардчилал иргэний оролцооны асуудалтай холбоотой Монгол улсын түүхэнд тохиосон нэгэн содон үйл явдал бол 1945 онд болсон Ард нийтийн санал асуулга юм. Дэлхийн II дайны дараах улс төрийн ээдрээт нөхцөл байдал дунд манай улсын тусгаар тогтнол, бүрэн эрхэт байдлын хувь заяаг хэрхэх тухай, нөлөө бүхий том гүрнүүд хэлэлцэж тодорхой болзол тавигдаад байсан эгзэгтэй үед БНМАУ-ын Бага Хурлын тэргүүлэгчид¹⁰, БНМАУ-ын тусгаар тогтнолын талаарх асуудлын талаар бүх ард түмний саналыг гаргуулах тухай түүхэн шийдвэр гаргасан байдаг.

1945 оны 10 сарын 20-ны өдөр тэр үеийн манай улсын насанд хүрсэн нийт иргэд бараг бүгдээрээ буюу 99,9% нь (478 мянга гаруй хүн) улсын тусгаар тогтнолын төлөө саналаа хураалган оролцож улс, үндэстнийхээ гол үнэт зүйлийг хамгаалж чадсан нь бас нэг чухал тэмдэглэлт үйл явдал юм.

Дээр дурьдсан Үндсэн хуулийн заалтууд, “Ард нийтийн санал асуулгын тухай” хууль, “Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулж байх тухай Ерөнхийлөгчийн зарлигийн заалтуудын агуулга нь шууд ардчилал, иргэний оролцооны талаар үлэмж их бололцоо нээж өгсөн хууль, эрх зүйн чухал баримт бичгүүд гэдэг нь тодорхой байна.

Бусад орны сайн туршлага, практикаас сургамж авч орон нутгийн түвшинд сум, дүүрэг, аймаг, нийслэлд ард иргэдийнх нь нийтлэг ашиг сонирхолыг хөндсөн зарим асуудлыг орон нутгийн хэмжээний санал асуулга явуулах замаар шийддэг болвол шууд ардчилалын дараах гурван хэлбэр манайд хэрэгжих бололцоотой болно.

1. Бүх ард түмний санал асуулга
2. Иргэдийн нийтийн хурал (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал биш)
3. Орон нутгийн референдум

Дээрх гурван хэлбэрийг иргэд шийдвэр гаргаж оролцдог шууд ардчиллын хэлбэрүүд гэж үзэх нь бий¹¹.

Шууд ардчилалын энэ гурван хэлбэр нь иргэний оролцооны дээд хэлбэр болох тул тэр бүр байнга хийгдээд байдаг зүйл биш. Тэр тусмаа Ард нийтийн санал асуулгын тухай хууль хэдийгээр батлагдсан ч, өнөө хүртэл хэрэглэгдээгүй нь цаг хугацаа, хүч хөрөнгө, асуудал шийдэх төвөгтэй байдалтай холбоотой төдийгүй дээр нэгэнт тэмдэглэсэнчлэн иргэдийн санаачлагаар референдум явуулах бололцоо хуулиар хаагдмал байгаатай холбоотой гэж үзэж байна. Эдүгээ энэ хаагдмал бололцоог нээхийн тулд “Иргэний оролцооны тухай” хуулийн төслийг шинээр санаачлаад байгаа нь (Ерөнхийлөгчийн институт) сайшаалтай ч одоо нэгэнт байгаа ард нийтийн санал асуулгын хуульд өөрчлөлт оруулах, орон нутгийн түвшинд санал асуулга явуулах тухай хуулийг шинээр батлуулах замаар асуудлыг шийдэх нь илүү мэт. Цаашид орон нутгийн референдумыг хуулийг баталж, үндэсний гэхээсээ илүү орон нутгийн референдумыг явуулж орон нутгийн түвшиний асуудлыг шийдвэрлэх боломжтой.

Манай улсад шууд ардчилалд үндэслэсэн иргэний оролцооны хэлбэрүүдээс байнга хэрэглэх бололцоотой нь баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурал юм. Гэвч баг, хорооны түвшинд шийдвэрлэх асуудлын хүрээ хумигдмал, хөрөнгө нөөц ихээхэн хомс байдаг. Харин шууд ардчиллын хэлбэр биш ч гэсэн Ерөнхийлөгч Н.Энхбаярын үед гаргасан “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж байх тухай зарлиг нь

10 1945 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 76 дугаар тогтоол

11 /en.m.wikipedia.org/ Government in the United States. 1997. p. 17/

зөвхөн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын түвшинд төдийгүй гүйцэтгэх эрх мэдлийн шугамаар үйл ажиллагаа явуулж байгаа Засаглалын бүх түвшиний байгууллагууд бодлого, шийдвэртээ иргэдийн санал бодлыг тусгаж байх зарчмын чухал чиглэл болсон байна. Харамсалтай нь манай судалгаанд хамрагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд шууд ардчилалын болон иргэдийн оролцоог хангах талаар гарсан дээрх бодлого шийдвэрийн хэрэгжилт сулхан байгаа нь ажиглагдсан. Үүний гол шалтгаануудын нэг нь урьд гарсан бодлого шийдвэрийг өвлөн авч хэрэгжүүлэх гэхээсээ ямар нэгэн шинэ санал, санаачлага гаргаж олны анхаарлыг татах үйл ажиллагааг шинээр эхлүүлдэг явдал байх шиг байна.


Манай улсад шууд ардчилал - Иргэний оролцоог хангах чиглэлээр өөр санаа, санаачилгыг шинээр хэрэгжүүлэх оролдлогууд гарсаар байна. Үүний нэг илрэл нь Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн “Шууд ардчилал-Иргэний оролцоо”-ны үзэл санаа юм. Энэ хүрээнд “Шууд ардчилал-иргэний оролцоогоор дамжуулан төвлөрлийг сааруулах үндэсний дунд болон урт хугацааны бодлогын баримт бичиг” (2012-2022 он) Монгол улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 176 дугаар зарлигийн хавсралт маягаар гарчээ.

Энэхүү бодлогын баримт бичиг нь УИХ-аар хэлэлцэгдэн батлагдаж байж хүчин төгөлдөр болох тул түүний хэрэгжилтийн тухай асуудлыг ярих нь утгагүй хэрэг болно. Харин 2011 оны 12 дугаар сарын 23-нд Төсвийн тухай шинэ хууль батлагдан гарч, тус хуулинд “Иргэдийн оролцоо” гэсэн тусгай бүлгийг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилгаар оруулан баталсан. Энэ хууль батлагдаад гурван жил гаруй болж байна. Ийнхүү манай улсад шууд ардчилал, иргэний оролцооны талаар хууль, эрх зүй болон бодлогын орчин харьцангуй сайн бүрдэж байна. Гагцхүү холбогдох хууль, бодлогын хүрээнд нээгдсэн боломжуудыг гүйцэтгэх удирдлагын түвшин бүрт хэрэгжүүлж хэвшүүлэх үйл ажиллагаа дутмаг байгаа нь илт. Хууль тогтоомжийн заалт, бодлогыг тууштай хэрэгжүүлэх төдийгүй, шууд ардчилал, иргэдийн оролцооны хүрээнд олон улс, практикт нэвтэрсэн сайн туршлага, онол-арга зүйн дүгнэлт, зөвлөмжийг бүтээлчээр авч ашиглах явдал чухалчлагдаж байна.

Орон нутгийн түвшинд дэх иргэдийн оролцооны өнөөгийн байдлыг тодруулах зорилгоор манай судалгааны баг Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Төв, Сүхбаатар, Хэнтий аймгийн 10 гаруй сум, Улаанбаатар хотын Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн нийт 1400 гаруй өрхийн төлөөллийг хамруулан асуулгын судалгаа хийсэн бөгөөд хураангуй үр дүнг дор танилцуулая.

Иргэдэд мэдээлэл хүрч буй байдал

Орон нутаг дахь иргэдийн оролцоог сайжруулахад иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх нь туйлын чухал билээ. Тиймээс бид асуулгын судалгаагаар орон нутаг дахь иргэний оролцоо, түүний талаарх мэдлэг, мэдээлэл иргэд, олон нийтэд хүрч буй байдлыг тодруулахыг зорилоо. Иргэд оршин суугаа орон нутгийнхаа бодлого, шийдвэрийн талаарх мэдээллийг ихэнхидээ телевиз, өдөр тутмын сонин хэвлэл, орон нутаг дахь засаг захиргааны байгууллагаас авдаг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Иргэдийн мэдээлэл авч буй байдлыг аймаг, нийслэлээр харьцуулж үзэхэд онцгой ялгаа харагдахгүй байна (Зураг 1-ийг үзнэ үү).




Зураг 1. Иргэдийн мэдээлэл авч буй байдал (аймаг, нийслэлээр)

Мэдээлэл авдаг эх сурвалжуудыг эрэмбээр нь харвал иргэдийн 54.5 хувь нь буюу ойролцоогоор 5 хүн тутмын 3 хүн нь телевизийн мэдээ, сурталчилгаанаас, 3 хүн тутмын нэг нь байгууллагын нээлттэй хаалганы өдрүүдээр, 5 хүн тутмын нэг нь орон нутгийн байгууллагаас гарч буй албан ёсны мэдээллүүдээс гэжээ. Харин брошур буюу нугалмал хуудас зэрэг хэвлэмэл материал, төлөвлөлт загвар харуулсан самбар зэрэг тус орон нутагт байрлах, зорилтот иргэддээ зориулсан мэдээлэл, баримтанд иргэд, олон нийт ач холбогдол бага өгдөг ба зорьж унших нь ховор байдаг байна.

Иргэдийн оролцоо

Манай улсад баг, хорооны иргэд Иргэдийн Нийтийн Хурлаас өөр шууд ардчиллын зарчмаар асуудлыг шийдэж буй хэлбэр хараахан байхгүй байна. Өнгөрсөн хугацаанд иргэд орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд хэрхэн оролцож байсныг тандахад судалгаанд оролцсон

иргэдийн 10 иргэн бүрийн 2 нь байнга оролцож, харин 2 иргэн бүрийн нэг нь зарим үед оролцдог гэжээ. Огт оролцдоггүй гэж таван хүн тутмын нэг нь буюу 22 хувь нь хариулсан байна (Зураг 2-ыг харна уу).



Зураг 2. Иргэдийн орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд санал бодлоо илэрхийлж оролцож буй байдал

Иргэдийн оролцооны идэвхийг харуулсан судалгааны үр дүнг хот, хөдөөгөөр харьцуулсан шинжилгээ хийж үзэхэд онцлох ялгаа ажиглагдахгүй байгаа хэдий ч хүн ам зүйн чухал үзүүлэлтүүд болох нас, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь харьцуулж үзэхэд дараах үр дүн ажиглагдлаа. Иргэдийн нас ахих тусам байнгын оролцоо нэмэгдэж байгаа бол нас залуужих тусам зарим үед оролцох оролцоо нэмэгдсэн дүн ажиглагдаж байна (Хүснэгт 1). Тогтмол оролцоо залуучуудын дунд бага байна.

Хүснэгт 1. Иргэдийн оролцооны идэвхи, насны бүлэгт эзлэх хувь

	18-25 нас	26-35 нас	36-45 нас	46-55 нас	56-аас дээш
Байнга оролцдог	6	17	26	38	39
Зарим үед оролцдог	56	56	54	53	47
Оролцдоггүй	37	26	21	9	14
Нийт	100	100	100	100	100

Өөрөөр хэлбэр 46-аас дээш насны иргэдийн 38-39 хувь байнга оролцдог гэж хариулсан байхад 18-45 насныханы ердөө 6-26 хувь нь л тийм хариулт өгчээ. Харин зарим үед оролцдог болон оролцдоггүй иргэдийн дийлэнхи нь 45-аас доош насныхан байна. Нас ахих тусам иргэдийн оролцоо тогтмолжих хандлагатай байгааг судалгааны үр харуулж байна.

Иргэний оролцооны идвэхийг хөдөлмөр эрхлэлтийн байдлаар харьцуулан харвал орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд байнга оролцдог гэж хариулсан иргэдийн 25 хувийг цалин хөлстэй ажиллагч, 17 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгч, 37 хувийг тэтгэвэрийн насныхан эзлэж байна. Мөн зарим үед оролцдог гэж хариулсан иргэдийн 32 хувийг цалин хөлстэй ажиллагч, 27 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгч, 20 хувийг тэтгэврийн насныхан бүрдүүлжээ (Хүснэгт 2).


Хүснэгт 2. Иргэдийн оролцооны идэвхи, хөдөлмөр эрхлэлтэд эзлэх хувь

Хөдөлмөр эрхлэлт	Байнга оролцдог	Зарим үед оролцдог	Оролцдоггүй
Цалин хөлстэй ажиллагч	25	32	32
Ажил олгогч	1	1	3
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	17	27	30
Нөхөрлөл, хоршооны гишүүн	3	-	-
Мал аж ахуй эрлэгч	-	-	-
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	1	1	-
Тэтгэвэрт	37	20	10
Оюутан, суралцагч	4	4	8
Ажилгүй	8	11	17
Бусад	4	3	2
Нийт	100	100	100

Дээрх үр дүнгийн хүснэгтээс байнга болон зарим үед оролцдог иргэдийн 44-57 хувь нь цалин хөлстэй ажиллагч, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, тэтгэврийн насныхан байгаа нь харагдаж байна. Харин ажил олгогч, нөхөрлөл хоршооны гүшүүд, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид, оюутан суралцагчид болон ажилгүй иргэдийн хувьд оролцооны идэвхи сул байгаа бол мал аж ахуй эрхлэгчдийн хувьд иргэний оролцооны идэвхи маш муу буюу огт оролцоогүй байна.

Иргэдийн оролцооны хэлбэр

Иргэдийн орон нутгийнхаа бодлого, шийдвэрт өнөөг хүртэл ямар хэлбэрээр оролцож байгааг тодруулахад ямар нэгэн байдлаар оролцож байсан иргэдийн хувьд биеэр, цахимаар, бичгээр зэрэг хэлбэрээр санал гомдлоо илэрхийлж оролцдог гэж илүүтэй хариулсан бол нээлттэй хэлэлцүүлэг, ярилцлагад оролцож ирсэн гэж нийт судалгаанд оролцогчдын 11 хувь нь хариулсан байна (Зураг 3).




Зураг 3. Иргэдийн орон нутгийнхаа бодлого, шийдвэрт оролцож буй хэлбэр, хувиар

- Улс төрийн байгууллагын үйл ажиллагаанд амаар болон бичгээр санал бодлоо илэрхийлж шууд оролцдог
- Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд амаар болон бичгээр шууд оролцдог
- Санал гомдлоо илэрхийлж оролцдог
- Байгууллагуудаар дамжуулж оролцдог
- Хуулиар олгогдсон оролцооны боломжуудыг ашигладаг
- Нээлттэй хэлэлцүүлэг, ярилцлагад оролцдог
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан санал бодлоо илэрхийлэх замаар оролцдог
- Цахим хэлбэрээр санал бодлоо илэрхийлж оролцдог (Facebook, Twitter, цахим санал асуулга гэх мэт)
- Жагсаал, цуглаанд нэгдэх замаар оролцдог
- Гарын үсэг цуглуулах замаар оролцдог
- Өнөөг хүртэл ямар нэгэн байдлаар оролцож байгаагүй

Судалгаанд оролцсон иргэдийн 16 хувь нь өнөөг хүртэл ямар нэгэн байдлаар оролцоогүй гэж хариулсан байна. Мөн оролцсон иргэдийн хувьд гарын үсэг цуглуулах, жагсаал цуглаанд нэгдэх, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр санал, бодлоо илэрхийлэх, холбогдох байгууллагуудаар дамжуулан оролцох, хуулиар олгогдсон оролцооны боломжуудыг ашиглах оролцооны хэлбэрүүд сул буюу хангалтгүй байна.

Оролцооны хэлбэр тус бүрийг насны бүлгээр харьцуулан харвал 56-аас дээш насныхны тухайд улс төрийн байгууллага, засаг захиргааны байгууллагын үйл ажиллагаа, хурал цуглаанд оролцох нь илүүтэй байдаг бол 46-55 насны иргэд жагсаал цуглаанд нэгдэх, санал гомдлоо илэрхийлэх хэлбэрээр оролцох нь илүү байдаг байна. Харин 36-45 насныхан байгууллагуудаар дамжуулж, гарын үсэг цуглуулах замаар, 18-35 насныхан цахим хэлбэрээр санал бодлоо илэрхийлдэг гэжээ.

Орон нутгийн удирдлагын шийдвэрт иргэдийн оролцоог хангах талаар зохион байгуулж байгаа ажлыг иргэдийн талаас илүү хувь нь сайжруулах шаардлагатай гэж үзэж байна. Харин хангалттай сайн гэж нийт иргэдийн 14.6 хувь нь хариулжээ. Тэгвэл тус асуудлын талаар ойлголт мэдлэггүй, мэдээлэлгүй байгаагаас шалтгаалж хариулж мэдэхгүй гэж ойролцоогоор 10 хүн тутмын нэг нь буюу 8.5 хувь нь хариулжээ. Хангалтгүй гэсэн үнэлгээг 4 хүн тутмын нэг нь буюу 23.6 хувь нь өгсөн байна.



Зураг 4. Иргэдийн орон нутгийнхаа бодлого, шийдвэр гаргалтанд оролцож буй оролцооны хэлбэр, аймаг, нийслэлээр, хувиар


Орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд санал бодлоо хэрхэн илэрхийлж оролцдогоос үл хамаарч иргэдийн 43-58 хувь нь орон нутгийн удирдлагын шийдвэрт иргэдийн оролцоог хангах талаар зохион байгуулж буй ажлыг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

Хүснэгт 3. Орон нутгийн удирдлагын шийдвэрт иргэдийн оролцоог хангах талаар зохион байгуулж байгаа ажлын талаарх иргэдийн үнэлгээ, иргэдийн оролцооны идэвхи, хувиар

		Иргэдийн орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд санал бодлоо илэрхийлж оролцож буй байдал		
Орон нутгийн удирдлагын шийдвэрт иргэдийн оролцоог хангах талаар зохион байгуулж байгаа ажлын талаарх иргэдийн үнэлгээ		Байнга оролцдог	Зарим үед оролцдог	Оролцдоггүй
	Хангалттай сайн	33	8	6
	Сайжруулах шаардлагатай	53	58	43
	Хангалтгүй	11	22	26
	Хариулж мэдэхгүй байна	4	12	24
Нийт		100	100	100

Харин байнга санал бодлоо илэрхийлж оролцдог иргэдийн гуравны нэг нь тус ажилд хангалттай сайн гэсэн үнэлгээг өгчээ. Харин оролцооны идвэхи багатай болон оролцдоггүй иргэдийн тухайд хангалтгүй буюу хариулж мэдэхгүй гэсэн хариултыг түлхүү өгсөн байна.

Иргэдийн орон нутгийнхаа удирдлагын шийдвэр гаргах үйл явцад ямар үүрэгтэйгээр оролцох хүсэлтэй байгааг тандахад 8.4 хувь нь өөрийн саналыг боловсруулж өгөхийг, 27.0 хувь нь гаргасан саналуудад санал өгөхийг, 40.5 хувь нь гаргасан саналуудыг үнэлж дүгнэхийг, 12.9 хувь нь идвэхгүйгээр ажиглахыг хүсч байгаагаа илэрхийлсэн бол 11.3 хувь нь оролцохыг хүсэхгүй байна гэж хариулжээ. Өөрөөр хэлбэл иргэдийн 75.9 хувь нь буюу 4 хүн тутмын 3 нь орон нутгийнхаа удирдлагын шийдвэр ямар нэгэн байдлаар оролцох хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна.



Зураг 5. Иргэдийн орон нутгийнхаа удирдлагын шийдвэр гаргах үйл явцад оролцохыг хүсч буй байдал

Иргэдийн 40.5 хувь нь гаргасан саналуудыг үнэлж, дүгнэхийг хүсэж байна гэсэн бол 27 хувь нь гаргасан саналуудад санал өгөхийг хүсч байгаагаас харахад иргэд өөрсдөө санал оруулах бус бэлэн гаргасан саналуудад саналаа өгөх, тэдгээр саналуудыг үнэлж дүгнэхийг илүүд үзсэн байна. Дээрх асуудлыг насны бүлгээр авч үзвэл тодорхой үүрэгтэйгээр удирдлагын шийдвэр гаргах үйл явцад оролцохыг хүсэхгүй байна гэж 18-25 насны залуучууд илүүтэй хариуллаа. Харин иргэдийн 40-60 хувь нь гаргасан саналд санал өгөх, үнэлж дүгнэх үүрэгтэйгээр орон нутгийнхаа удирдлагын шийдвэр гаргах үйл явцад оролцохыг хүсэж байна гэжээ.

Орон нутаг дахь иргэдийн оролцоотой удирдлагын тогтолцоо ямар зорилгод чиглэсэн байх ёстой талаарх иргэдийн төсөөллийг тандахад иргэдийн 70-80 гаруй хувь нь доор өгөгдсөн чиглэлүүдтэй санал нэг байгаагаа илэрхийлсэн байна. Санал нэг байгаа хариултын үнэлгээний 34-66 хувь нь “бүрэн санал нэг” байгаагаа илэрхийлсэн хариулт байна.

Хүснэгт 4. Иргэдийн оролцоотой удирдлагын тогтолцоо ямар зорилгод чиглэх ёстой талаарх иргэдийн төсөөлөл, хувиар


	Бүрэн санал нэг байна	Санал нэг байна	Зарим талаараа санал нэг байна	Бага зэрэг санал нэг байна	Огт санал нийлэхгүй байна
Иргэд юу хүсэж, сонирхож байгааг улс төрчид илүү сайн мэдэх хэрэгтэй	58	23	9	5	5
Иргэдийн хүсэл, эрмэлзлэлийг тусгасан шийдвэрийг л улс төрчид гаргадаг байх ёстой гэж боддог	39	33	20	4	4
Орон нутгийн бодлогын асуудлыг сайн ойлгож байж, түүнд хяналт тавих боломж олдоосой гэж би боддог	43	39	12	4	2
Иргэд болон нутгийн нийт хүмүүсийн сайн сайхны төлөө шийдвэрүүдийг гаргахад иргэд илүү их хүчин чармайлт гаргаж байгаасай гэж хүсдэг	48	39	10	2	1
Улс төрийн шийдвэрүүдийг ойлгох мэдлэг олж авахад нь иргэдэд тусладаг байгаасай гэж хүсдэг	47	35	12	4	3
Улс төрийн шийдвэрүүдийн нөлөө илүү сайжраасай гэж хүсдэг	38	43	13	4	2
Улс төрийн шийдвэрийг ойлгох мэдлэг олж авахад нь иргэдэд тусладаг байгаасай гэж хүсдэг	34	44	17	4	1
Иргэд агуулгын хувьд өөр өөр саналтай байж түүнийг илэрхийлэх бололцоотой байгаасай гэж хүсдэг	66	27	4	2	1
Орон нутгийн бодлого урт хугацааны зорилгод илүү анхаарал хандуулдаг байгаасай гэж хүсдэг	47	40	10	2	1

Бүрэн санал нэг байгаа гэж хариулсан хариултуудыг харьцуулан үзвэл иргэдийн 58 хувь нь иргэд юу хүсэж, сонирхож байгааг улс төрчид илүү сайн мэдэх хэрэгтэй гэж хариулсан бол бүрэн санал нийлсэн асуудал нь иргэд агуулгын хувьд өөр өөр саналтай байж түүнийг илэрхийлэх бололцоотой байгаасай гэж хүсч буйгаа илэрхийлсэн байна. Үүнд судалгаанд оролцсон иргэдийн 66 хувь нь бүрэн санал нэг байна гэж хариулжээ.

Эндээс дүгнэж үзвэл иргэдийн оролцоог хангах талаар төрөөс явуулж буй бодлого үйл ажиллагаа иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд иргэд юу хүсэж, сонирхож байгааг улс төрчид илүү сайн мэдэх, нөгөөтэйгүүр иргэд санал бодлоо илэрхийлэх бололцоотой байгаасай гэдгийг иргэдийн талаас илүү хувь нь чухалд тооцож байна. Дараагийн түвшинд орон нутгийн бодлого урт хугацааны зорилгод анхаарч, улс төрд гарсан шийдвэрийн нөлөөг сайжруулж, гаргасан шийдвэрүүдээ иргэдэд ойлгуулах асуудалд анхаарах хэрэгтэй гэж үзжээ.

Иргэдийн сэтгэл ханамж

Иргэдийн оршин суугаа орон нутгийнхаа хөгжлийн бодлогод хэр зэрэг сэтгэл ханамжтай байгааг тодруулахад судалгаанд оролцогчдын 7.9 хувь үнэхээр сэтгэл хангалуун, 35 хувь сэтгэл хангалуун, 33.5 хувь нь төдийлөн сэтгэл хангалуун биш, 15.9 хувь бага зэрэг сэтгэл хангалуун, 7.8 хувь огт сэтгэл хангалуун биш гэсэн хариултыг өгсөн байна.



Зураг 6. Орон нутгийн хөгжлийн бодлогын талаарх иргэдийн сэтгэл ханамж, хувиар

Иргэдийн сэтгэл ханамжтай байдлыг нийслэл, аймгаар болон хүйс, боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлтээр харьцуулан үзэхэд онцгой ялгаа харагдахгүй байна. Насны бүлгээр нь харвал 36-аас дээш насныхны тухайд орон нутгийнхаа хөгжлийн бодлогод сэтгэл ханамжтай байдал өндөр байна. Харин 36-аас доош насны залуучуудын хувьд төдийлөн сэтгэл хангалуун бус буюу сэтгэл ханамж муутай байдаг гэж хариулсан байна.

Харин орон нутгийнхаа хөгжлийн бодлогод хэр зэрэг сэтгэл ханамжтай байгааг оролцоотой нь харьцуулж үзвэл орон нутгийнхаа хөгжил, иргэдийн

амьдрал ахуйтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд байнга оролцдог буюу тус орон нутагт зохион байгуулагдаж буй үйл ажиллагаа, хийгдэж буй бүтээн байгуулалтад ямар нэгэн байдлаар оролцож, тэдгээрийн талаарх мэдээллийг авдаг иргэдийн 39 хувь нь сэтгэл хангалуун гэсэн үнэлгээ өгсөн байна.

Хүснэгт 5. Орон нутгийн хөгжлийн бодлогод иргэдийн сэтгэл ханамж, оролцооны идэвхи, хувиар

Та орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд санал бодлоо илэрхийлж оролцож буй байдал				
Орон нутгийнхаа хөгжлийн бодлогод сэтгэл ханамжтай байдал		Байнга оролцдог	Зарим үед оролцдог	Оролцдоггүй
	Үнэхээр сэтгэл хангалуун	15	6	2
	Сэтгэл хангалуун	39	19	8
	Төдийлөн сэтгэл хангалуун биш	23	43	44
	Бага зэрэг сэтгэл хангалуун	13	25	29
	Огт сэтгэл хангалуун биш	10	8	17
Нийт		100	100	100

Өөрөөр хэлбэл орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудалд санал, бодлоо илэрхийлж оролцдог иргэдийн сэтгэл ханамжийн түвшин өндөр байгаа нь харагдаж байна. Харин эсрэгээрээ зарим үед оролцдог, оролцдоггүй иргэдийн хувьд сэтгэл хангалуун бус байдаг ажээ.

Иргэдийн орон нутгийнхаа бодлогыг сонгуультай холбоогүйгээр хэр сонирхдогийг тандахад төдийлөн сонирхдоггүй болон огт сонирхдоггүй гэж судалгаанд оролцогсдын 17.3 хувь нь хариулсан бол оролцогчдын талаас илүү нь буюу 55.7 хувь сонирхдог буюу маш ихээр сонирхдог гэж хариулжээ. Харин зарим үед сонирхдог гэж ойролцоогоор 3 хүн тутмын нэг нь буюу 27 хувь нь хариулсан байна.

Дүгнэлт

Судалгааны ажил нь өргөн утгаараа “Шууд ардчилал-Иргэдийн оролцоо”-ны асуудлыг хөндөж байгаа юм. Сүүлийн жилүүдэд энэ асуудал дэлхийн улс орнуудад эрчимтэй хөгжиж, шууд ардчилал-иргэдийн оролцоог хэрэгжүүлэх олон хэлбэр, арга хэрэгслүүд бий болсон байна. Шууд ардчилал-иргэдийн оролцооны онол, үзэл баримтлал, түүнийг Европын зарим оронд хэрэгжүүлж буй туршлагаас үзэхэд маш нарийн зохицуулалт бүхий олон үе шат, хэлбэр, арга хэрэгслүүдийг

тодорхой зориулалттайгаар сонгож хэрэглэдэг байна. Тухайлбал, Европын холбооны улсуудад иргэдийн оролцоо явцуу утгаараа зөвхөн орон нутгийн түвшинд л хэрэглэгддэг байна. Илтгэлийнхээ хүрээнд ХБНГУ-ын туршлагыг тухайлан авч үзлээ.

ХБНГУ-ын орон нутгийн түвшин дэх иргэдийн оролцоо хоёр үе шатыг дамжин хөгжиж ирсэнийг дээр дурьдсан. ХБНГУ орон нутгийн түвшиний иргэдийн оролцоог цаашид хөгжүүлэхдээ иргэдийн оролцоог хангах дүрэм, журам бий болгох, институтчилах, орон нутгийн улс төрчид, засаг захиргааны ажилтнууд, иргэд хоорондын хамтын ажиллагааг дэмжих, нутгийн захиргааны байгууллагуудыг нээлттэй болгох, оролцогч талууд зөвшилцөлд хүрэх, иргэдийг мэдээллээр хангах шаардлагатайг чухалчилж үзсэн байна. Мөн орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог хөгжүүлэхэд тулгамдаж буй олон асуудал байгаагаас хүмүүс хоорондын сэтгэлгээний ялгаа, нэр томъёоны ойлгомжгүй байдал, иргэд болон төрийн захиргааны байгууллага хооронд зөрчил үүсэх, илтгэлцэл алдагдахаас болгоомжлох хэрэгтэйг анхааруулсан байна.

Иргэдийн оролцоо бол засаг захиргааны байгууллагууд шийдвэр гаргах, төлөвлөх, хяналт тавих зэрэг үйл ажиллагаандаа иргэдийг зориуд зохион байгуулалттайгаар оролцуулж тэдэнд мэдээлэл өгөх, саналыг нь сонсох, асуудлыг хамтран хэлэлцэх тухай юм. Орон нутгийн бүх шатны хурлын болон засаг захиргааны байгууллагууд үйл ажиллагаагаа нээлттэй, ил тод, хяналттай явуулахад иргэдийн оролцоо чухал байдаг. Түүнээс гадна иргэдийг тодорхой асуудал шийдэхэд оролцуулснаар иргэд идэвхижиж өөрөө өөрийнхөө төлөө, оршин суугаа нутгийнхаа хөгжлийн төлөө санаачилга гарган ажиллах боломж бүрдэнэ.

Манай улс Үндсэн хуулиараа зөвхөн баг, хорооны түвшинд шууд ардчилалын хэлбэрээр, иргэдийн шууд оролцоотойгоор асуудлыг шийдэхээр зохицуулсан байдаг. Харин бусад түвшинд төлөөллийн ардчиллын зарчмаар асуудлыг шийдэхээр хуульчилсан байдаг. Гэхдээ Үндсэн хууль батлагдахаас өмнө манай улсад шууд ардчилал байгаагүй гэвэл үнэнд үл нийцнэ. Бүр 1922 оноос тусгайлан дүрэм журмуудыг боловсруулан батлаж эдгээрт тулгуурлан арван гэр, баг, сум, хошууны хурлын зохион байгуулалтууд хийгдэж байсан бөгөөд өөрөө өөрийнхөө төлөө явдаг, хот айлаараа хамтарч асуудлаа шийддэг уламжлал монголын ард түмэнд байгаа. Мөн дээр дурьдсан Үндсэн хуулийн заалтууд, “Ард нийтийн санал асуулгын тухай” хууль, “Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулж байх тухай Ерөнхийлөгчийн зарлигийн заалтуудын агуулга нь шууд ардчилал, иргэний оролцооны талаар үлэмж бололцоог нээж өгсөн эрх зүйн чухал баримт бичгүүд гэдэг нь тодорхой харагдах төдийгүй сүүлийн жилүүдэд иргэдийн оролцоог бүхий л түвшинд нэмэгдүүлэх хүсэл эрмэлзлэл бий болж байна.

Манайд орон нутгийн хэмжээний санал асуулга явуулах замаар асуудлыг шийддэг болвол “Бүх ард түмний санал асуулга”, “Иргэдийн нийтийн хурал”, “Орон нутгийн референдум” гэсэн шууд ардчиллын хэлбэрүүд хэрэгжих бололцоотой юм.

Гэвч манайд иргэдийн оролцооны тухай ойлголт өнөөг хүртэл нэг мөр болоогүй байна. Тухайлбал, шууд ардчиллын чухал илэрхийлэл болох “Ард нийтийн санал асуулга”-ыг иргэдийн оролцооны хэлбэр гэж үзэх үү, үгүй юу гэдэг асуудлаар судлаачид санал зөрдөг.

Орон нутаг дахь иргэдийн оролцоог хөгжүүлэхэд тулгамдаж буй олон асуудал байгаа хэдий ч “Орон нутгийн реферэндум” явуулах бололцоог хуулийн хүрээнд нээлттэй болгох, “Иргэний оролцооны тухай” шинэ хуулийн төслийг батлахаас илүү орон нутгийн түвшинд санал явуулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх, баг, хорооны иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэж буй асуудлын хүрээ хумигдмал, хөрөнгө нөөц хомс байдлыг шийдвэрлэх нь нэн бухал байж болох юм.

Бидний хийсэн судалгааны үр дүнгээс харахад манай оронд иргэдийн оролцоог хангах чиглэлээр гарсан бодлого, шийдвэрийн хэрэгжилт сулхан, хуучин бодлого, шийдвэрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхгүй, үр дүнд хүрэхгүйгээр шинэ санаачлага гаргадаг нь энэ чиглэлээр хэрэгжиж буй бодлого, шийдвэрийн хэрэгжилтэнд муу нөлөөлж буй байдал ажиглагдаж байна. Мөн Орон нутгийн түвшин дэх иргэдийн оролцооны өнөөгийн байдлыг тодорхойлох судалгааны тоон болон чанарын үр дүнд тулгуурлан тус илтгэлийн хүрээнд орон нутаг дахь иргэдэд мэдээлэл хүрч буй байдал, орон нутгийн иргэдийн оролцоо, түүний хэлбэр, иргэдийн сэтгэл ханамжтай холбоотой дараах зүйлүүдийг тодруулж болохоор байна.

Мэдээлэл. Иргэд оршин суугаа орон нутгийнхаа бодлого, шийдвэрийн талаарх мэдээллийг ихэнхидээ телевиз, өдөр тутмын сонин хэвлэл, орон нутаг дахь засаг захиргааны байгууллагаас авдаг болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Харин брошур буюу нугалмал хуудас зэрэг хэвлэмэл материал, төлөвлөлт загвар харуулсан самбар зэрэг тус орон нутагт байрлах, зорилтот иргэддээ зориулсан мэдээлэл, баримтанд иргэд, олон нийт ач холбогдол бага өгдөг ба зорьж унших нь ховор байдаг байна. Иймд иргэдэд мэдээлэл хүргэхдээ тухайд зорилтод бүлгийн иргэдийн хамгийн их мэдээлэл авч буй эх сурвалжуудаар нь дамжуулан мэдээлэл хүргэх нь үр дүнтэй.

Оролцоо. Дөрвөн иргэн тутмын нэг нь орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудалд байнга оролцож байхад хоёр нь зарим үед оролцдог байна. Харин үлдсэн нэг нь ямар нэгэн байдлаар оролцоогүй байгаагаа илэрхийлсэн байна. Тогтмол оролцооноос зарим үед оролцох оролцоо өндөр байна. Иргэдийн нас ахих тусам байнгын оролцоо нэмэгдэж байгаа бол нас залуужих тусам зарим үед оролцох оролцоо нэмэгдсэн дүн ажиглагдаж байна. Энэ нь нас ахих тусам иргэдийн оролцоо тогтмолжих хандлагатай байгааг илэрхийлэх төдийгүй тогтмол оролцоо залуучуудын дунд бага байгааг харуулж байна. Харин хөдөлмөр эрхлэлтийн хувьд цалин хөлстэй ажиллагсдын байнгын болон тогтмол бус оролцоо өндөр байна. Харин хөдөлмөр эрхлэлтийн бусад хэлбэрүүд иргэдийн оролцооны идвэхи сул байгаа бол мал аж ахуй эрхлэгчдийн хувьд иргэний оролцооны идвэхи маш муу буюу огт оролцоогүй байна.

Оролцооны хэлбэр. Орон нутаг дахь иргэд ямар хэлбэрээр орон нутгийнхаа бодлого, шийдвэр гаргахад оролцож буйг тодруулахад иргэдийн дийлэнх нь санал гомдлоо илэрхийлэх, нээлттэй хэлэлцүүлэг, ярилцлагад оролцох, улс төрийн болон захиргааны байгууллагад амаар болон бичгээр санал бодлоо илэрхийлэх хэлбэрээр оролцдог байна. Харин гарын үсэг цуглуулах, жагсаал цуглаанд

нэгдэх, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санал, гомдлоо илэрхийлэх, холбогдох байгууллагуудаар дамжуулан оролцох, хуулиар олгогдсон оролцооны боломжуудыг ашиглах байдлаар оролцох бага буюу хангалтгүй байна. Мөн иргэдийн хувьд нас, хүйс, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, оршин суугаа байршил болон бусад оролцох боломжуудаас хамааран оролцооны хэлбэр нь өөр өөр байна.

Сэтгэл ханамж. Иргэдийн сэтгэл ханамжтай байдлыг нийслэл, аймгаар болон хүйс, боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлтээр харьцуулан үзэхэд онцгой ялгаа харагдахгүй байна. Насны бүлгээр нь харвал 36-аас дээш насныхны тухайд орон нутгийнхаа хөгжлийн бодлогод сэтгэл ханамжтай байдал өндөр байна. Харин 36-аас доош насны залуучуудын хувьд төдийлөн сэтгэл хангалуун бус буюу сэтгэл ханамж муутай байдаг гэж хариулсан байна. Мөн орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд оролцдоггүй иргэдийн сэтгэл ханамжтай байдал муу байгаа болон энэ чиглэлээр мэдээлэл авч, ямар нэгэн байдлаар оролцдог иргэдийн сэтгэл ханамж өндөр байгаа нь харагдлаа.

“Орон нутгийн түвшин дэх иргэдийн оролцоо” сэдэвт илтгэлийн хэлэлцүүлэг



Ш.Батсүх: Улс төрчид юуг чухалчилж авч үзэх вэ гэж асууж байна. Бид их ерөнхий зүйл яриад байдаг. Иргэдийн оролцоо хаана, ямар байх ёстой вэ гэдэг нь манайд тодорхой болоогүй байна. Гадаад улс орнуудад энэ асуудал хууль эрх зүйн хүрээнд маш нарийн зохицуулагдаж албажсан байдаг. Манайд иргэдийн оролцоо чухал л гэж яриад байхаас биш яг яаж оролцуулах, хэрхэн зөв хөгжүүлэх талаар бодлого, зохицуулалт тодорхой биш байна. Тиймээс иргэдийн

оролцоог тодорхой бодлоготойгоор хөгжүүлэх асуудлыг шийдэх хэрэгтэй юм. Эрх зүйн хувьд нарийн зохицуулалт хийж өгсөнөөр аливаа асуудлыг гудамжинд жагсаж, нийгэмд бухимдал үүсгэж хурцатгахаас нь өмнө ширээний ард сууж, ярилцаж шийддэг шинэ соёл төлөвшүүлэх хэрэгтэй байна.

Г.Чулуунбаатар: *Нэгдүгээрт, Монгол улсад яг эрх зүйн орчин нь юу байна вэ? Хоёрдугаарт, тухайн Иргэдийн хуралд иргэд оролцоод санал хэлдэг. Тэгэхээр манай иргэд яг ямар шатанд оролцох ёстой талаар заасан заалт байдаг уу?*

Ш.Батсүх: Нэгдүгээр асуултанд профессор Я.Долгоржав хариулна. Хоёрдахь асуултын тухайд манай улс төлөөллийн ардчилалтай гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Өөрөөр хэлбэл бид сонгож илгээсэн төлөөлөгчөөрөө дамжуулан аливаа асуудалд оролцдог. Биднээс мандат авсан төлөөлөгчид биднийг төлөөлж чадаж байна уу, үгүй юу гэдэг бол өөр асуудал юм. Харин манай Үндсэн хуулинд баг, хорооны түвшинд шууд ардчиллын зарчмаар асуудлыг шийдэхийг хуульчилсан гэдгийг бид бүгд мэднэ. Иргэдийн оролцоо хөгжсөн орнуудад асуудлыг хэлэлцэж шийдэхдээ иргэдийг ямар шатанд нь оролцуулж, иргэдийн оролцооны ямар арга хэрэгсэл ашиглах вэ зэргийг нэгд нэгэнгүй нарийн зохицуулж өгсөн байдаг.

Я.Долгоржав: Хамгийн ерөнхий байдлаар хэлэхэд манайд иргэний оролцооны чиглэлээр эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй байна. Хоёрдугаарт, одоо хийгдэж байгаа ажлуудыг зөв үү гээд харвал зөв байна. Сүүлийн үед Орон нутгийн хөгжлийн сангаас иргэний оролцоотой төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд энэхүү санхүүжилтын ихэнхи нь ширээ, сандал гэх мэт эд зүйлсийг худалдаж авахад зарцуулагдсан байдаг боловч энэ зарцуулалт нь хуулинд тодорхой заагдаагүй байдаг. Энэ нь хууль эрх зүйн орчин нарийн тодорхой болоогүй байгааг илэрхийлж байна. Манай орон нутаг яаж хүчирхэгжих вэ, гэхээр орон нутгийн хүй элгэнүүдийг хүчирхэгжүүлэх нь зөв юм. Орон нутгийн хүй элгэнүүдийн хүчтэй байсан нөхцөл байдал дээр германчууд энэ асуудлыг шийдэж байсан байна. Харамсалтай нь манайд орон нутгийн хүй элгэнүүд нь орон нутагтаа хөгжиж чадахгүй байгааг бидний судалгааны үр дүн харуулсан.

Асуулт: *Монгол улсын хувьд шууд ардчиллыг 1995 оны Ард нийтийн санал асуулгын хуулиар зөвшөөрсөн байдаг боловч энэ нь одоо хүртэл хэрэглэгдээгүй. Ард нийтийн санал асуулгаар асуудлыг шийдвэрлэх боломж ер нь байдаг уу?*

Я.Долгоржав: Манайд референдумын хууль хийгдсэн байдаг. Бид үндэсний хэмжээний референдум хийхээс гадна Local referendum явуулах нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах нь илүү оновчтой байна. Хамгийн чухал зүйл бол ИТХ, УИХ-ын төлөөлөгчдийг шууд ардчиллаар эргүүлж татах хуулийн шаардлага гараад байгаа юм. Ард түмний төлөөлөл болсон төлөөлөгчид болон ард түмэн хоорондын үзэл бодол зөрөөд байгаад гол учир нь байгаа юм. Ард түмний санал асуулгын хууль хэрэгжих боломж хомс байна.

Монголын залуучуудын нэгдсэн намын төлөөлөл: *Ер нь залуучууд хамгийн идэвхгүй субъект байдаг гэсэн, энэ нь ч үнэн. Залуучуудын идэвхи оролцоог ярихаас өмнө тэдний улс төрийн боловсрол, ухатсар, соёлын талаар эхлээд ярих ёстой болов уу гэж бодогддог. Тэгэхээр зөвхөн залуучууд төдийгүй монголчуудын улс төрийн боловсролыг дээшлүүлэхэд онцгой анхаарах, түүний дараа улс төрийн оролцоо бий болгох, идэвхитэй оролцуулах тухай асуудлыг ярих нь зөв гэж боддог. Тэгэхээр залуучуудад эзэмшүүлэх улс төрийн мэдлэгийг хэн олгох ёстой байдаг вэ?*

Ш.Батсүх: Ерөнхийдөө залуучуудын оролцоог нэмэгдүүлэе гэвэл тэдний улс төрийн боловсролыг дээшлүүлэх хэрэгтэй гэсэн Таны үзэл бодолтой санал нэг байна. Залуучуудын улс төрийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, үүнд тулгуурлан идэвхи оролцоог нь нэмэгдүүлэх хэрэгтэй байгаа юм. Германы улс төрийн намууд сонгогчдынхоо улс төрийн боловсролыг дээшлүүлэх асуудалд их анхаардаг. Мөн засгийн газрын зүгээс ч энэ асуудалд ач холбогдол өгч “Холбооны улсын Улс төрийн боловсролын төв” гэсэн байгууллага байгуулж улсын төсвөөс санхүүжүүлэн гарын авлага, ном, бусад материалыг хүссэн иргэдэд үнэ төлбөргүй тараадаг. Манайд ийм чиг үүрэгтэй байгууллага одоогоор байхгүй байна. Улс төрийн намуудын хувьд сонгогчдынхоо улс төрийн боловсролыг дээшлүүлэх, өөрийн намын үзэл баримтлалыг сурталчилан ойлгуулж байх нь чухал юм.

Д.Цогтбаатар: Монгол улсын төрийн бодлогын асуудалд иргэд хэрхэн оролцож байгааг тодорхой харах хэрэгтэй байна. Бид залуучуудын оролцоо муу байна гэж байгаа боловч тэдний мэдлэгийг дээшлүүлэх шаардлагатай гэдэг нь тодорхой байна. Хэдий тийм боловч өмнөх үе шиг оролцоо учиргүй муу байна гэхээргүй байна. Хүн бүхэн л идэвхтэй оролцдог болоод байгаа. Гэхдээ энд нэг онцгой анхаарч үзэх ёстой асуудал нь бид иргэдийг хэрхэн оролцуулах талаар зорилтот сургалтуудыг зохион байгуулах явдал юм. Улс төрийн асуудал гэхээр тодорхой тооны хэдэн намууд л асуудлыг шийдэж байх ёстой юм шиг хандаж ирсэн нь буруу юм. Өнгөрсөн үеийг бодвол өнөөдөр манай иргэд баг, хорооныхоо, аймаг, нийслэлийнхээ асуудалд тодорхой хэмжээгээр оролцдог болсон байна. Тиймээс оролцоо гэдэг тал руугаа илүү түлхүү анхаарч, энэ асуудлын талаар ярилцах нь зүйтэй болов уу.



1990 ОНЫ АРДЧИЛСАН ХУВЬСГАЛД ЗАЛУУСЫН ОРОЛЦОО



*Ж.Баасандаш
Монголын Улс төрийн
хэлмэгдэгсдийн холбооны дэд тэргүүн*



*Д.Цогтбаатар
Монголын Улс төрийн
хэлмэгдэгсдийн холбооны
тэргүүн*

Монгол Улсад 1990 онд ардчилсан хувьсгал гарах болсон түүхэн шалтгаан, уг үйл явцын хөдөлгөх хүчин, эхлэл, өрнөлийн талаарх үзэл бодлоо Та бүхэнд энэ илтгэлээр товчхон танилцуулж байна. 1990 оны хувьсгалын хөдөлгөх хүч нь Монголын залуучууд байсан. Энэхүү хувьсгалд идэвхийлэн оролцогчид насны хувьд янз бүр байсан боловч идэр залуу сэтгэлгээтнүүд байв. Миний бие энэ асуудлаар мэргэжлийн судлаач биш жирийн нэгэн сонирхогч, харин одоогоос 25 жилийн өмнөөс эхлэн өрнөсөн уг үйл явцад эхнээс нь оролцсон төдийгүй зохион байгуулсан этгээдийн нэгэн гэдгээ онцлон дурдъя.

ИЛТГЭЛЭЭ ЭХЛҮҮЛЭХ ҮГ

Монгол орныг бүхэлд нь бүрхэж цантсан улс төрийн жихүүдэс, цан хүүргийг илч гэрэл, хурын шимээр ханатал тайлсан XVII жарны цагаан морин жил алслан одож эдүгээ бид өнгөрснөө үнэлэн цэгнэх нэгэн агшинтай золгоод байна. Дүн өвлийн цас, мөсөн хүүрэг тачигнасан тэр л өдрүүдэд ардчилсан хөдөлгөөний ариухан дөл бадамлан ассанаар монгол орон, монголчууд нойрноосоо сэрсээн!

Тэр үеийн Монголын улс төр, эдийн засаг, нийгмийн хямралт байдал нь хүнд суртлын дэглэм, нийгмийн коммунист харилцааг үндсээр нь халж шинэчлэх түүхэн шаардлагаар тодорхойлогдож байв. Монголын ардчиллын төлөө хөдөлгөөн нь зөвхөн цэвэр Монголын үзэгдэл байгаагүй. Тэрээр дэлхийн социалист хэмээх ертөнцийн хямралтай нягт холбоотой байв. Ардчилсан хөдөлгөөний өрнөлт нь коммунист хүнд сурталтнуудын улайран эсэргүүцэж дайран давшиж байсан шиг хэсэг бүлэг хүмүүсийн өдүүлсэн «зохиомол бухимдал» байсангүй.

Ардчилсан хөдөлгөөн манай нийгмийн харилцааны гүнээс, далан жилийн хөгжлийн сургамжаас урган гарсан юм. 1920-иод оны хувьсгалчдын хэлмэгдэлт, үндэсний "капиталист" элементийн устгал, "Баруун", "Зүүний" нугалаа, 1930-аад оны "хувьсгалын эсэргүү", "ардын дайсан", "гадаадын тагнуул"-ын гэгдэгчдийн

эсрэг явуулсан цуст хядлага, үндэсний сэхээтний өвөрмөц давхрага-лам нарыг аймаглан устгалт, 1950-60-аад оны “сэхээтний төөрөгдөл”, “үндсэрхэг, үгүйсгэх үзэлтнүүд”, “намын эсрэг бүлэг”-ийг амьдаар нь, гэр бүл удам судраар нь егүүтгэх хорон хатаалт, сэтгэл санаа, оюун ухаанаар нь гүжирдэн доромлох, булчингаар нь хариу авах, цөлөх энэ бүхний цаана улбаа нь үл тасрах коминтерн, сталинч дэглэм, түүнийг залгамжлагчдын сүүдэр энэ бол Монгол оронд өрнөсөн ардчилсан хөдөлгөөний үр хөврөлийг боловсруулсан түүхийн хуудас мөн.

АРДЧИЛСАН ХӨДӨЛГӨӨНИЙ ЭХЛЭЛ

Монгол оронд өрнөсөн улс төрийн тэмцлийн эхлэл нь бодит үр дүнгээр шаталсан хэд хэдэн мөчлөгийг дамжсан байна. Юуны өмнө коммунист хүнд суртлын ширүүн эсэргүүцлийг сөрөн 1990 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн МАХН-ны анхдугаар их хурлыг хуралдуулж чадсан нь түүхэн ач холбогдолтой үйл явдал байв. Энэ нь:

1. Ардчилсан хөдөлгөөнийг мөрийн хөтөлбөр бүхий зохион байгуулалтын хэлбэрт шилжүүлсэн.
2. Ардчиллын төлөө хөдөлгөөнийг нийгмийн бодит хүчин удирдсан биет үзэгдэл болохыг ард түмэнд тунхаглан зарласанд оршино. Улс төрийн тэмцэл зохион байгуулалтын хэлбэрт шилжсэнээр МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчоог огцруулах шаардлага бүхий улс төрийн өлсгөлөн хүртэл цаашид шатлан өргөжих нөхцөл бүрдсэн юм.

Жанжин Сүхбаатарын талбайд “өлсөгчдөд” мах, талх, мал, газар гэсэн лоозон байгаагүй юм. Харин тэнд хүнд сурталнуудын ухааныг балартуулсан, зарим хүний сэтгэлийг сэртхийлгэсэн “Улс төрийн товчоо огцор” гэсэн шаардлага байв. Энэ өлсгөлөн бол уг үгийн дээд утгаар ойлгох улс төрийн өлсгөлөн байв. Түүнийг хэн нэгэн, түүний дотор ардчилсан хүчнүүд санаанаасаа зохиосонгүй. Энэ нь монгол оронд бүрэлдэн бий болоод байсан улс төрийн түүхэн бодит байдлын илэрхийлэл коммунист дэглэмийн өөрийнх нь бүтээгдэхүүн байсан юм.

МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчоог бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулсан нь ардчилсан хүчний тэмцлийн улс төрийн чухал ололт болсон. Энэхүү ололт нь ард түмний улс төрийн идэвхийн өрнөлт, ардчилсан хүчнүүдийн тэмцлийн тактик, арга гэх мэт бусад олон хүчин зүйлээр нөхцөлдсөн юм. Гэвч хамгийн гол нь шалтгаан нь улс орны тухайн үеийн удирдлага бүхэлдээ цаашид улс орныг удирдах, тэгэхлээр оршин тогтнох түүхэн, түүний дотор ёс суртахууны эрхээ бүрэн алдаад байсанд оршино. Энэ бол нийгмийн хувьсгалын бодитой бүрэлдсэн тохироо байсан билээ.

АРДЧИЛЛЫН ТӨЛӨӨ ХӨДӨЛГӨӨНИЙ ӨВӨРМӨЦ ОНЦЛОГУУД

1990 оны ардчилалын төлөө хөдөлгөөн нь социалист ертөнцөд өрнөсөн хувьсган шинэчлэгч үзэл санааны бүрэлдэхүүн хэсэг нийтлэг зүй тогтолтой ч Монголын гэсэн өвөрмөц онцлогтой ч холбоотой хэд хэдэн дүр төрхтэй байлаа. Үүнд:

1. Ардчилсан хувьсгалын хөдөлгөгч хүчин “холбоо”, “эвсэл”-д нэгдэж түүнээс улс төрийн цөм болсон намууд төрөн гарсан нь бусад орнуудад түгээмэл гараагүй Монголын ардчилсан хөдөлгөөний өвөрмөц нэгэн онцлог байв.
2. Монголын ардчиллын төлөө хөдөлгөөний хөдөлгөгч хүчин нь хүн амын нийгмийн, улс төрийн идэвхтэй бодит давхраа байв. Ардчилсан хүчнүүдийн удирдагчид нь өндөр албан тушаалтан, нөлөө бүхий улс төрийн зүтгэлтэн байсангүй. Харин коммунист, хүнд сурталнуудын давхаргын чөлөөт хүрээнээс түрэн гарч ирсэн залуу үеийн төлөөлөгчид байлаа. Чухам үүнд л Монголын ардчиллын төлөө хөдөлгөөний өвөрмөц онцлог, давуу тал, дутагдал, нэгэн зэрэг агуулагдаж байсан. Энэ нь юуны өмнө ардчиллын төлөө хөдөлгөөний хувь заяаг хагарал зөрөлдөөний “тоглоомд” нэрвэгдүүлэхээс ангижруулан, ардчиллын төлөө жинхэнэ тэмцэл байх, түүндээ эрс тууштай зогсох давуу талыг бий болгосон бас монголын ардчилал нялхсын өвчинд нэрвэгдэх аюулыг өөртөө байнга агуулж байсан. Энэ бол зөвхөн Монголын гэмээр тийм өвөрмөц онцлог байв.

АРДЧИЛЛЫН ТӨЛӨӨ ЗАЛУУСЫН ТЭМЦЛИЙН УТГАТ ЧАНАР

Монгол оронд өрнөсөн ардчиллын төлөө хөдөлгөөн нь ангийн тэмцэл буюу ангиуд хоорондын сөргөлдөөн тэмцэл, эсвэл эрх мэдэл, хөрөнгө мөнгөний булаалдаан байгаагүй. Ардчилсан хүчнүүд юуны төлөө, хэнтэй тэмцэв?

1990 онд эгнэн боссон залуучууд Монгол оронд улс төрийн ардчилсан тогтолцоо бий болгохын төлөө, манай нийгмийн удирдлагын бүхий л давхаргын эд эсэд аалзны шүлс санагдуулам хэрээст тор, хүлээс гинж болон тогтсон захиргаадалт, хүнд суртлыг халахын төлөө тэмцсэн. Коммунист хүнд суртал хэмээх гэмт үзэгдлийг дараах хэдэн шинжээр тодорхойлж болох байна. Үүнд:

- энэ бол нийгмээсээ, ард түмнээсээ хөндийрөн тасарч харьцангуй биеэ даасан, удирдлагын давхарга дахь сорон шимэгч амьд бие мөн.
- энэ бол нэгэн дарангуйлагч, түүнийг тойрон хүрээлсэн өчүүхэн хэсэг этгээдийн ноёрхол, засаглал, төржиж царцсан ганц намын дарангуйлал, дангаар ноёрхох явдал мөн.
- энэ бол тойрон хүрээлэгчдийн ялзмаг бүрхүүл доторхи өвөрмөц ертөнцийн дотоод амьдрал, тусгай хангамж, ёс суртахууны доройтол, ялзрал мөн.
- энэ бол өөрөө өөрийгөө нөхөн үйлдвэрлэж хамгаалж байдаг нарийн арга ажиллагаа бүхий амьд механизмын цогцос мөн.

Ардчиллын төлөө тэмцэгчид хэн нэгэн хэлмэгдүүлэгч, хүнд сурталтнаас өшөө авахыг зориогүй. Харин коммунист хүнд суртлын тогтолцоог ардчилсан, өөрөөр хэлбэл эрх мэдэл нь ард түмэндээ байдаг улс төрийн тогтолцоогоор халахын төлөө тэмцсэн. Үүнд ардчиллын төлөө манай тэмцлийн утгат чанар оршино.

ЗАЛУУЧУУДЫН 1990-ЭЭД ОНЫ ТЭМЦЛИЙН ЭХЛЭЛИЙН СУРГАМЖ

Ардчилсан хүчний залуучууд МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчоог огцруулсанаар санаачлагыг гаргаа авч идэвхтэй ажиллагаанд шилжсэн боловч улс төрийн нам байгуулахад хэт яарснаас хүнд суртлын тогтолцоо зүсээ хувирган амьдрах бололцоо олгож, ард түмний хүчийг саармагжуулан улмаар ардчиллын үйл явцыг саатуулах үр дагаварт хүргэсэн явдал бол нэг дэх сургамж байв.

Цаг хугацаа, хүч хөрөнгө, орон зайн хувьд МАХН-д илэрхий ашигтай, тэгш биш нөхцөлд явагдсан 1992 оны сонгуульд нийгэм, улс төрийн нөхцөл байдлын тухайн үеийн зайлшгүй шаардлагаар оролцсон боловч ардчиллын төлөө тэмцлийг ард түмний язгуур эрх ашигт нийцсэн зохистой хэлбэрээр цаашид тууштай өрнүүлж чадаагүй нь хоёр дахь сургамж байв.

МАХН-ын Улс төрийн товчоо огцорсонд чихэр харсан хүүхэд шиг баярлаж, коммунистуудад зүсээ хувирган “битүү” аргаар ардчилсан хувьсгалыг чөдөрлөн гацаах бололцоо олгосон явдал бүх ардчилсан хүчнүүдэд хамаарах хамгийн чухал сургамж байв.

Хагас дутуу хийгдсэн ардчиллын үр дүн ард түмнийг төдийгүй гадаад улс орнуудыг төөрөгдүүлэн, ардчиллын өрнөлт зогсонги байдалд орсон алдааг залруулах асуудал ирээдүйд хийх ажлын гол чиглэл болж үлдсэн.

АРДЧИЛСАН ХУВЬСГАЛЫН ӨРНӨЛ

1990 оны 03 дугаар сарын 21-нд хуралдсан БНМАУ-ын АИХ-ын VIII чуулганаар Үндсэн хууль дахь “БНМАУ-ын төр нийгмийг удирдан чиглүүлэгч хүч бол бүхнийг ялагч Марксист, Ленинист онолыг үйл ажиллагаандаа удирдлага болгодог МАХН мөн” гэсэн заалтыг хүчингүй болгов. Мөн оны 05 дугаар сарын 10-нд хуралдсан БНМАУ-ын АИХ-ын хуралдааны IX чуулганаар УБХ /хууль тогтоох байнгын байгууллага/, Засгийн газар /гүйцэтгэн захирамжлах байгууллага/-ыг эмхлэн байгуулах, мөн Ерөнхийлөгчийн албан тушаалыг бий болгох, АИХ-ын депутатуудыг бүх нийтээр сонгох, харин Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч бөгөөд УБХ-ы дарга, УБХ-ын гишүүд, Ерөнхий сайд, Улсын Прокурор, Дээд шүүхийн дарга, АХШХ-ны дарга нарыг парламентад суудалтай намууд болон Ерөнхийлөгчийн саналын дагуу АИХ-ын депутатууд сонгон баталж байхаар шийдэв.

Тус чуулганаар улс төрийн намуудын тухай хуулийг батлав. Уг хуулинд Үндсэн хуулийн заалтуудад нийцсэн дүрэм, мөрийн хөтөлбөртэй, 451-ээс доошгүй гишүүнтэй, улс төрийн үзэл бодлоороо нэгдсэн гишүүнчлэл бүхий байгууллагыг “улс төрийн нам” хэмээн бүртгэж болох тухай заажээ.

Монгол оронд улс төрийн тэмцэл цаашид өрнөж 1992 онд Үндсэн хуулийн бүрэн реформ хийгдсэнээр шилжилтийн шинжтэй улс төрийн өвөрмөц байдал, олон намын тогтолцоо, парламентын засаглал бий болов.

Төрийн болон аж ахуйн байгууллагын бүтцэд ажиллаж байсан коммунист намын үүр, хороодыг татан буулгаж улс төрийн намуудыг зөвхөн нутаг дэвсгэрийн зарчмаар ажиллуулах болсон, эхлээд хүчний байгууллагад

ажиллагсадыг аажмаар төрийн бүх албан хаагчдыг аливаа намын гишүүнчлэлээс ангижруулсан явдал бол ардчиллын төлөө тэмцлийн бас нэг ололт байв. Төр болоод намын ажлыг ялган заагласан, ядарч туйлдсан эдийн засгаа үзэл суртлаас ангижруулж, цэвэр аж ахуйн харилцааны хууль бодитой үйлчлэх нөхцөл бүрдүүлсэнд уг шийдвэрүүдийн ач холбогдол оршиж байв.

Энэхүү цаг хугацаанд хэдийгаар улс төрд цөөнх байсан боловч Ардчилсан хүчнээс санаачлан Эдийн засгийг либералчлах, хувийн өмчийн эрхийг баталгаажуулах, улсын өмчийг хувьчлах, түүний дотор хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээний салбарын хувьчлалыг тэргүүн ээлжинд хийх, энэхүү үйл ажиллагааг зохион байгуулалтаар хангах зорилгоор Өмч хувьчлалын комисс байгуулж ажиллуулах, төгрөгийн ам, доллартай харьцах ханшийг чөлөөлөх, үнийг зах зээлийн эрэлт нийлүүлэлтээс хамаарч өөрчлөгдөх боломжтой болгох, хоёр шатлалт банкны тогтолцоо бий болгох замаар банкны системийг хөгжүүлэх, мөнгөний бодлогоор дамжуулан макро эдийн засгийг удирдах боломж бүрдүүлэх, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, Хөрөнгийн бирж байгуулан ажиллуулах, эдийн засаг, бизнесийн сургалтыг зах зээлийн зарчим, эрэлтэд нийцүүлэн өөрчлөх, газрын доорхи баялагаа ашиглан хөгжихөөс илүүтэй монгол хүний оюуны чадамжид тулгуурлан хөгжихөд ач холбогдол өгөх зэрэг цогц арга хэмжээг санаачлан улмаар хэрэгжүүлэх ажилд ханцуй шамлан оролцсон. Эдгээр арга хэмжээг эхлүүлж чадсан нь залуу нас, шинэлэг сэтгэлгээ, эх орноо гэсэн сэтгэл, зүтгэлийн үр дүн байсан.

Монголчууд эв нэгдэлтэй байх хэрээр хүчирхэгжиж, тарж бутрах хэрээр уруудан доройтож тэр ч байтугай боолын боол болж байсан олон зуун жилийн түүхэн сургамжийг мартаж өсгүй байв. Мөн хууль тогтоох байгууллагыг бүрдүүлэх 1992 оны бүх нийтийн сонгуулийн үр дүн хатуу сануулага өгсөн. Энэ сонгуулиар ардчилсан хүчнийг бүрдүүлдэг шинэ тулгар намууд анх удаа олон намын оролцоо бүхий парламентын сонгуульд оролцсон боловч ердөө 5 суудал, харин эрх баригч коммунист МАХН 70 суудал авч ялалт байгуулсан... Эдгээр бодит шаардлагыг үндэслэн Монголын Ардчилсан Нам, Монголын Үндэсний Дэвшлийн Нам, Монголын Сэргэн Мандлын Нам, Нэгдсэн Нам тус тус нэгдэж 1992 оны 10 дугаар сарын 25-нд Монголын Үндэсний Ардчилсан Нам /МҮАН/ байгуулагдсан.

ТӨРИЙН ЭРХ АРДЧИЛСАН ХҮЧИНД ТАЙВАН ЗАМААР ШИЛЖСЭН НЬ

1996 оны УИХ-ын сонгууль Монгол Улсын түүхэнд анх удаа Төр, засгийн эрх мэдэл улс төрийн нэг хүчнээс нөгөөд тайван замаар шилжсэн онцгой тохиолдол болсон. Энэ сонгуулиар хууль тогтоох дээд байгууллага УИХ-д МҮАН-МСДН-ын “Ардчилсан Холбоо” эвсэл 50 суудал, МУНН нэг суудал авсан бол анх байгуулагдсан цагаасаа эхлэн 75 жилийн турш Төр засгийн эрх мэдлийг дангаар барьж байсан коммунист үзэл баримталдаг МАХН 25 суудал авч үнэмлэхүй ялагдал хүлээжээ.

1996-2000 онд “Ардчилсан Холбоо” эвсэл Засгийн газрын кабинетыг дангаараа бүрдүүлж, агентлагуудын дарга нар болон төрийн зарим албанд

өөрийн гишүүдээс сонгон томилж ажиллуулсан. Газар, орон сууцны хувьчлалыг эрчимжүүлэх, ашигт малтмалын орд газруудыг лицензаар эзэмшүүлж ашиглуулах, бизнест ээлтэй татварын орчин бий болгох, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, нийгмийн эмзэг давхрагад үзүүлэх төрийн халамжийг нэмэгдүүлэх зэрэг олон чухал арга хэмжээг эхлүүлсэн. Эдгээр алхмуудыг МАХН хийх байсан ч хийгээгүй нь монголын зах зээлийн эдийн засгийг тодорхой хугацаагаар хойшлуулсан үйл явдал байлаа. Монголын ардчилалыг дэмжигч улс орнуудын хүрээ өргөжиж, манайд олгох хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хэмжээ эрс нэмэгдсэн нь монголын гадаад харилцаа, зах зээл хөгжих давуу тал байв.

Энэ жилүүдэд төрийн эрх мэдлийг анх удаа авсан “Ардчилсан Холбоо” эвсэл зоримог, тууштай ажилласны зэрэгцээ бас нялхасын өвчинд нэрвэгдэн их төлөв зохион байгуулалтын шинжтэй алдаа эндэгдэл гаргаж байв. Ялсан ялалтандаа бялуурч, Монгол Улсын Еранхий сайд М.Энхсайханы Засгийн газар төрийн шийдвэр гаргахдаа цаг үеэ олоогүй шийдвэр гаргаж, суурь үнэ чөлөөлсөнөөс орон нутгийн сонгуульд үнэмлэхүй ялагдаж, төрийн байгууллагын анхан шатны нэгжид МАХН-ыг өөрийн хүмүүсээ бэхжүүлэх боломжийг олгож, ардчилсан хүчний улс төрийн түүхэнд сургамжийг авсан билээ. Цаашдын сонгуулийн улс төрийн түүхэнд томоохон цохилтыг авснаар 2000 он, 2004 онуудад ялагдал хүлээж, ардчиллын хөгжилд нөхөж баршгүй хохирол, тодорхой цаг хугацаа боломжоо алдсан юм. Тухайлбал, тэр үед удирдлагын анхан дунд шатны /баг, сум, аймаг, нийслэлийн дүүрэгт/ удирдах ажилтнуудыг коммунистууд бүхэлд нь бүрдүүлж байв. Тэд “Ардчилсан Холбоо” эвсэлийн бодлогыг дэмжээгүй төдийгүй шат шатанд нь унагаан мухардалд оруулж байв. Тухайлбал 1996-2000 оны үед УИХ-д цөөнх болсон МАХН-ын 25 гишүүн О.Дашбалбартай нийлж хурал хаясан тохиолдолд хуралдааны ирц 65.8 хувь болж дийлэнх олонхийн буюу 66.6 хувийн ирц бүрдүүлэхэд 1 хүн дутдаг байв. Хуулийн энэ ялимгүй юм шиг атлаа асар их учир холбогдолтой зохицуулалтыг МАХН чадмаг ашиглан, өөрсдийнх нь ашиг сонирхолд нийцээгүй асуудал хэлэлцэх болгонд хурал хаяж, төрийн ажил хэргийг яах ч аргагүй гацаа, түгжээнд оруулж байв. Жишээ нь эвсэл Ерөнхий сайдаа томилж чадахгүй 2 сар болж, Ерөнхий сайдад нэг хүний нэрийг 7 удаа дэвшүүлж, Засгийн газраа 4 жилд 4 удаа солиход хүрч байв. Иймэрхүү шаналгаат байдал 4 жилийн турш үргэлжилсэн.

МАХН сонгуулийн ялагдалдаа хорсон гашуудаж, төр засгийн эрх мэдлийг ямар ч үнээр, ямарч аргаар болов буцаан авах аян дайнд мордсон. Тэд эвслийн нэр хүнд, нааштай үйл ажиллагааг олон түмний дунд гутаан унагаах, эвслийн дотоод эв нэгдлийг задлах компани дэгдээж 2000 онд санасандаа хүрсэн билээ. Тэдний бохир ажиллагаа намдаа хамгийн их хандив нэртэй хахууль өгсөн хүнийг УИХ-ын сонгуульд нэр дэвшүүлэхээс эхэлсэн. Сонгогчдод ба үзэл бодол нь төлөвшөөгүй залууст багц багцаар мөнгө тарааж, санал, эрмэлзлэлийг нь худалдан авч байв

АРДЧИЛСАН ХҮЧНИЙ ЯЛАГДАЛ БА ШИНЭ ТӨРИЙН ДАМПУУРАЛ

2000 оны ээлжит сонгуулиар УИХ-д МАХН 72 суудал авч үнэмлэхүй ялалт байгуулсан. Монгол түмэн ардчилсан хувьсгалыг дутуу хийсний нэгэн горьг ийнхүү амсаж эдэлсэн. Заримаас дурьдвал:

1. МАХН-аас Үндсэн хуульд 2000 онд «дордуулсан долоон заалт» гэх хоч авсан нэмэлт, өөрчлөлт оруулсан. МАХН цаашдаа сонгуульд хэзээч ялагдахгүй гэх тооцоонд үндэслэсэн энэхүү өөрчлөлтөөр *нэгд*, цөөнхийн зүгээс УИХ-ын үйл ажиллагаанд хуулийн хүрээнд шахалт үзүүлэх, шаардлага тавих (бойкот хийх) үүд хаалгыг бүрэн хаасан, *хоёрт*, эрх баригч намын удирдлагыг гартаа атгасан цөөн бүлэг этгээдүүд төр засгийн эрх мэдлийг мөнхөд эзэгнэх, хууль бусаар хөрөнгөжих сонирхолоо хангах нөхцөл бүрдүүлсэн, *гуравт*, коммунист засаглалын үед оршин тогтнож байсан нам төвтэй төрийн тогтолцооны олон механизмыг сэргээн тогтоосон, *дөрөвт*, засаглал хуваарилах парламентат ёсны зарчмыг ихэд алдагдуулсан байна. Шинэ үндсэн хуулийн тулгуур үзэл санаа, зохицуулалтад зэрлэгээр халдсан энэхүү балмад шийдвэрийн горьг монголчууд өнөөдрийг хүртэл эдэлсээр байна. Цаг, хугацаа өнгөрөх тутам түүний хөнөөх аюул, учруулах хохирол өсөн нэмэгдэж буйг бодит байдалд харсаар байна.
2. Төрийн чухал албан тушаал, шийдвэр гаргах эрх мэдлийг мөнгөөр худалдах бусармаг замд халтиран орж, төрийн албаны чадамж, нэр хүндийг унагаан улс төрийн болон төрийн захиргааны ажлын баримжаа багатай, чадваргүй хүмүүс засаглалд олширсон. Тэд ганц олдсон боломжоо ашиглан, зорилгоо хангахад гаргасан зардал буюу шархаа нөхөх, илүү ихийг авах идэхэд шунах болсон. Гэмт үйлдэл үүгээр хязгаарлагдсангүй.
3. Гэмт бүлэглэлүүд хувьчлагдах өмч хөрөнгийн үнэ ханшийг унагааж эсвэл өсгөх замаар ашиглал үйлдэх, гол төлөв гадаадын хүмүүст газар наймаалах, лиценз худалдах, ашигт малтмалын том ордуудаа монгол хүнд ямарч өгөөжгүйгээр ашиглуулах зэрэг гэмт хэрэг үйлдэж, хууль бусаар олсон их мөнгөөр хахуульдаж санасан бүхнээ гүйцэлдүүлэх болов.
4. Үүссэн нарийн төвөгтэй нөхцөл байдал болон ардчилсан хүчнүүд эв, эеэ нэгтгэх бодит шаардлагыг харгалзан 2000 онд Монголын Үндэсний Ардчилсан Нам /МҮАН/, Монголын Социаль Демократ Нам /МСДН/, Монголын Ардчилсан Сэргэн Мандлын Нам /МАСМН/, Монголын Ардчилсан нам /МоАН/, Монголын Шашинтний Ардчилсан Нам /МШАН/ зэрэг улс төрийн 5 нам нэгдэж, Ардчилсан Нам байгуулагдсан нь монголын улс төрийг эрүүлжүүлэхэд чиглэсэн бас нэг чухал алхам байв. Ийнхүү МАХН-тай эн тэнцэхүйц улс төрийн хүчийг нэгтгэж чадсан нь нэн чухал үр дүн болсон. Энэхүү нэгдлийн гол ач холбогдол нь хэрвээ өөрсдөө олигтой ажиллаж чадвал зорилго, зорилгоо хэрэгжүүлэх, улс төрийн идэвхтэй үйл ажиллагаа явуулах боломж нээгдсэнд оршино.

УЛС ТӨРЧ ХЭМЭЭХ ЗАРИМ ЗАЛУУСЫН ЁС СУРТАХУУНЫ ЯЛЗРАЛ

“Сайн ах, эгч нар”-ын үзүүлж байгаа дээр дурьдсан түмэн хар нүгэл дагуулсан гэмт үйлдлүүд нь залуу үеийг хар тамхи мэт хордуулан ёс суртахууны ялзралд оруулж эхэлсэн. Зарим залуус эрдэм номд шамдах, хөлсөө дуслуулан оюунаа чилээж, хичээн хөдөлмөрлөхийн оронд аль нэг нөлөө бүхий улс төрийн намын нөмөр нөөлгөд багтах, эрх мэдэлтний цүнх барьж шарвалзан дагасаар мөнгөжихийг чармайх болов. Тэдэнд үзэл бодол, итгэл үнэмшил, түмэн олны эрх ашиг гэгч зөвхөн мэдээллийн хэрэгслээр шүлсээ үсчүүлэн ярих төдий зүйл болжээ. Асар их баялаг нөөц бүхий Өмнөговийн Оюу толгой, Таван толгой, Сэлэнгийн Төмөртэй, Сүхбаатарын Төмөртолгой, Ховдын Хөшөөт, Дорноговийн Дулаанхайрхан, Дорнодын Тосон-Уул, Дорноговийн Зүүнбаян зэрэг стратегийн ордуудыг гадаадын хүнд эзэмшүүлэн Монгол хүнд өгөөжгүйгээр ашиглалтад оруулсан, эрх мэдэл албан тушаалаа ашиглан түмэн үед шигшигдэх гэмт хэргүүд үйлддэгдсэн баримтууд үүний нотолгоо болно.

БҮДГЭРЭН МАНАНТСАН МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ

Дээр дурьдсан эмгэнэлт, аймшигт жүжиг мэт нөхцөл байдал нь монголын ирээдүйг бүдгэрүүлэн манантуулж байна. Үүнийг сүүлийн 23 жилд манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүн оны үнээр /1990 онд 10.4 тэрбум, 2014 оны ХБГ 21661.2/ бараг 2200 дахин өссөн байхад хүн амын бодит орлого худалдан авах чадварын хувьд 25 жилийн өмнөхөөс өсөөгүй буурсан, иргэдийн мөнгөн хадгаламжийн 98 хувийг хүн амын 2 хүрэхгүй хувь эзэмшдэг, хүн амын 80 хувь ядуу зүдүү, 5 хүрэхгүй хувь нь хэт баян чинээлэг амьдарч байгаа, нийгэмд зохион байгуулалттай гэмт хэрэг, авилгал улам бүр газар авч байгаа зэрэг баримтаас харж болно.

ГАРЦ ХАЙСАН ШИНЭ ҮЕИЙНХЭН

Эдүгээ залуу үеэ хүмүүнжүүлэх асуудлыг өнөөгийн төрийн болон улс төрийн намуудын баримталж байгаа бодлого, үйл ажиллагааны хүрээнд шийдвэрлэх боломжгүй гэж үзэж зарим саналаа илэрхийлж байна.

1. ЭДИЙН ЗАСАГ, СОЦИАЛ ХҮРЭЭНД

1. Эдийн засгийн эргэлтэд оруулах нүүрснээс бусад ашигт малтмалын ордоо Оюу толгой, Цагаансуврага, Улаан, Цав, Төмөртэйн овоо, Төмөр толгой, Асгат зэрэг одоо ашиглагдаж байгаа ордуудаар хатуу хязгаарлаж, цаашид томоохон ордууд нэмж ашиглалтад оруулахгүйгээр хойч үедээ өвлүүлэн үлдээх бодлого хэрэгжүүлэх
2. Ашигт малтмалынхаа боловсруулалтын түвшинг ахиулах, үнэт эрдэнэсээ хүдэр хэлбэрээр гадагш зөөхөөс аль болох татгалзах
3. Зэс хайлуулах перометаллургийн заводыг зэсийн олборлолтоо түшиглүүлэн,

- хар төмөрлөгийн заводыг төмрийн хүдрийн ордуудаа түшиглүүлэн шинээр барьж байгуулах
4. Нүүрсний нөөцөө түлшинд хэрэглэхийн зэрэгцээ энерго-технологийн чиглэлээр боловсруулж, кокс, шингэн түлш, хийн бүтээгдэхүүн болгон хувиргаж, химийн үйлдвэр хөгжүүлэх
 5. Зэс олборлох талаар хуримтлуулсан туршлага, бэлэн технологи, мэрэгжилтэй, мэрэгшилтэй ажилтнуудтай зэрэг боломждоо тулгуурлан Дорноговь аймгийн Цагаансуваргын ордыг цэвэр өөрийн хүчээр олборлох
 6. Газрын тосны ордуудаа түшиглүүлэн эхлээд Дорноговь аймгийн Зүүнбаянгийн районд цаашдаа Дорнод аймгийн Матадын районд газрын тос боловсруулах бага оврын үйлдвэр байгуулан авто бензин, дизель түлшний хэрэгцээг өөрийн бүтээгдэхүүнээр хангах асуудлыг шийдвэрлэх
 7. Хөдөө орон нутагт бүсчилсэн байршилтай, малын мах, ноос, сүү, арьс шир, улаанбуудай зэрэг бүтээгдэхүүн боловсруулах чиглэлтэй, түүхий эд бэлтгэж нийлүүлэгчид, малчдын дундын өмчийн үйлдвэрүүдийг хамгийн орчин үеийн шилдэг технологиор тоноглож, улсын төсвийн болон зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр барьж байгуулах, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний илүүдэл хэсгийг үнэ хүргэж гадаад зах зээлд борлуулахад Төрөөс дэмжлэг үзүүлэх, Аж үйлдвэр, хөдөө аж ахуйн паркийг аймаг, сум бүхэнд байгуулах,
 8. Монгол хүн зөвхөн дотооддоо, өөрийн улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэж бэлтгэсэн мах, гурил, төмс, хүнсний ногоогоо хэрэглэх, эдгээр бүтээгдэхүүнийг экспортлохыг бүрэн хориглох
 9. Аялал, жуулчлалыг бизнесийн бие даасан салбар болтол дэмжиж хөгжүүлэх, казино, бооцоот тоглоомын газрууд нээн ажиллуулах, агнуур-жуулчлалыг хослуулах, үзэсгэлэнт дурсгалт газруудад олон талын сонирхолтой маршрут, хөтөлбөр бүхий ажиллагаатай аялал жуулчлалын тохилог төвүүд нээж ажиллуулах, жуулчдын визний нөхцөлийг хөнгөвчлөх, жуулчдын орчны аюулгүй байдлыг баталгаатай хангах
 10. Хөшигтийн хөндийн олон улсын нисэх онгоцны иж бүрэн буудлыг түргэвлэн байгуулж ашиглалтад оруулах, тус нисэх буудлыг агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдал, зорчигчийн тав тухтай байдлыг бүх талаар хангах шаардлагад нийцүүлэн тоноглож, үйлчилгээний шилдэг менежмент нэвтрүүлэх
 11. Алтанбулаг, Замын-Үүдийн чөлөөт бүсийн үйл ажиллагааг идэвхжүүлж, чөлөөт бүсэд гадаадын иргэдийг визгүй нэвтрүүлэх, тэнд ажиллах аж ахуйн нэгжүүдээс бүртгэлийн хураамж авахгүй байх, бараа тээврийн хэрэгслийг гаалийн татваргүй нэвтрүүлэх, орчны аюулгүй байдлыг хангах, шаардлагатай бол тендер зарлаж энэ талын өргөн туршлагатай гадаадын компанид эзэмшүүлэх хүртэл шийдвэртэй арга хэмжээ авах
 12. Алтанбулаг-Замын Үүдийн төмөр замын тээх нэвтрүүлэх чадлыг өргөтгөх, өмнийн говь-дорнын талыг холбосон хөндлөн төмөр зам шинээр тавихыг түргэвчлэх, шинээр тавигдах авто замын чанарыг эрс сайжруулах, өндөр хурдны авто болон босоо тэнхлэгийн төмөр замыг нэн яаралтай барьж байгуулж, ачаа эргэлтийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэх
 13. Дотоодын нийт бүтээгдэхүүний 70 орчим хувийг бүтээж, төсвийн орлогын 40 хувийг бүрдүүлж, 800 гаруй мянган хүнийг ажлын байраар хангаж

байгаа эдийн засгийн хувийн секторын талаар төрөөс тусгайлсан бодлого тодорхойлж хэрэгжүүлэх

14. Үндэсний манлай аж ахуйн нэгж үүсгэн хөгжүүлэх, хаа ч үл давтагдах үндэсний үнэт түүхий эдээ гүнзгий боловсруулан дэлхийн зах зээлд гарахыг төрийн бодлогоор дэмжих
15. Үндэсний жижиг дунд үйлдвэрүүдийн үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж буй тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас 5 хүртэл жил чөлөөлөх, мөн үйлдвэрүүдийг экспортын татвараас чөлөөлөх талаар мөрдөж байгаа одоогийн журмаа тууштай үргэлжлүүлэх
16. 9 хүртэл ажиллагсадтай, 100 сая хүртэл борлуулалтын орлоготой Үндэсний жижиг, дунд үйлдвэрүүдийг 5-10 жил санхүүгийн тайлан шаардахгүйгээр аливаа татвараас бүрэн чөлөөлж, “татварын амралт” эдлүүлэх, 10-20 хүртэл ажиллагсадтай 100-500 сая хүртэл төгрөгийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдээс жилд нэг удаа санхүүгийн тайлан авч тогтмол татварт шилжүүлэх
17. Иргэдээ хөрөнгийн зах зээлийн сургалтад үнэ төлбөргүй хамруулах, хувьцаа эзэмшдэг компанийн нь үйл ажиллагаанд оролцуулах, хувьцаагаа захиран зарцуулахад нь төрөөс дэмжлэг үзүүлж, зөвлөгөө өгөх өргөн хүрээтэй ажил зохион байгуулах
18. Нийт иргэд ялангуяа залуучууддаа зах зээлийн мэдлэг боловсрол, амьдралын арга туршлага олоход нь, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настай ахмадууд, нялх балчир үрсээ ая тухтай амьдрахад нь дэмжлэг үзүүлэх хэрэгт уул уурхайн бизнесийн орлогын тодорхой хувийг тусгайлан зориулах, энэ зориулалтаар сан бүрдүүлж ашиглах ...

2. ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ, УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД

Олон нам

1. Улс төрийн намууд бүгдээрээ хамтран зорих асуудлуудаа урьдчилан тохирох
2. Намууд урьдчилан нэгэнт тохирсон зорилго, зорилтод хамгийн бага зардлаар, хамгийн богино хугацаанд хүрэх арга замаа санал болгох хэлбэрээр сонгуулийн хөтөлбөрөө боловсруулдаг байх
3. Нийт иргэдээ улс төрийн намын харьяалалгүй болгох, тухайн намын төлөө саналаа өгсөн иргэд түүний дэмжигчид байх журамд шилжих
4. Намуудыг зөвхөн УИХ-д авсан суудлын тоог нь харгалзан тооцож олгосон төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх, дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн намууд нэгдсэн нэг байранд байрладаг байх
5. Одоогийн улс төрийн намуудын эд хөрөнгийг бүрэн хурааж, цаашдын санхүүжилтэд шилэн дансны аргаар хяналт тогтоох, нам санхүүжүүлэх нэрээр бүлэглэн завших гэмт хэргийг таслан зогсоох ...

Хууль тогтоох засаглал

1. Улсын Их хурлын сонгуулийг зөвхөн хувь тэнцүүлсэн хэлбэрээр явуулах, өөрөөр хэлбэл сонгогчид хүнийг биш улс орноо хөгжил дэвшилд хүргэх мөрийн хөтөлбөр бүхий улс төрийн намыг сонгох, тухайн нам өөрийн

хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадвартай гэж үзсэн хүнээ УИХ-ын гишүүнээр ажиллуулах

2. Хэрэв УИХ-ын гишүүн мэдлэг чадвар, ёс суртахууны хувьд болон бусад шинжээрээ намын хамт олны, түүнчлэн монгол түмний итгэл найдварыг алдсан бол түүнийг ямарч нөхцөлд эргүүлэн татах боломж бүрдүүлэх
3. Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх тусгайлсан бодлого хэрэгжүүлэх
4. Нийслэл, нийслэлийн дүүрэг, аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлыг татан буулгах замаар удирдлагын үргүй зардлыг хэмнэх
5. УИХ-ын гишүүдийн тоог цөөлж, дээд, доод танхимтай болгох тогтолцоог судлаж оновчтой шийдэлд хүрэх
6. УИХ-ын гишүүд Засгийн газрын гишүүн болон өөр ажил хавсран гүйцэтгэхийг бүрэн хориглох ...

Гүйцэтгэх засаглал

1. Орлогч сайд, бага дунд тушаалын дарга нарын орлогчид (зайлшгүй шаардлагатайгаас бусад)-ын орон тоог цомхотгох
2. Төрийн албаны зөвлөл, Хүний эрхийн үндэсний комиссыг татан буулгаж одоогийн чиг үүргийг нь төрийн яам, агентлаг бүрт хариуцуулах
3. Зарим яамд, агентлагуудын үйл ажиллагааны давхардлыг бүрэн арилгах
4. Улс төрийн намууд гишүүнчлэлгүй байх тул УИХ-ын сонгуулийг гүйцэтгэх засаглалын байгууллагууд зохион байгуулж Сонгуулийн ерөнхий хороог татан буулгах
5. Төрийн мэргэшсэн албан хаагчийн сонгон шалгаруулалтыг мерит зарчмаар буюу Чингис хааны хэрэглэж байсан аравтын шалгарлаар хэрэгжүүлэх, өөрөөр хэлбэл төрийн албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л эрх мэдлийг удирдлагын тухай, тухайн нэгжийн хамт олонд, удирдлагын анхан шатны нэгжид бүрэн шилжүүлэх
6. Төрийн албаны бүхий л ажил хэрэг зөвхөн урьдчилан тогтоосон стандартын дагуу хэрэгждэг байх, энэ зорилгоор эрх зүйн шаардлагатай орчин бүрдүүлэх
7. Нутаг дэвсгэрийн удирдлагын төвлөрлийг задалж эрх мэдлийг орон нутагт шилжүүлэх, эхлээд аймгуудыг бие даан санхүүжих чадвартай байхуйц оновчтой ангилалын дагуу бүсчилэн хөгжүүлж, аажимдаа засаг захиргааны томсгосон хуваарьт шилжих
8. Төрийн албан хаагчийг 7 хоногт 6 өдөр ажиллуулдаг журамд шилжих-????
9. Нийслэл хотыг нүүлгэж Хархорины орчимд шинээр байгуулах ...

Шүүх засаглал

1. Үйлдэгдсэн гэмт хэрэгт хуулийн ямар зүйл, заалт тохирохыг л шүүгч шийддэг байх, үүний тулд шүүхийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй, олон түмний хяналт дор хэрэгждэг байхаар зохион байгуулах
2. Буруу ташаа шийдвэр гаргасан шүүгч, прокурор, өмгөөлөгч зэрэг хуульчдын эрхийг хасаж, түүнийг дахин хэзээ ч тухайн мэргэжлээр ажиллуулахгүй байх журам тогтоох
3. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах, ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтыг, сэжигтэн, яллагдагчид үзүүлэх өмгөөллийн үйлчилгээг ял завшуулах эсвэл хүн хэлмэгдүүлэхээс сэргийлэх найдвартай

хамгаалалт болгон шинэчлэх, шүүх, прокурор, өмгөөлөл ямар нэг хий зай гаргахгүйгээр харилцан хүндэтгэлтэй, уялдаа холбоотой ажиллах явдлыг чухалчлах

4. Ёс зүйг яг таг баримталдаг, чин шудрага хүмүүст танил тал нөлөөлдөггүйг, ийм ёс суртахуун хичнээн үнэ цэнэтэйг хэлсэн “Цогт тайж” киноны Гүн баатрын дүр үзэгчдийг татаж чадсан, ийм ёс суртахуун бүхий шүүгчдийг бодлого, төлөвлөгөөтэй бэлтгэх
5. Шүүхийн байгууллагад шинээр орсон хуульчдыг хамгийн доод албан тушаалаас эхлэн хамт олны саналаар удирдах албан тушаалд шат алгасалгүй дэвшүүлж, боловсон хүчнийг чадваржуулж, дотоод хяналтыг сайжруулах
6. Шүүх засаглалын ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах нөхцөл бололцоог нь хангах, гэхдээ “Алтан загасны үлгэр”-т гардаг эмгэний шунал хаан болоод ч хангагдаагүй гэх үлгэрийн сургамжийг бодолцох
7. Гэмт хэргийн эзэн холбогдогчийг тогтоож, ял оноох, хашраахын зэрэгцээ гэмт хэрэг гарах болсон шалтгаан нөхцөлийг арилгах, ялангуяа ядуурлыг бууруулахад төрийн бүх хүч хэрэгслийг чиглүүлэх ... зэрэг болно.

ДҮГНЭЛТ

Энэхүү илтгэлд шийдвэрлэх шаардлагатай зарим асуудлуудыг хөндөв. Болж бүтэж байгаа зүйлээ ярихад оройтохгүй. Нийгэмд хуримтлагдсан эдгээр тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, хөгжил дэвшлийн гэрэлт ирээдүй цогцлоох үйлсийг гагцхүү залуучууд, бидний хойч үе бүтээн босгож чадна. Бидний хөндсөн асуудалд өөр өөрсдийн үзэл бодлын үүднээс хандаж санал бодлоо хуваалцахыг Та бүхнээс хүсье.

“1990 оны Ардчилсан хувьсгалд залуусын оролцоо” сэдэвт илтгэлийн хэлэлцүүлэг



Асуулт: Сонирхолтой илтгэл тавьсан Танд баярлалаа. Таны илтгэлийн хүрээнд хөндөгдсөн зүйлүүдэд санал нийлэх, нийлэхгүй зүйл байна. Тухайлбал, Сонгуулийн ерөнхий хороог татан буулгая, Засгийн газар сонгуулийг зохион байгуулая, Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг татан буулгая гэсэн зүйлүүдийг хөндөж ярилаа. Энэ нь тагадгүй ардчилалаас ухарсан зүйл болох юм биш байгаа. Хэрэв таны хэлж байгаа зарчмуудаар асуудлыг шийдээд явъя гэвэл Үндсэн хуулинд маш том өөрчлөлтүүдийг хийх хэрэгтэй болох байх. Мөн цаашид бусад хуулиудад ч өөрчлөлтүүд орох байх. Энэ тал дээр Та ямар байр суурьтай байна вэ?

Ж.Баасандаш: Би таньтай санал нэг байна. Дээр дурьдсан зарчмуудыг авч хэрэгжүүлбэ гэвэл Үндсэн хуулинд маш том өөрчлөлтүүд орох ёстой. Энд та



бүхэнд танилцуулж байгаа зүйл бол илтгэгч нарын санаа байгаа юм. Бид энэ илтгэлийг тавихдаа өнөөдөр энд Монголын сор болсон сэхээтнүүд, олон талын мэдээлэлтэй хүмүүс, аливааг эргэцүүлж, тойруулж хардаг хүмүүс цугларсан байгаа учраас та бүхний дунд санаа болгож энэ асуудлыг гарган тавьж байгаа юм. Та бүхэн бидний илтгэлээс авахыг нь авч гээхийг

нь гээж болох юм. Бидний хэлэлцүүлж байгаа илтгэлд НӨУБ-ыг үгүй болгох асуудал дурьдагдаагүй, харин ч иргэдийн оролцоог улам өсгөх хэрэгтэй, нутгийн удирдлагыг улам чанаржуулах хэрэгтэй, анхан шатны нэгж байгууллагуудын эрх мэдлийг өргөжүүлэх хэрэгтэй, төрийн төвлөрлийг задлах хэрэгтэй. Бид өнгөрсөн 25 жилд шавар байшин нураасаар байгаад 25 жил болсон. Одоо хүмүүсийнхээ, иргэдийнхээ сэтгэлгээг нь өөрчилье, хүмүүсийнхээ эрх мэдлийг гарт нь өгье, байшин нураахаа больё л гэж байгаа юм.

Д.Баасанхүү: Миний хувьд Залуучуудын идэвхи оролцоо өнөөдөр яагаад муу байгаа талаар өөрхийнхөө бодож явдаг зүйлээ хэлэх гэсэн юм. Нэгдүгээрт, 1930 оноос хойш үй олон хүний хэлмэгдүүлэлт явагдсан байдаг. Энэ цагаас хойш монгол улсын төр засаг, улс төрийн намуудаас хэлмэгдэгсдэд чиглэсэн цэгцтэй арга хэмжээ аваагүй байна. Хоёрдугаарт, 2008 оноос хойш маш олон залуучууд эвлэлдэн нэгдэж дарга нартай уулзаж санаа бодлоо илэрхийлэх хүсэлт тавьдаг боловч дарга нар тэднийг бодитойгоор хүлээн авч саналыг нь сонсдоггүй. Энэ мэтчилэн маш олон асуудлууд байдаг. Эдгээр асуудлаас болоод залуучуудын зориг, санаа бодлыг мохоож байгаа юм. 2008 оны үйл явдлыг харж байхад залуучуудыг мохоосон. Залуучуудын улс төрийн боловсрол, мэдлэг дутмаг байна. Төрийн албан хаагчид, улс төрчид ширээний ард асуудлыг шийдвэрлэдэггүй, хойшлуулдаг, орхигдуулдаг, дүйвээдүүлдэг гэх мэт элдэв янзын аргаар мултарсаар байна. Энэ нь цаашилсаар байгаад залуучуудын оролцоо улам муудаж байх шиг байна. Хуулиндаа өөрчлөлт оруулж арга хэмжээнүүдийг зөв байдлаар нь шийдвэрлэж баймаар байна.

Ж.Баасандаш: 1990 онд ардчилал эхэлсэн. Өнөө үед улс орноо өөд нь татах нь залуучууд та бүхний гарт байгаа юм шүү. Хүн амын дотор баян хоосны ялгарал гарчихсан байгаа. Монголын ард түмний аж амьдралыг сайжруулахын тулд энэхүү ардчиллыг хийсэн.

Санал: 1937 онд хэлмэгдэл явагдаж их олон хүнийг устгаж буруутгаж байсан. Энэ байдал өнөө үед манайд мөн давтагдах гээд байгаа юм биш биз дээ. Энэ асуудал аливаа улс төр, хуулийн хэлэлцүүлгийн асуудалд оролцох оролцооны талаар хүн бүрийн боловсрол, мэдлэг дутмаг байгаатай холбоотой юм.





АРДЧИЛАЛ ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТЭГШ ЭРХИЙН АСУУДАЛ

Ц. Оюунгэрэл

*УИХ-ыг гишүүн, Ардчилсан
Эмэгтэйчүүдийн Холбооны тэргүүн*

Энэ онд монголчууд бид ардчилсан хувьсгалын 25 жилийн ойгоо тэмдэглэж байгаа билээ.

Бидний Ардчиллын түүхэнд үргэлж хамт байж, биднийг дэмжиж ирсэн нэгэн байгууллага бол Конрад-Аденауэр-Сан билээ. Энэ байгууллага 1990 оноос хойш Монголын ардчилсан хөгжлийг бэхжүүлэн ард түмэн, олон нийтэд ардчиллын үнэт зүйл, түүний мөн чанарыг түгээн, ойлгуулахад үргэлж бидэнтэй хамт байсанд гүнээ талархаж явдгаа энэ дашрамд илэрхийлье.

Конрад-Адерауэр-Сангийн түнш байгууллагуудын нэг бол Ардчилсан Намын дэргэдэх Ардчилсан Эмэгтэйчүүдийн Холбоо билээ. Бид Ардчиллын үнэт зүйлийг олон нийтэд тэр дундаа эмэгтэйчүүдийн хүрээнд түгээн, тэднийг улс төрд бэлтгэхэд онцгойлон анхаарч ажилладаг. Энэ ч утгаараа бид өөрсдийгөө төрдөө ардчилсан үзэлтэй, хүний эрх эрх чөлөөг дээдэлдэг эмэгтэй улс төрчийг бэлтгэх гол үүрэг бүхий байгууллага хэмээн үзэж өндөр хариуцлагатай ажилладаг. Иймээс бидэнтэй ойр дотно ажилладаг байгууллагууд маань энэхүү үнэт чанарыг ойлгож мэдэрдэг, түүнийг хуваалцаг байгууллагууд байдаг. Түүний нэг бол яахын аргагүй Конрад-Адерауэр-Сан юм.

Конрад-Адерауэр-Сан, Ардчилсан Эмэгтэйчүүдийн Холбоотой хамтран маш “даруухан” тогтвортой харилцааг бий болгосон гэж би үздэг. Даруухан гэж байгаагийн учир нь бид өндөр зардлаар улс төрчдийг бэлтгэнэ гэдэгт итгэдэггүй, аль болох бага зардалаар хүмүүсийн итгэл үнэмшилд суурилан улс төрчдийг бэлтгэх үйл ажиллагааг хамтдаа явуулдаг. Түүнчлэн нөгөө талаас энэ харилцааг би тогтвортой хэмээн нэрлэмээр байна. Учир нь хэн нэгний, аль нэг байгууллагын үйл ажиллагааг тасалдуулах, гэнэтийн цочролд оруулах хүнд зүйлийг бид бие биенээсээ нэхэж шаарддаггүй, харин ч тогтвортой бага зардлаар итгэл үнэмшилд суурилсан үйл ажиллагааг хамтран зохион байгуулдаг. Миний бие Ардчилсан Эмэгтэйчүүдийн Холбооны тэргүүнээр сонгогдсон цагаас хойш эдүгээ 4 жилийн хугацаанд Конрад-Адерауэр-Сантай хамтран зохион байгуулсан ажил бүхэн амжилттай болдог. Бидний хамтын ажиллагааны

амжилтын үр дүнд манай Ардчилсан Намын эмэгтэйчүүд ч амжилтанд хүрсээр байдагт оршино.

Ганцхан жишээ баримт дурьдахад намайг Ардчилсан Эмэгтэйчүүдийн Холбооны тэргүүн хэмээх сонгуульт албан тушаалыг хүлээж авахад Ардчилсан Намаас УИХ-д нэг ч эмэгтэй гишүүн, сайд байгаагүй. Нам дотор ч намын дарга эмэгтэй, тэр битгий хэл орон нутгийн намын дарга эмэгтэй огт байдаггүй байсан. Мөн орон нутгийн сонгуульд эмэгтэйчүүдийн эзлэх хувь маш бага байв. Үүнийг бидний гол өрсөлдөгч болох МАН-тай харицуулахад манай эмэгтэйчүүдийн амжилт МАН-ын эмэгтэйчүүдийн амжилтын 30%-тай л тэнцэхүйц байсан юм. Бид ийм бага түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нам дотроо төдийгүй улс төрийн орон зайд хангаж явсан нам байжээ.

Гэтэл Конрад-Адерауэр-Сантай хамтран ажиллах явцдаа бид эмэгтэй хүнийг улс төрд оролцуулахын тулд тодорхой шатанд өөрт нь тохирсон бэлтгэлийг хангах нь зөв зүйтэй болохыг ойлгосон. Энэ бол Герман улсын туршлага төдийгүй, Германчууд эмэгтэйчүүдээ улс төрд оролцуулахын тулд түүнийг өөртөө итгэх итгэлийг нь нэмэгдүүлэх, гэр бүл, хамт олон, намын гишүүдэд нь хүлээн зөвшөөрөгдөх ажлыг дэс дараатайгаар хийсний үр дүнд эдүгээ эмэгтэй Канцелиртай орон болж чадсан билээ. Бид энэ туршлагыг өөрсдийн намд хэрэгжүүлэхийн тулд Конрад-Адерауэр-Сангаас маш их зүйлийг суралцаж ажилласан. Ингээд нэн тэргүүнд эмэгтэй хүнд тохиолддог хамгийн энгийн бэрхшээл юу байдгийг олж харахыг хичээсэн.

Олон хүмүүс Монгол Улсын эмэгтэйчүүд өндөр боловсролтой, эрэгтэйчүүдээс илүү их дээд сургууль төгсөж чаддаг, тэднээс илүү өндөр мэргэжилтэй учраас улс төрд илүү амжилт гаргана гэж “гэнэн”-ээр боддог. Гэтэл яг тухайн цагт эмэгтэй хүн хичнээн өндөр боловсролтой байсан ч “улс төрд орж болохгүй” гэсэн хориг саад нь эрэгтэй хүнтэй харицуулахын аргагүй их олон байдаг. Яагаад энэ хориг саад тулгардаг вэ? Энэ асуултын хариуд нэн тэргүүнд эмэгтэй хүний биологийн зохицлоос үүдэн эмэгтэйчүүд хичнээн өндөр боловсрол эзэмшин, олон их дээд сургууль төгссөн ч заавал хүүхэд гаргах хэрэгтэй болдог. Энэ мөчид эмэгтэй хүнд хүүхдээ харах, эрүүл саруул өсгөж бойжуулах, гэр бүлдээ анхаарал халамж үзүүлэх нь нэн тэргүүнд тавих асуудал болдог. Үүний улмаас тухайн эмэгтэйн улс төрийн карьер, амжилт заавал хойш татагдаж байдаг. Энэ бол эмэгтэйчүүд бидэнд байгалиас өгөгддөг улс төрийн амжилтыг арагш ухраадаг хүчин зүйл ч бас байгалиас өгч буй хамгийн их аз жаргал байдаг билээ.

Хоёрдугаарт, эмэгтэй хүн байгалиас ийм өгөгдөлтэй учир хичнээн өндөр боловсролтой ч заавал эрэгтэй хүний ард байх ёстой гэсэн үзэл нийгэмд хүчтэй суурьшсан байдаг. Учир нь гэр бүл дотор эрэгтэй хүн гэрийн гаднах, эмэгтэй хүн гэр дотрох ажлыг хийх нь зөв гэсэн уламжлалт хөдөлмөрийн хувиарлалт нь үзэл санааны хувиарлалт болон бидний нийгэмд эзлэх байр суурийг хүссэн хүсээгүй хуваадаг. Эмэгтэй хүн учраас хэрэггүй, байж бай, хүлээ, гэртээ үлд харин эрэгтэйгээ явуул гэсэн дохиолол бүхий чиглэл бидний гэр бүл, найз нөхөд, хамт олон намын гишүүд, хамтран зүтгэгч нарын зүгээс байнга ирж байдаг. Ихэнх хүмүүс эмэгтэй хүнийг нь хамгийн сайн туслагч, зөвлөх, мэргэжилтэн, гарын үзүүрийн хүн, нарийн бичиг гэж харахаас хэн ч эмэгтэй хүнийг хамгийн сайн удирдагч гэж хардаггүй. Ийм учраас эмэгтэй хүнийг “та удирдагч мөн, удирдагч байж чадна” гэдгийг өөрт нь хэлж итгүүлж үнэмшүүлнэ гэдэг нь эмэгтэйчүүдийг

улс төрд оруулах хамгийн анхны даваа байдаг. Энэ давааг давах ажлыг бид Конрад-Адерауэр-Сантай хамтран зохион байгуулахыг хүссэнээр бид хамтдаа олон амжилт гаргасан. Маш олон хүн өөртөө итгэх итгэлээ Конрад-Адерауэр-Сан болон Ардчилсан Эмэгтэйчүүдийн Холбооны хамтарсан сургалтаас олж авдаг. Үүнийг олж авахдаа эмэгтэйчүүд “яагаад би өөрийгөө удирдагч гэж харж байгаагүй юм бэ” гэж гайхдаг. Хариулт нь маш энгийн бөгөөд урьд нь түүнийг хэн ч удирдагч гэж харж байгаагүй бөгөөд өөрийгөө удирдагч болно гэж хэзээ ч харж үзээгүй байдаг. Энэ бол эрэгтэй хүнээс онцлог эмэгтэй хүнд тохиолддог бэрхшээл юм. Иймээс эмэгтэй хүний дотоод сэтгэлд байдаг үзэл бүхий онцлог бэрхшээлийг хамтарч даван туулахад бидний сургалт чиглэж ирсэн.

Гуравдугаарм, аливаа түүхийн номыг уншихад бид хэзээ ч эмэгтэй баатар, эмэгтэй гавьяатан, эмэгтэй хаан, эмэгтэй удирдагчийн тухай бараг олж үзэж байгаагүй. Түүхийн хичээл бүхэлдээ эрэгтэй хүмүүсийн тухай байдаг. Үе үеийн хаадууд эрэгтэй байсан төдийгүй цөөхөн хэдэн хатан санамсаргүйгээр буюу хаан нас барснаар богино хугацаанд төрөө удирдсан байдаг. Бидэнд нийгмийн жамаар нэг эмэгтэй удирдагч төрөн гарч түүний араас дараагийн эмэгтэй удирдагч төрөн гарах энэхүү тэгш эрхэт нийгмийн жам ёсны хичээл ордоггүй. Сургуульд бидтүүхэн гавьяаг зөвхөн эрэгтэй хүмүүс бүтээн байгуулсан, цаашдаа ч тэд түүхийг бүтээнэ гэдэг хандлага бүхий үзлийг далд ухамсарт шингээж ой тойнд буулгасан түүхийн номуудыг уншиж өсдөг. Уран зохиолд ч гэсэн энэ байдал ижил. Ихэнх гол дүр нь эрэгтэй баатар байх төдийгүй үлгэрт эмэгтэйчүүдийн дүрийг тусгахдаа сайн эр хүнийг мөрөөдсөн, хаан, ханхүүтэй учрахыг хүссэн гүнжүүд л оршдог. Хүүхэд байхаас эхлэн уншиж сонссон үлгэр домог, түүх судлалаас бидний далд ухамсар болон эргэн тойронд “эмэгтэй хүн бол удирдагч биш” гэсэн мессэжээр хүрээлэгддэг. Энэ бол өндөгөөр зүйрлэвэл маш том хальс юм. Тэр хальсыг цоолж гарч ирж ангаахай, дэгдээхий болж жигүүр дэвэн нисэхэд бэлдэнэ гэдэг эмэгтэй удирдагчийг бэлтгэх бидний хамгийн гол ажил юм. Ийм ч учраас эмэгтэй удирдагчийг бэлтгэх эмэгтэйчүүдийн байгууллага маш чухал үүрэгтэй байдаг.

Эрчүүдэд зориулсан байгууллага албан ёсоор байх шаардлагагүйгээр тэд байнга өөрсдөө нэгддэг. Эрчүүд хамтдаа гольф, фоло тоглон нум сум харваж, бөх барилдан, морио уяна. Тэд байнга клубын зарчмаар нэгдэн ажиллаж бие биенээ дэмждэг. Манай улсын нийгэмд эдүүгээ эрэгтэйчүүдийн клуб маш олон болсон. Зөвхөн уяачдын нийгэмлэгийг 300 мянган эрчүүдийг хамарсан клуб хэмээн ойлгож болно. Учир нь морь уядаг эрэгтэй бүр уяан дээрээ эмэгтэй хүнийг аваачдаггүй. Морины уяан дээр эмэгтэй хүнийг очиход “сэжиглэдэг” учраас тэр уяачдын нийгэмлэг бол эмэгтэй хүнийг нэвтрүүлдэггүй, зөвхөн эрэгтэйчүүд бие биедээ хүч, урам өгсөн тэдний том клуб болдог.

Бөхийн дэвжээ хэмээх бас нэгэн томоохон клуб бий. Аймаг, сумын, улсын дэвжээ, бөхийн гал гэж байдаг. Зөвхөн наадмын баяр ёслолоор барилдах 512 бөхийг бэлтгэхийн төлөө улсын хэмжээнд 50 мянган эрчүүд клуб болсон байдаг. Энэ мэтчилэн газар сайгүй эрчүүд олон зуугаараа нэгдэн клуб болж бие биендээ урам өгч, туршлага солилцон дэмжиж, зовж зүдэрсэн цагт нь тусалж, найрамдал үүсгэж эрчүүдийн дундах маш том клубыг бий болгосоор байдаг. Тэр клубээр дамжуулаад эрэгтэй нэр дэвшигчид маш хурдан дэмжлэг олдог. Бизнесийн салбарт ч эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү клубын зарчмаар ажиллаж чаддаг.

Гэтэл эмэгтэйчүүдэд нийгмийг эзэлсэн ийм том сүлжээ бүхий клуб огт байдаггүй.

Ингээд эргэн харахад эмэгтэй хүнийг удирдагч болгон аль нэг салбарт нэвтрүүлэхийн тулд ялангуяа олон жилийн уламжлалт соёлтой, бүхий л түүхийн турш уншиж мэдсэн зүйлс маань “эмэгтэй хүн удирдагч биш” гэсэн агуулга бүхий мессэжтэй энэ цаг үед эмэгтэйчүүдийг улс төрийн хүрээнд гаргаж ирэх нь Ардчилсан нийгмийн нэг том зорилго болсон. Учир нь ардчилсан нийгэмд эрэгтэй эмэгтэй тэгш эрхтэй. Харин эмэгтэйчүүдээ дэмжиж байж энэ нийгэм маань илүү тэгш эрхтэй, тэгш оролцоотой нийгэм болон хөгжих юм. Ийнхүү нийгэмд тэгш оролцоотойгоор эмэгтэй удирдагч нарыг бий болгохын тулд эмэгтэйчүүдийн байгууллагыг зайлшгүй дэмжих шаардлалтай юм.

Ерөөс эмэгтэйчүүдийн байгууллагыг зөвхөн уяачдын клубтэй харьцуулахад 10 дахин, бөхийн дэвжээ, галуудтай хариуцуулахад 15 дахин жижигхэн юм. Биднийг уламжлалт шинж чанартай эрчүүдийн том сүлжээний хажууд маш нялх сүлжээ гэж ойлгож болно. Гэхдээ энэ сүлжээ буюу эмэгтэйчүүдийн байгууллагаар дамжуулаад эмэгтэй хүн эрчүүдийг ч, эмэгтэйчүүдийг ч, байгууллагыг ч, улсыг ч удирдаж чадна гэдгийг ойлгуулахад их нөөц бололцоо бидэнд бий. Зөвхөн үүнийг ойлгосон эмэгтэйчүүд өөртөө маш их мэдлэг боловсрол хуримтлуулж, өөрийгөө дайчилж чаддаг. Тэд эрчүүдийн хэзээ ч олж харж байгаагүй шийдлийг гаргаж ирдэг. Хүмүүсийг өөр хооронд нь эвлэрүүлж, ажлын уялдаа холбоог зангидан нэгтэх урмын үгийг хэлж, ухаантай үйлдлийг эмэгтэйчүүд хийж чаддаг.

Тэр ч утгаараа ялангуяа тайван тогтвортой хөгжүүлэе гэвэл эмэгтэйчүүдийн оролцоо нийгэмд маш их хэрэгтэй болдог. Ялангуяа ороо бусгаа цаг үе гэж ярьдаг мөчүүдэд хүмүүс бие биенээ ойлгохгүй хоёр тийшээ харж, асуудлыг хэн нь ч уншиж танилцаагүй атал өөр хоорондоо цэцэрхэн ам булаалдан, туйлширдаг. Ийм орчин нөхцөлд илүү боловсролтой, асуудалд нухацтай ханддаг аль нэг талд авталгүй төвийг сахин шийдэхэд зайлшгүй үр дүнтэй ажилладаг, нягт нямбай эмэгтэй хүн хэрэгтэй болж эхэлдэг. Ийм эмэгтэй хүн олон байснаар тухайн ажил цаг алдалгүй маш хурдацтай сайн урагшилдаг.

Эмэгтэй хүнийг олноор ажиллуулсан байгууллагуудын ажил аяандаа сайжирч их өөдрөг байдаг. Учир нь монголын эмэгтэйчүүд боловсролтой учраас тухайн байгууллагын баримт материалыг тооцоо судалгаанд суурилсан үндэслэлтэйгээр бэлтгэдэг. Ингэж асуудалд нухацтай хандаж чаддаг хүмүүс нэг шат ахин удирдах түвшинд орохын тулд бидэнд маш бага дэмжлэг л хэрэгтэй. *Нэгдүгээрт*, би өмнө хэлсэнчлэн тэдэнд өөртөө итгэх итгэлийг нь өгөхөд дэмжлэг хэрэгтэй. *Хоёрдугаарт*, уламжлалт удирдах арга барилаас илүү XXI зууны эмэгтэй удирдагчийн арга барилыг төлөвшүүлэхэд нь бид туслах ёстой.

Эмэгтэй удирдагч заавал эрэгтэй удирдагчтай адил байх албагүй. Эмэгтэй хүн учраас өөрөөр удирдаж болно. Таны энэ арга барил танд зохино, байгууллага хамт олонд чинь таалагдана, зөвхөн энэ арга барилаар ажилласнаар удирдагч эмэгтэй та зөв шийдвэр гаргана гэдгийг итгүүлэх шаардлага гардаг. Учир нь зарим эмэгтэйчүүдийг ямар нэгэн байгууллага удирдахаар очиход “хэзээ сайд хүн ийм байлаа, ийм гишүүн, дарга байдаггүй” гэсэн хандлагаар угтдаг. Тэр үед эмэгтэй дарга хүн өөр арга барилтай байж болох төдийгүй “би ийм арга барилаар удирдана, харин та нар энэ арга барилыг сурах хэрэгтэй” гэдгийг тухайн хамт

олонд зоригтой хэлэх хэрэгтэй болдог. Ингэж илэрхийлэн хэлэх хэмжээний мэдлэг мэдээллийг бид өсөж яваа дарга болсон эмэгтэйчүүддээ нэмж сургаж хэлж өгөх хэрэгтэй болдог. Өөрөөр хэлбэл удирдлагын олон янзын арга барил байдаг. Үүнээс таны онцлог, зан чанар, нийгмийн туршлагад тулгуурлаад зөвхөн энэ арга барил нь үр дүнтэй төдийгүй өөрт тань тохирно гэдгийг итгүүлэхэд, тэр үзэл бодлыг нь бэхжүүлэхэд эмэгтэйчүүдийн байгууллага, бид туслах хэрэгтэй болдог. Энэ л ажлуудыг хийхийн тулд эмэгтэйчүүдийн байгууллага зайлшгүй байх хэрэгтэй болдог. Хамгийн гол нь эдгээр ажлуудыг тасралтгүй хийх хэрэгтэй. Учир нь эмэгтэй хүн тасралтгүй төрж, хүн ам маань тасралтгүй өсөж эмэгтэйчүүдэд тохиолддог асуудал тасралтгүй үргэлжилсээр байх болно. Иймээс эмэгтэйчүүдийн байгууллага өөрөө тасралтгүй үйл ажиллагаа явуулах ёстой.

Гэтэл УИХ-аар хэлцэхээр зэхэж буй улс төрийн намуудын тухай хуулинд эмэгтэйчүүдийн байгууллагыг татан буулгах заалтыг зарим хүмүүс ярьж байна. Үүнийг би эрс эсэргүүцэж байгаа. Хэрэв эмэгтэйчүүдийн байгууллага байхгүй бол, улс төрийн намууд эмэгтэй удирдагчдаа бэлтгэж чадахгүй болно. Мөн эмэгтэй удирдагчдыг бэлтгэдэг өөр байгууллагыг дахин хаанаас ч олох боломжгүй юм. Нам дотрох эмэгтэйчүүдийн байгууллага бусад эмэгтэйчүүдийн байгууллагаас ихээхэн онцлогтой. Учир нь намын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллага нь эмэгтэйчүүдийг шууд улс төрд бэлтгэдэгээрээ илүү онцлогтой. Ингэж улс төрд эмэгтэйчүүдийг бэлдэх нь бусад салбарт эмэгтэйчүүдийг бэлтгэхээс илүү их нарийн технологи, хүчин чармайлт, итгэл үнэмшил шаарддаг тул улс төрийн намын дэргэд эмэгтэйчүүдийн байгууллага зайлшгүй байх шаардлагатай байдаг. Иймээс би улс төрийн намуудын тухай шинэ хуулиар эмэгтэйчүүдийн байгууллагыг зайлшгүй байлгах шаардлагатай гэсэн байр суурьтай байгаа юм.

Үүний зэрэгцээ эмэгтэй нэр дэвшигчид хууль, эрх зүйн орчин зайлшгүй чухал байдаг. 2008 оны УИХ-ын сонгуулиар эмэгтэйчүүдийн квот огт байгаагүй учир эмэгтэй хүн нэр дэвших боломж маш бага байсан. Харин 2012 оны сонгуулиар нэр дэвшигчийн квотыг тогтоож өгснөөр түүхэн үйл явдал болж эмэгтэйчүүд шийдвэр гаргах түвшинд буюу УИХ-д гишүүнээр сонгогдсон амжилтыг үзүүлсэн. Харин орон нутгийн түвшний сонгуульд эмэгтэйчүүдийн квот байхгүй байгаа нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог боймлож буй хэвээр байна. Цаашид сонгуулийн хуулинд бүхий л түвшний сонгуульд эмэгтэйчүүдийн квотыг тогтоож өгөх нь эмэгтэй нэр дэвшигчийг дэмжих нэгэн том алхам юм.

Түүнчлэн эмэгтэй нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилтыг багасгаж, бага төсөв зардлаар нэр дэвших боломжийг хангаж өгөх нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл сонгуулийн үеийн санхүүжилтийн асуудал нь эмэгтэй нэр дэвшигчийг хойш ухрах маш том шалтаг болдог. Учир нь эрэгтэй нэр дэвшигчидтэй адил эмэгтэйчүүдэд санхүүгийн боломж, хөрөнгө мөнгө байдаггүй учраас өрсөлдөгчиддөө хялбархан ялагддаг. Иймээс эрэгтэй эмэгтэй хүний тэгш оролцоог хангахын тулд энэхүү сонгуулийн санхүүжилтын асуудлыг тэгшитгэх, ижил тэнцүү хэмжээний санхүүжилттэй болгож чадсанаар эмэгтэйчүүдийн оролцоо тогтвортой байх юм. Эмэгтэйчүүд бол нийгмийн олонхи, ардчилсан нийгэм олонхийн хүслээр аливааг шийддэг онцлогтой. Хүн амын олонхи болсон эмэгтэйчүүдийг төлөөлөх эмэгтэй удирдагчдаа бэлтгэх хүсэл эрмэлзлэл эмэгтэй хүн бүхэнд байдаг. Энэ хүсэл эрмэлзлэлийг илэрхийлэх байгууллага нь зөвхөн эмэгтэйчүүдийн байгууллага.

Тиймээс эмэгтэйчүүдийн байгууллагыг дэмжиж явдаг бүх байгууллагууд буюу НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр, Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн, Фридрех Эбертийн Сан, Ханс Зайдлын Сан, Канад Сан зэрэгт талархал илэрхийлмээр байна. Тэр дундаа манай Ардчилсан Эмэгтэйчүүдийн Холбоог байнга дэмжиж ажилладаг, эмэгтэйчүүдийг улс төрд бэлтгэхэд тууштай, тасралтгүй хүчин зүтгэдэг Конрод-Аденаур-Сандаа гүн талархал илэрхийлж буйг минь хүлээн авна уу. Манай эмэгтэйчүүд ч Конрод-Аденаур-Санд чин сэтгэлээсээ талархаж явдгийг илэрхийлмээр байна.

Герман Монгол хоёр орны нөхөрсөг харилцаанд төдийгүй Монголын Ардчилалд үнэтэй хувь нэмэр оруулж 25 жилийн хугацаанд тасралтгүй хөдөлмөрлөж ирсэн Конрад-Аденаур-Сангийн хамт олондоо ажлын өндөр амжилт хүсье. Цаашид бидний харилцаа улам бэхжиж, тууштай хамтран ажиллана гэдэгт гүнээ итгэлтэй байна.

Та бүхэнд Ардчилсан хувьсгалын 25 жилийн ойн баярын мэндийг дахин хүргэе.

“Ардчилал дахь эмэгтэйчүүдийн тэгш эрхийн асуудал” сэдэвт илтгэлийн хэлэлцүүлэг

Ж.Баасандаш: *Надад илтгэгчээс тодруулж асуух хоёр асуулт байна. Нэгдүгээрт, манай ард түмэн эмэгтэй хүүхдээ л боловсролтой болгочихё гэсэн ойлголттой байдаг. Энэ нь төрийн чадалжид нөлөөлж байна уу? Та энэ талаар ямар бодолтой байдаг вэ? Хоёрдугаарт, би энэ эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн. Миний илтгэлдээ тусгасан нэг санаа бол төрийн удирдлагын төвлөрлийг задлая гэсэн санаа байгаа юм. Бид төвлөрсөн тогтолцооноос татгалзсан, одоо үүнийгээ жинхэнэ ажил болгоё. Үүнийг бид ажил болгохын тулд удирдлагын анхан шатны нэгжид эрх мэдлийг нь шилжүүлэх хэрэгтэй, өөрөөр хэлбэл мерит зарчмыг хэрэгжүүлэх хэрэгтэй юм. Энэ зарчимд тулгуурлаж төвлөрлийг задлах бололцоо байна уу? Эмэгтэйчүүдэд үүнийг хийх боломж байна уу? Ингэснээр танил талаар албан тушаалд томилдог асуудал үгүй болох болов уу? Энэ талаар Та ямар бодолтой байна вэ?*

Ц.Оюунгэрэл: Эхний асуулт манай монголоос бусад газарт байдаггүй чухал асуудал байдаг. Бид *rewires gender* гэсэн нэр томъёог хүртэл гаргасан байгаа. Эмэгтэйчүүд боловсрол эзэмшчихээд мөн л ялгаагүй хөдөө орон нутагт явдаг. Монгол Улсын Боловсролын Их Сургууль (МУБИС)-д жендерийн асуудлыг зохицуулах үүднээс эрэгтэйчүүдийг сургах асуудлаар квот тавьж туршилт хийж үзэж байна. Өнөөдөр МУБИС-ийн босго оноо их өндөр байгаа бөгөөд эрчүүд энд хүрэхгүй байгаа тул энэ босго оноог багасгахаар яригдаж байна. Хоёрдугаарт, төвлөрлийг сааруулахын тулд орон нутагт төсвийг захиран зарцуулах эрхийг нь өгсөн. Гэтэл ихэнх аймаг, дүүрэгт тухайн аймаг дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид захиран зарцуулж эхэлсэн. Манай Улаанбаатар хотын хэмжээнд Хан-Уул дүүрэг, Багахангай дүүрэг хоёрт л иргэд Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгийг захиран зарцуулж байна. Мөн боловсрол, эрүүл мэндийн байгууллагын удирдлагыг сонгохдоо тухайн байгууллагын удирдах зөвлөлөөс санал авна





гэсэн төсөл явж байгаа. Үүнийг дэмжинэ. Төвлөрлийг сааруулахад мэдлэг, арга барил их чухал байдаг. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр төрийн бодлого, зохицуулалтын ажлуудаар төвлөрлийг сааруулж болно гэж бодож байна.

Д.Баасанхүү: *Ц.Оюунгэрэл даргыг “Ногоон нүдэн лам” номондоо хэлмэгдэгсдийн талаарх асуудлыг авч үзсэн гэдэг талаас нь үнэлдэг. Ардчилсан намын дотоод ажлын зохион байгуулалтыг бид сайн мэдэхгүй байна. Таны сургалтанд хамрагдсан этэгтэйчүүдийн хэдэн хувийг хэлмэгдсэн этэгтэйчүүд эзэлдэг вэ? Тэдний шагнал уралшууллын асуудлыг хэрхэн шийдвэрлэж, тусалж байсан бэ?*

Ц.Оюунгэрэл: Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн асуудал миний хувьд их ойр байдаг асуудал. Ардчилсан намын дотоод ажил, төлөвлөгөөнд эдгээр хүмүүсийн талаар санал оруулж байгаагүйдээ хүлцэл өчье. Энэ асуудлыг тодорхой түвшинд ярьж санал болгоно гэж бодож байна. Цагаатгалын тухай хууль УИХ-аар орох үед надад тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлж чадвал бусад гишүүддээ нөлөөлж чадна гэж амлаж байна. Хэлмэгдсэн хүнийг шагнуулах асуудлыг хөөцөлдөж огт үзээгүй, харин хөгжлийн бэрхшээлтэй хоёр дуучныг гавьяат болгох асуудалд хүчин зүтгэж үзсэн юм байна.

Санал: Өнөөдрийн бага хурлаар Ардчилалд иргэдийн оролцоог хэрхэн нэмэгдүүлэх тухай олон зүйл ярилаа. Би насаараа багшилж байгаа багш хүн. Манай ЕБС-уудад багш нар залуу үеэ сургах, хүмүүжүүлэх асуудалд байнга санаа тавьж ажилладаг. Хүүхдүүдийг сургаж байхад хүүхдүүдэд харилцан адилгүй зүйл олон байдаг. Манай монгол хүүхдүүдийн оюун ухаан, мэдлэг чадвар дэлхийд гайхагдаж байна. Энэ талаас нь та бүхэн дэмжиж, тусалж байхыг хүсье. Залуучууд нийгмийн ажилд оролцох нь их дулимаг, хойрго байгаа нь ажиглагддаг. Гэтэл залуучууд маань эрүүл мэнд, биеийн тамир, амьдрал ахуй, боловсролдоо ихээхэн анхаарч байх хэрэгтэй. Гэгээлэг, хүмүүнлэг, энэрэнгүй байдлаар нийгэмтэйгээ зэрэгцэн алхаж баймаар байна. Хэлмэгдэгсэд одоо тун цөөхөн болсон байгаа, тэдний асуудал, үр хүүхдүүдийнх нь асуудлуудыг шийдвэрлэж өгч туслаарай.



АРДЧИЛАЛД ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦОО ЧУХАЛ БОЛОХ НЬ

Х.Нотингэрэл

*“Оорчлолтийн төлөөх залуу элэгтэйчүүд”
ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн*

Бүтэц

- Залуучуудын улс төрийн оролцоо
- Залуучуудын ардчиллын талаарх ойлголт
- Залуучууд яагаад оролцох ёстой вэ?
- Залуучуудын оролцоог хэрхэн нэмэгдүүлэх вэ?

Залуучуудын улс төрийн оролцоо

- 1990-ээд оноос хойш иргэдийн сонгуульд оролцох оролцоо дэлхий даяар буурч, дунджаар 64%, гол шалтгаан нь залуучуудын хүн амд эзлэх хувь ба тэдний оролцоогүй байдал (Ялангуяа албан ёсны улс төрийн оролцоо багасч байна. Намын гишүүнчлэл, сонгуульд оролцох гэх мэт).
- 15-25 насныхан дэлхийн хүн амын 5% байна.
- Үндэсний парламентад нэр дэвших эрх дэлхийн улс орнуудын 3-ны нэгд 25 нас байна.
- Нийт парламентчдын 1.65% хориод нас, 11.87 % гучаад насныхан байна.
- Дэлхийн парламентчдын дундаж нас 53 байна.

Залуучуудын улс төрийн оролцоо

- Монгол Улсын 2012 оны УИХ-ын сонгуулийн ирц 65,24%, (59,7% - 77,1%)
- Өмнөх сонгуулиар залуучуудын идэвхи тун хангалтгүй байсаар ирсэн бөгөөд энэ байдал 2012 оны УИХ-ын сонгуулиар мөн давтагдаа
- 2012 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн дундаж нас Иргэний зориг нам 37.5, МАН болон АН-ын хувьд 43-46 нас байв.
- 2012 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдыг насаар ангилж харвал
- 26 – 35 нас, Нийт 543-аас 63 нэр дэвшигч, үүнээс 45 эрэгтэй, 18 эмэгтэй.


- 26 – 40 нас, Нийт 543-аас 135 нэр дэвшигч, үүнээс 90 эрэгтэй, 45 эмэгтэй.
- УИХ-ын гишүүдийн дундаж нас 49, МАН 48, АН-ын бүлэг 48, Шударга ёс эвсэл 50, Иргэний зориг 53 байна.
- Албан ёсны улс төрд оролцох оролцоо сул
- Залуучуудын улс төрийн зохион байгуулалтууд дахь эмэгтэйчүүдийн оролцоо?

Залуучуудын ардчиллын талаарх ойлголт, итгэл үнэмшил


- Залуучуудын дунд ардчиллыг үнэлэх, түүнийг ойлгох явдал хэт ерөнхий, өнгөц, ардчиллыг туйлын эрх чөлөө, дураараа байх мэтээр төсөөлөх нь түгээмэл байна. Монголын залуучуудын ардчиллын талаарх ойлголт, төсөөлөлд гарсан өөрчлөлт судалгаа (2014)
- Улс төрийг сонирхож ажигладаг, 40.7%
- Улс төрийн кампанит ажилд оролцож байсан, 40.2%
- Улс төрийг ойлгоход хэцүү байдаг, 62.6 %
- Бид төр засагт нөлөөлж чадахгүй, 50.1%
- Бид улс төрд оролцож чадна, 59.9 %
- Монгол залуусын ардчилалд хандах хандлага. Азийн Барометр 2010 он.

Монголын залуучуудын ардчиллын талаарх ойлголт, төсөөлөлд гарсан өөрчлөлт судалгаа (2014)

Таны бодлоор Монгол Улс хэр ардчилалтай байна гэж боддог вэ? (2014 оны залуусын үнэлгээ, 2003-2006 оны дүнгийн хувьд хийсэн харьцуулалт)




Залуучуудын амьдралд ардчиллын үзүүлж буй нөлөөтэй харьцуулсан байдал
(2005-2013 оны дүнд хийсэн харьцуулалт, хувиар)



Монголын залуучуудын ардчиллын талаарх ойлголт, төсөөлөлд гарсан өөрчлөлт судалгаа (2014)

Засгийн өнөөгийн хэлбэрийг залуусын хүйсийн байдлаар харьцуулсан үзүүлэлт




- Эрэгтэйчүүдээс илүү эмэгтэйчүүд монголын ардчилалд итгэлгүй байна.

Залуучууд яагаад оролцох ёстой вэ?

- Монгол улсын иргэн бүр төрийн хэрэгт оролцох эрхтэй бөгөөд чадавхтай.
- Залуус өөрсдөө өнөөдрийн залуусын туршлага, тулгарч буй бэрхшээлүүдийг бүрэн утгаар илэрхийлж, төлөөлж чадна.
- Тэд бол ирээдүй. Ардчилсан нийгэмд амьдрах ардчилал, хүний эрхийн мэдлэг боловсрол, чадавх олгох бэлтгэл болно.
- “Оролцооны гарц байхгүй нийгэмд нэг бол нам гүм эсвэл дуулиан шуугиан л оршдог”.
- “Түлхүүрдэх боломж олгохгүй бол хаалгаа эвдүүлэх вий”

POPULATION PYRAMID 1989-2020 (AGE STRUCTURE DIAGRAM)



Залуучуудад тулгарч буй бэрхшээл


- Төр засагт, цаашлаад ардчилалд үл итгэх байдал газар авч байна. Залуучууд илүү өртөмтгий.
- Ерөнхий боловсрол дахь иргэний, ардчиллын боловсролын агуулга маш хангалтгүй байна. Иргэний нэрэн дор хэт уламжлалт, националист боловсрол байна.

- Улс төрийн намд үл итгэх байдал их. Нам нь иргэний оролцооны гарц биш дайжих шалтгаан болсон. Улс төрийн намууд ч залуусыг дэмжих, анхаарах, сонсох бодлогогүй,
- Залууст “цүнх баригч”, тэднийг хэрэгсэл гэж харах хандлага байна.
- Бүхэлдээ албан ёсны улс төрийг сонирхох сонирхол буурч байгаа, намын гишүүнчлэл, сонгуульд саналаа өгөх гэх мэт.
- Бодитой, утга учиртай оролцооны гарц бага, олж харахгүй байх, оролцуулахгүй байх, ил тод бус, мэдээлэл хангалтгүй байх.


Залуучуудад тулгарч буй бэрхшээл

- Монголын нийгэм дэх нас, хүйсийн ялгаварлал бүхий соёл, нийгмийн бүтэц. Залуучуудад үл итгэх, эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшний оролцоог үл дэмжсэн хандлага оршсоор байна.
- Нийтийн орчинд өөрийгөө илэрхийлэх хэт өндөр үнэтэй болсон.
- Хэвлэл мэдээллийн салбар хэт скандалчлагдаж иргэний оролцоог дэмжих бус үгүйсгэхэд илүү хувь нэмэр болж байна, ашиггүй мэдээг нэвтрүүлэхгүй байх.
- Технологийн хүртээмжийн ялгаа – нийгмийн ялгааг тодорхойлох түвшинд ирж байна.
- Манлайллын тухай буруу ойлголт түгсэн, манлайлагч төрдөг, сонгогддог, төгс гэсэн сэтгэлгээ, хамтын сайн дурын, төгс биш ажил гэхээсээ илүү.
- Бусдыг дэвчсэн, хүчирхийллийн арга замыг зөвтгөх хандлага, ялангуяа социал мэдиад их байгаа.
- Оролцооны чадавх сул – өөрийгөө зохистой илэрхийлэх, зөвшилцөх, зөрчлийг шийдвэрлэх гэх мэт.
- Төвлөрсөн хүчтэй эрх мэдлийг хүсэх, зөвшилцөл, процессыг үгүйсгэх хандлага ажиглагдах болсон.


Иргэний оролцооны чадавхын мэдрэмж (empowerment) (Над шиг улс төрд юу болоод байгааг тэр бүр ойлгодоггүй)



**Ардчиллын дэмжлэг
(ардчилал уу, авторитари дэглэм)**



**Ардчиллын дэмжлэг
(Эдийн засгийн хөгжил үү, Ардчилал уу)**




Залуучуудад байгаа боломж


- Нийгэм улс төрийн асуудлыг сонирхдог, идэвхтэй.
- Ардчилалд итгэдэг хэвээр, үнэт зүйлээ гэж хардаг.
- Интернет, гар утасны хэрэглээ маш өндөр түвшинд байна.
- Интернет орчинд маш идэвхтэй, албан бус бүлгүүд, хөдөлгөөнүүд, байна. Сүлжээнд суурилсан, сэдэвчилсэн кампанит ажил хэлбэртэй, интерактив, үе тэнгийн, төвлөрсөн бүтэцгүй, хурдтай.
- Олон улсын байгууллагуудын хөтөлбөртөө залуучуудын асуудлыг чухалчлах хандлагатай байна. – UN, IDEA, IPU, EU

Ардчиллын дэмжлэг

(Ардчилал сул талуудтай ч хамгийн сайн тогтолцоо)



Ардчилсан шийдвэр гаргалтын тогтолцоо



Залуучуудын оролцоог хэрхэн нэмэгдүүлэх вэ?

Ойлголтуудыг дахин тодорхойлох

- **Оролцоо** - бүх түвшинд, бүх орчид оролцооны боломжийг олж харах, хэрэглэх, гэр бүлээс эхлээд олон улсын түвшинд.
- Оролцоо - хэлбэр биш, мэдээлэлтэй, шүүмжлэлт сэтгэлгээтэй, үр дагаврыг нь ухамсарлах, хариуцлагыг нь үүрэх, бодитой хүлээлттэй байх чадавхтай байх.
- **Нийгмийн эрх мэдэл** – төвлөрсөн бус, оролцоонд тулгуурласан, тэгш эрхтэй, үе тэнгийн, мэргэжлийн бус, ил тод, мэдээлэл харилцааны шинэ зэвсэгтэй болж байна – хувь хүмүүс бусаддаа нөлөөлөх, эвлэлдэн нэгдэх илүү хүчтэй болсон.
- Ардчилал, хүний эрхийн итгэл үнэмшил төрөлхийн биш гэдгийг санах.

- Оролцохгүй байх, циник байх, ажиглагч байх нь сонголт мөн ч юу ч өөрчлөхгүй гэдгийг байнга сануулах.
- **Манлайлал** – хамтын ажиллагаа, бие биенийхээ боломж бололцоо, эрх чөлөөг тэлэхэд чиглэсэн байх.

Залуучуудын оролцоог хэрхэн нэмэгдүүлэх вэ?

Иргэний, Ардчиллын, Хүний эрхийн боловсрол

- Ардчилал, иргэний боловсролыг албан ёсны боловсролд чухалчлах, албан бус боловсролын боломжуудыг тэлэх
- Ардчиллын боловсролын ур чадварт илүү анхаарах
- Багш нарыг тусгайлан бэлтгэх
- Иргэний боловсролыг дэмжих тогтвортой улс төрийн хүсэл зориг – дийлэнх олонх тоглоомын үндсэн дүрмээ ойлгох.
- **Үндэсний түвшний сонгуульд санал өгөх ба нэр дэвших насыг ижил болгох**

Залуучуудын оролцоог хэрхэн нэмэгдүүлэх вэ?

- Залуучуудын бодитой оролцооны гарц, боломжуудыг бий болгох
- Залуучуудын байгууллагуудтай зөвлөлдөх замаар үндэсний бодлогоо сайжруулах, улс төрийн хөтөлбөрүүдэд оруулах механизм бий болгох.
- Шийдвэр гаргах түвшин бүрд, хууль тогтоох, нөөцийг хуваарилах, засгийн газрыг хянах, сонсгол, хэлэлцүүлэгт насны төлөөллийг харгалзах, залуусыг оролцуулах.
- Шийдвэр гаргах шатанд квотын системтэй газрууд цөөнхгүй байна.
- Залуу парламентчдын бүлэг байгуулан ажиллах.
- Залуучуудын парламент, зөвлөл бий болгох.
- Улс төрийн намын шийдвэр гаргалт, дотоод механизмд залуусын оролцоог нэмэгдүүлэх
- Залуучуудын сайн дурын ажлын боломжууд, гарцыг бий болгох.
- Ардчиллын боловсролын хөтөлбөрүүд, мэдээллийн төв, гарцуудыг бий болгох, дэмжих

Залуучуудын оролцоо – арга зүйн хувьд

- Үе хоорондын залгамж холбоо, менторшип хөгжүүлэхэд анхаарах,
- Интернет, сошиал медиа ашиглах, сүлжээнд суурилсан албан бус бүлгүүдийг бэхжүүлэх, санаачлагуудыг дэмжих,
- Залуусын өөрийн үүсгэлтэй, залуус өөрсдөө удирдсан төсөл хөтөлбөрийг дэмжих,
- Залуусын олон төрөл байдлыг анхаарах, хүйс, хөгжлийн бэрхшээл, технологийн хүртээмж, байршил, анги гэх мэт,
- Залуу эмэгтэйчүүдийг дэмжих тусгайлсан хандлага, хөтөлбөрүүд бий болгох,
- Орон нутаг дахь интернэтийн хүртээмжийг цаашид дэмжин, нэмэгдүүлэх,
- Анхлан сонгууль өгөх бүлэгт анхаарал хандлуулах,
- Судалгаанууд насаар ангилсан мэдээллүүдийг байнга гаргаж байх.

Санаа авах жишээнүүд:

G5008, Netherlands

DemocracyOS, Argentina

Crowdfunding, crowdsourcing, urgudul.mn

Сонгуулийн гэх мэт ажиглалтын бүлгүүд хэлбэрээр ажиллуулах

Ардчиллын хамгаалагч

=

Залуусын боловсрол

Залуусын оролцоо

“Залуучуудын оролцоо чухал болох нь” сэдэвт илтгэлийн хэлэлцүүлэг



Ж.Баасандаш: Нэгдүгээрт, Чингис хаан бондын эргэн төлөлтийн талаар нилээн их яригдлаа. Энэ талаар миний хувьд хэд хэдэн янзын хувийн бодол байдаг. Чингис хааны их өв уламжлалыг сэргээж, түүнээс суралцах тал дээр ямар бодолтой байдаг вэ? Хоёрдугаарт, залуучуудын боловсролын асуудал манайд тун туу явагдаад байх шиг байна. Ардчиллын талаарх ойлголт, түүний асуудлууд зэрэг нь залуучуудад тэдлэг болж очиж чадахгүй байгаа нь тодорхой байна. Энэ чиглэлээр цаашидаа ер нь ямар ажил хиймээр байна вэ?

Х.Номингэрэл: Таны хэлж байгаа зүйлтэй санал нийлж байна. Бид ч ялгаагүй энэ хөдөлгөөнд оролцогчид болж таарч байгаа юм. Нэг жишээ хэлбэл, уламжлал гээд эмэгтэй хүн гарахыг хориглосон уул хоёр, гурав байсан нь одоо 18 болсон нь дэмжихээргүй асуудал байгаа юм. Ийм байдлаар уламжлал сэргэх нь тохиромжгүй зүйл юм. Тэгэхээр бид энэ асуудал дээр өв уламжлалаа дагах талаар авах гээхийн ухаанаар хандах нь зүйтэй гэж бодож байна. Хоёрдугаарт, иргэдийн боловсролыг дэмжихийн тулд юу хийх вэ гэхээр албан ба албан бусаар боловсрол олгогддог. Ялангуяа албан байдлаар олгож байгаа боловсролд гол хүчээ чиглүүлэх ёстой. Ардчиллын боловсролын хөтөлбөр хийж байгаа бөгөөд улс төрийн янз бүрийн сэдвүүд нь хоорондоо өрсөлдөөд эцэслэгдэхгүй байгаа. Ардчиллын боловсрол, иргэний боловсрол, хүний хөгжлийн боловсрол гэж янз бүрээр яригдаад байгаа асуудлуудыг нэг тийш нь болгох нь зүйтэй гэж бодож байна.

Санал: Өнөөдрийн сэдвийн хүрээнд манай төр, иргэн хоёрын хоорондын холбоог залгаж өгөх сэдвийг сонгож судалгаа хийжээ. Бид коммунист үзэл баримтлалаас ардчилал руу шилжиж байгаа улс. Залуучуудын оролцооны асуудлыг хөндөж байгаа нь залуучууд юунд оролцож байгаагаа ойлгох, юунд хэрхэн хандахаа

мэдэж байх талаасаа чухал ач холбогдолтой юм. Энэ судалгаанаас харахад залуучууд оролцооноос залгах хандлагатай болж байгаа нь тодорхой юм. Залуучууд юунд хэрхэн хандах, юуг ойлгох ёстой гэдгээ сайн мэдэж авах хэрэгтэй юм. Бид дараа дараагийн хурлаараа улс төрийн намуудын энэ чиглэлд явуулж байгаа бодлого, чиглэл юу вэ? гэдэг талаас нь ярилцвал зүгээр байх. Гэхдээ өнөөдөр бид энэ асуудлыг хөндөж байгаа нь зөв юм. Илтгэгч Номингэрэлд сонирхолтой илтгэл тавьсанд баярлалаа.

Ш.Батсүх: Баярлалаа. Таныг саналаа хэллээ гэж ойлголоо. ХБНГУ-д улс төрийн боловсролын төв гэж байгууллага байдаг. Энэ төвөөс иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн янз бүрийн нийгэм улс төр, засаг захиргаа, холбооны улсын тогтолцоо, дэлхийн улс төрийн тогтолцооны талаарх ном, гарын авлага, товхимолуудыг боловсруулж иргэдэд үнэгүй хүргэдэг. Ингэж иргэдийнхээ улс төрийн боловсролд анхаарал хандуулж ажилладаг. Энэ чиглэлийн байгууллага, ном товхимолууд одоогоор манайд байхгүй байна. Удахгүй энэ асуудал шийдвэрлэгдэх байх гэж найдаж байна.

Ц.Бүжидмаа (Улс төрийн боловсролын академийн багш): Бид өнөөдрийн эрдэм шинжилгээний хурлаар улс төрийн байдал, иргэдийн оролцооны асуудлыг хөндөн ярилцаж байгаад талархаж байна. Мөн Удирдлагын академийн судалгааны баг энэ чиглэлээр олон зүйлд ашиглаж болохоор үр дүнтэй судалгаа хийсэн нь сайшаалтай байна. Илтгэгч Х.Номингэрэлийн хувьд сүүлийн үеийн зарим тоо баримтуудыг авч ашиглаагүй дутагдалтай тал байна. Манай улс төрийн боловсролын академи 2014 онд энэ чиглэлээр судалгаа хийсэн, тэр үр дүнг цаашид авч ашиглаарай. Улс төрийн оролцоонд залуучуудаас гадна эмэгтэйчүүдийн асуудал маш их чухалаар тавигдаж байгаа. УИХ-д 11 эмэгтэй ажиллаж байгаа бөгөөд 4%-д нь ч хүрдэггүй. 21 аймгийн Засаг дарга нарын дотор нэг ч эмэгтэй Засаг дарга байдаггүй. Энэ мэтчилэн улс төр дэх залуучуудаас гадна, эмэгтэйчүүдийн оролцоо маш сул байдаг. Гэхдээ миний ярьсан зүйл залуучуудын эсрэг эмэгтэйчүүдийн асуудлыг тавьсан зүйл биш шүү. Мөн миний хувьд Ардчиллын боловсролын хөтөлбөр дээр судлаачаар ажилладаг. Ардчиллын боловсрол, иргэний боловсрол гэх мэтчилэн хэд хэдэн нэр томъёо яригдаж байна. Нэр томъёоны хувьд асуудалтай, маргаантай зүйл олон байна.

Санал: Элчин сайд хэлэхдээ Германд үе дамжин сургагдаж, бэлтгэгддэг улс төрчид байдаг гэсэн. Манай монголд ч гэсэн мөн ийм Монгол-Германы хоорондын уламжлал байдаг. Өнөөдөр бид чиний, миний нам гэж маргахаас илүүтэйгээр хамтарч улс төр, улс орны бодлогыг шийдвэрлэх талаас нь үйл ажиллагаа явуулах хэрэгтэй байгаа юм.

Д.Шмюкин: Бидний хэлсэн зүйл хоосон үлдэхгүй, бид энэ хэлэлцүүлгийн дараа үр дүнг ном болгон хэвлэж та бүхэнд хүргэх болно.

Санал: Залуучуудын хувьд интернет, социал мэдээллийн системийг ашиглан мэдээлэл авах нь илүү их нэмэгдэж байна. Гэтэл эдгээр нь хэт нэг талыг барьсан, эсвэл буруу зөрүү мэдээлэл өгөх нь их байдаг. Хэвлэл мэдээллийн сувгуудын мэдээллийг хязгаарлах бус стандарт тогтоох, тухайн мэдээллийн үнэн зөв байдалд нь анхаарч, залуучуудад чиглэсэн боловсрол олгох тал дээр зохицуулалт хийх хэрэгтэй гэсэн санал байна.

Х.Номингэрэл: Хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах хоёр л гарц байдаг. Нэгдүгээрт, Хэвлэлийн хуулийн эрх зүйн асуудлыг хөндөж ярих хэрэгтэй юм. Хэвлэл мэдээллийн байгууллага нь өөрийн дотоод асуудлаа өөрийн механизмаар зохицуулж байдаг. Хоёрдугаарт, тухайн мэдээлэл үнэн болон хуурамч байна гэдгийг ялгаж харах тухай асуудал байна. Тухайн хүлээн авагчийн мэдээллийг хүлээн авч байгаа байдал, сэтгэлгээнээс шалтгаалж байгаа олон зүйл байна.



Конрад
Аденауэр
Сан

“АРДЧИЛАЛД ИРГЭДИЙН ИДЭВХИ, “ДЕМОКРАТИЕ ЛЕВТ VOM MITMACHEN” ОРОЛЦОО ЧУХАЛ БОЛОХ НЬ”

Аktive Bürgerbeteiligung in der Demokratie
Konferenz

сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал
Улаанбаатар хот, 2015 оны 05 дугаар сарын 07

Улаанбаатар, 07. Mai 2015



МОНГОЛЫН АКАДЕМИЙН УЛААНБААТАР ХОТ
УДИРДАГЧЫН АКАДЕМИ





Konrad
-Adenauer-
Stiftung



Sh.Batsukh (Hrsg.)

DEMOKRATIE LEBT VOM MITMACHEN

Aktive Bürgerbeteiligung in der Demokratie

Konferenzband

ORGANISATOREN DER WISSENSCHAFTLICHEN KONFERENZ

KONRAD-ADENAUER-STIFTUNG



DANIEL SCHMÜCKING

LANDESVERTRETER DER KONRAD-
ADENAUER-STIFTUNG IN DER MONGOLEI

- Tel.: + 976 11 319 135/136
- Fax: + 976 11 319 137
- daniel.schmuecking@kas.de



GANZAYA SENGEE

PROJEKT MENEGERIN

- Tel.: + 976 11 319 135/136
- Fax: + 976 11 319 137
- Zaya.Senggee@kas.de

VERWALTUNGS-AKADEMIE DER MONGOLEI



BATSUKH SHAIRII

VIZEREKTOR DER
VERWALTUNGS-AKADEMIE

- Tel.: + 976 70132757
- Fax: + 976 70133037
- sh.batsukh@naog.gov.mn



GANTSOOJ BADNAA

FORSCHUNGSMITARBEITER DER
VERWALTUNGS-AKADEMIE

- Tel.: + 976 70131754
- Fax: + 976 70133037
- Gantsooj@naog.gov.mn

Sh.Batsukh (Hrsg.)

DEMOKRATIE LEBT VOM MITMACHEN

Aktive Bürgerbeteiligung in der Demokratie

Konferenzband

ULAANBAATAR
2015

DDC
320
Б-34

Sh.Batsukh (Hrsg.)

DEMOKRATIE LEBT VOM MITMACHEN
Aktive Bürgerbeteiligung in der Demokratie

© 2015 Alle Rechte vorbehalten.

Der Druck des Konferenzbandes wurde von der Konrad-
Adenauer-Stiftung finanziert.

Verwaltungsakademie
Ulaanbaatar – 36
Bogd Javzandamba Strasse
Khan-Uul duureg, Mongolei
Tel.: (976) 91055262
E-mail: gantsooj@naog.gov.mn

ISBN – 978-99973-0-781-1

Druck: “Admon printing” GmbH, Ulaanbaatar

INHALT

Vorwort	4
Daniel Schmücking Rede des Landesvertreters der Konrad- Adenauer-Stiftung in der Mongolei	5
Gerhard Thiedemann Rede des deutschen Botschafters anlässlich der Konferenz "Demokratie lebt vom Mitmachen"	8
Batsukh, Sh. Bürgerbeteiligung auf kommunaler Ebene	11
Tsogtbaatar, D., Baasandash, J. Die Beteiligung der Jugend bei der Revolution von 1990	30
Oyungerel, Ts. Problematik der Gleichstellung von Frauen in einer Demokratie	43
Nomingerel, Kh. Die Bedeutung politischer Mitwirkung junger Menschen für die Demokratie	51

VORWORT

Lieber Leser und liebe Leserin, vor Ihnen liegt das Konferenzband, das von der Verwaltungsakademie der Mongolei und der Konrad-Adenauer-Stiftung (KAS) in der Mongolei gemeinsam am 07. Mai 2015 bei einer wissenschaftlichen Konferenz zum Thema *“Demokratie lebt vom Mitmachen”* entstanden ist. Diese Konferenz wurde von Dr. Daniel Schmücking initiiert, der Anfang dieses Jahres als Landesvertreter der Konrad-Adenauer-Stiftung in der Mongolei seine Stelle angetreten ist, mit dem Ziel die mongolischen Partner der Konrad-Adenauer-Stiftung in der Mongolei kennenzulernen und die weitere Zusammenarbeit zu fördern. Wir haben das Thema der Konferenz deshalb ausgewählt, da das diesjährige Jahresmotto der KAS in Deutschland *“Die Demokratie braucht Demokraten”* lautet.

Diese wissenschaftliche Konferenz wurde von Herrn Dr. Daniel Schmücking, Landesvertreter der Konrad Adenauer Stiftung und von Herrn Gerhard Thiedemann, dem Botschafter der Bundesrepublik Deutschland eröffnet. Anschließend wurden vier Fachvorträge präsentiert und diskutiert. Die Teilnehmer und Teilnehmerinnen hatten nach jedem Vortrag die Möglichkeit Fragen zu stellen und darauf Antworten von den jeweiligen Rednern zu bekommen und auch selbst Stellung zu beziehen. Wir haben versucht so weit möglich alles in dieses Konferenzband zu integrieren, sofern es keine inhaltlichen Überlappungen gab und Stellungnahmen zum Thema passte.

Bei der wissenschaftlichen Konferenz nahmen etwas 140 Teilnehmer aus knapp 40 Einrichtungen und Institution teil, darunter zu erwähnen sind der erste Staatspräsident der Mongolei, Herr P.Ochirbat und mehrere Mitglieder des Verfassungsgerichts der Mongolei, sowie seine Exzellenz, Botschafter der BRD, Herr Gerhard Thiedemann. Des Weiteren besuchten auch Studenten, Bürgervertreter und -vertreterinnen der Stadt Ulaanbaatar, sowie anderer Provinzen die Veranstaltung.

Hiermit möchte ich der Leitung und den Dozenten, Mitarbeitern und Mitarbeiterinnen der Verwaltungsakademie der Mongolei und den Mitarbeitern und Mitarbeiterinnen der Konrad-Adenauer-Stiftung meinen Dank zum Ausdruck bringen, die diese Veranstaltung unterstützt, organisiert und finanziert haben.

Prof. Dr. Shairii Batsukh



Rede des Landesvertreters der Konrad-Adenauer-Stiftung in der Mongolei

DR. DANIEL SCHMÜCKING

Sehr geehrter Herr Botschafter,
Lieber Herr Batsukh,
Sehr geehrte Referenten,
Liebe Teilnehmer und liebe Freunde der Konrad-Adenauer-Stiftung,

ich begrüße Sie ganz Herzlich zu unserer Konferenz „Demokratie lebt vom Mitmachen - Aktive Bürgerbeteiligung in der Mongolei“.

Seit etwa drei Monaten bin ich in der Mongolei. Am heutigen Tage findet die erste große Konferenz unter mir als neuem Leiter der Konrad-Adenauer-Stiftung in der Mongolei statt. Dabei habe ich ganz bewusst das Thema politische Partizipation gewählt. Weil für mich die Frage der Bürgerbeteiligung zentral ist für die Weiterentwicklung der mongolischen Demokratie. Um es mit den Worten des Deutschen Schriftstellers Bertolt Brecht zu sagen „Wer gegen Politik ist, ist für die Politik, die mit ihm gemacht wird.“ Für mich bedeutet dies, dass in einer Demokratie die Macht vom Volke ausgeht, diese aber auch vom Volk gestaltet werden muss.

Unzweifelhaft hat sich die Mongolei in den letzten 25 Jahren sehr gut entwickelt. In einem schwierigen außenpolitischen Umfeld haben sich Politiker und Bürger gemeinsam für die Demokratie entschieden. Mit dieser Entscheidung begann für die Mongolei aber auch ein langer und steiniger Weg. Und dieser Weg ist noch lange nicht zu Ende. Demokratie ist nicht einfach. Demokratie muss erkämpft aber auch erarbeitet werden. Demokratie wird von den Bürgern gestaltet. Demokratie lebt von Beteiligung. Demokratie lebt vom Mitmachen.

Ich möchte Ihnen an drei Punkte deutlich machen, warum politische Partizipation die wichtige Frage für die Weiterentwicklung des politischen Systems der Mongolei ist:

1. Im Gegensatz zu autoritären Regierungssystemen oder Diktaturen gibt die Demokratie ihren Bürgern Freiheit, aber Sie fordert auch etwas von Ihnen ein. Nämlich die politische Beteiligung am System. Dies beginnt bei der Teilnahme an Wahlen, reicht über ziviles Engagement und geht bis hin zur aktiven Gestaltung von Politik in Parlamenten und Parteien. Wenn sich die Menschen nicht engagieren, dann wird es schwer für die Demokratie.

Mir ist wohl bewusst, dass die Parteien und Politiker in der Mongolei keinen guten Ruf haben. Das bestätigt auch die aktuelle Umfrage der Sant Maral Stiftung. Aber: Jeder in der Mongolei hat das Recht und die Chance sich politisch zu engagieren und es besser zu machen. Also: Es hilft nicht über die Politiker zu klagen, es hilft nur, sich selber politisch zu engagieren, um die eigenen Wert- und Demokratievorstellungen auch durchzusetzen.

2. Die für die Demokratie so wichtigen Elemente der „Checks and Balances“ funktionieren nur dann, wenn es kraftvolle und unabhängige Gegenspieler der Regierung gibt. Diese Rolle der Kontrolleure spielen verschiedene Akteure: kritische Medien, eine aktive Zivilgesellschaft oder die Opposition im und außerhalb des Parlaments – aber auch demokratisch strukturierte Parteien. Deren Mitglieder die Chance haben müssen, ihr Führungspersonal zu wählen und auch Rechenschaft von diesen einzufordern. Darüber hinaus sollten Parteimitglieder die Chance haben, über Inhalte zu diskutieren und über Inhalte abzustimmen. Parteien sollten eine gemeinsame weltanschauliche Richtung und eine Wertegrundlage haben, die langfristiger angelegt ist als die aktuelle Tagespolitik. Die Stärkung der innerparteilichen Demokratie ist aus meiner Sicht die nächste wichtige Stufe bei der Entwicklung der mongolischen Demokratie. Dabei geht es um transparente Spielregeln in den Parteien mit klaren Rechten und Pflichten für die Mitglieder.

3. In der Demokratie hat das Parlament die Aufgabe die Bevölkerung zu repräsentieren. Im Besten Falle spiegelt das Parlament die Zusammensetzung der Bevölkerung wider. Das heißt für die Mongolei, es sollten z.B. Frauen, Viehzüchter und auch junge Menschen ausreichend vertreten sein. Kluge Gesetze werden dann verabschiedet, wenn verschieden soziale Gruppen darüber diskutieren. Dies kann nur funktionieren, wenn sich auch die genannten Gruppen an der Politik beteiligen. Aus diesem Grund würde ich mich sehr darüber freuen, wenn wir im nächsten Parlament der Mongolei mehr Frauen, mehr Viehzüchter und mehr junge Menschen sehen würden. Wir als Konrad-Adenauer-Stiftung werden dabei gerne unterstützen.

Sie merken, dass mir das Thema am Herzen liegt. Die Konrad-Adenauer-Stiftung begleitet die Demokratie in der Mongolei seit 1993. Jede Phase der Demokratieentwicklung hatte ihre ganz eigenen Herausforderungen. Vom Staatsaufbau, über die Schaffung des Rechtsstaates, den Aufbau freier Medien bis zur Schulung von Politikern waren und sind wir ein treuer und kritischer Begleiter der mongolischen Demokratie. Offene Worte sind dabei wichtig. Nur wer die Probleme offen und ehrlich diskutiert, findet auch Lösungen. Nach drei Monaten in der Mongolei mache ich mir aber in diesem Bereich keine Sorgen. Neben sehr viel Freundlichkeit habe ich auch sehr viel Offenheit gespürt. Haben Sie dafür schon einmal vielen Dank. Deshalb freue ich mich auch sehr auf die kommenden Aufgaben, die Zusammenarbeit mit Ihnen und auf die heutige Konferenz mit einer hoffentlich kritischen und lebhaften Diskussion.

Wir haben spannende Referenten zu Gast, die zum einen Partner der Konrad-Adenauer-Stiftung sind, aber auch kritische Begleiter der mongolischen Demokratie. Politische Partizipation findet auf verschiedenen Ebenen statt. Das spiegeln auch unsere Referenten

wider, die sich in ganz unterschiedlichen Positionen für die Mongolei einsetzen und heute über ihre Bereiche sprechen werden.

Herr Batsukh wird über die Bürgerpartizipation auf kommunaler Ebene sprechen. Denn frei nach dem Zitat des früheren Sprechers des US-Repräsentantenhauses Tip O'Neill ist alle Politik lokal. Das heißt, dass die Politiker vor Ort am besten wissen, was gut für die Menschen ist. Die Frage ist, wie mehr Bürger dazu motiviert werden können sich in den Kommunen zu beteiligen.

Herr Tsogtbaatar spricht über die Bedeutung der Aufarbeitung der Vergangenheit für die heutige Demokratie. Denn nur das Wissen über die eigene Geschichte, lässt uns für die Zukunft lernen. Nur wer um die Fehler der Vergangenheit weiß, kann sie in der Zukunft vermeiden.

Frau Nomingerel thematisiert die Bedeutung der Partizipation junger Menschen. Eine Demokratie muss es immer schaffen sich selbst zu erneuern. Die Förderung junger Menschen und ihrer Ideen ist dabei essentiell. Die Mongolei ist ein junges Land, leider zeigt sich das noch nicht in der Zusammensetzung des Parlaments.

